

**"ӨЛГИЙ-УЛААНХУС-ЦЭНГЭЛ СУМ ЧИГЛЭЛИЙН 80KM ХАТУУ
ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ**

/БАЯН-ӨЛГИЙ/"

**ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ҮЕД ДЭХ
ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙН
АЖИЛЛАГААНЫ ЗААВАР**

2023-01

ГАРЧИГ

1	ЕРӨНХИЙ.....	3
2	ЗАМ БАРИЛГЫН АЖЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ	3
3	АВТО ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ҮЕД АШИГЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	9
	АВТОЗАМ, БАРИЛГЫН АЖИЛД ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТ, БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ ҮЕИЙН ГЕОДЕЗИЙН ИНЖЕНЕР, ТУСЛАХ АЖИЛЧДЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	9
	ЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР, ТЕХНИКЧ, ТУСЛАХ АЖИЛЧДЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА.....	12
	ТӨМӨР БЕТОН ХООЛОЙН БАРИХ ҮЕИЙН ТУСЛАХ АЖИЛЧДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА 14	
	ДЭВСЭГЧИЙН ТУСЛАХ АЖИЛТНУУДЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	18
	ДЭВСЭГЧИЙН ТООЛОГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	21
	ТУСЛАХ АЖИЛТНУУДЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	23
	БУЛЬДОЗЕРЫН ОПЕРАТОРЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	27
	АВТОГРЕЙДЕРИЙН ОПЕРАТОРЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	32
	АВТО АЧИГЧИЙН ОПЕРАТОРЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	36
	МЕКСЕРИЙН ЖОЛООЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	40
	АВТО САМОСВАЛЫН ОПЕРАТОРЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	45
	АСФАЛЬТ БЕТОН ДЭВСЭГЧИЙН ОПЕРАТОРЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА 51	
	ИНДҮҮНИЙ ОПЕРАТОРЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА.....	55
	АВТО ГУДРОНАТОРЫН ОПЕРАТОРЫН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	60
	ТҮЛШ, УСНЫ МАШИНЫ АШИГЛАЛТЫН ЗААВАР	65
	ТҮЛШНИЙ МАШИНЫ ЖОЛООЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	73
	УСНЫ МАШИНЫ ЖОЛООЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	79
	ГАГНУУРЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА.....	83
	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМЫН ЗАСВАРЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА.....	92
	ЦАХИЛГААНЧНЫ АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	97

1 ЕРӨНХИЙ

КАРЕК буюу Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд АХБ-наас санаачлан хэрэгжүүлж буй “КАРЕК-ийн орнуудад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах нь” техник туслалцааны төсөл (ТА 8804-REG)-ийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын инженерчлэлийн гарын авлага 2” /Зам барилгын ажлын аюулгүй байдлыг сайжруулах нь/-ыг боловсруулан Монгол хэлээр хөрвүүлэн гаргасан байдаг. Энэхүү төслийн баримт бичигт КАРЕК-ын зөвлөмжийн дагуу дээрх гарын авлагаас хэсэгчилэн эш татаж тусгалаа.

Зам барилгын ажлын үед хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан ажиллуулах зорилгоор дээрх гарын авлагыг бүхэлд нь ашиглахыг зөвлөнө.

2 ЗАМ БАРИЛГЫН АЖЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ

1) Зорилго

1. Улсын авто замын сүлжээний удирдлагын хүрээнд хийгддэг зайлшгүй шаардлагатай бөгөөд нэн чухал ажлуудын нэг нь зам барилгын ажлууд байдаг. Шинэ авто замуудыг зайлшгүй барих шаардлагатай; одоо байгаа замуудыг засварлах, эсвэл зарим тохиолдолд эгнээний тоог нэмэгдүүлэх эсвэл сайжруулалт хийх зайлшгүй шаардлагатай болдог. Гүүр, хоолой, нэг түвшний уулзвар, олон түвшний огтлолцол зэргийг барих эсвэл сэргээх; мөн хөдөлгөөний зохион байгуулалтын олон төрлийн сайжруулалт хийгддэг. Эдгээр ажлууд хийгдэх бүхий л явцад замын хөдөлгөөнийг зогсолтгүй нэвтрүүлсээр байх шаардлагатай байдаг. Тухайн авто замыг ашиглаж байх явцад авто замын ажлыг ихэвчлэн хийж гүйцэтгэдэг.

2. Авто замыг шинээр барих, эсвэл одоо байгаа авто замуудыг сэргээн засварлах ба/буюу шинэчлэх зэрэг ажлыг хийж буй хэн боловч авто замын тодорхой хэсгийг “эзлэж” ажлаа гүйцэтгэх шаардлага гардаг. Энэ нь хөдөлгөөний хэвийн нөхцөлд саад учруулж улмаар хөдөлгөөн түгжрэх, саатах, хөдөлгөөнд оролцогчдоос гомдол гарах ч бий.. Мөн энэ нь барилгын ажлын талбайд тээврийн хэрэгслүүд мөргөлдөх нөхцөл байдлыг үүсгэх магадлалтай.

3. Аливаа авто замын төслийг удирдах явцад олон талын зөрчилдөөнт асуудлууд гардаг. Энэ нь мөн эрсдэлийг удирдах хувилбаруудыг авч үзэх асуудалд хамаарна. Зам барилгын ажлын хүрээнд хөдөлгөөний түр хяналтын дараах гол зорилтууд тавигддаг байна:

- ✓ Авто зам ашиглагч болон барилгын ажлын талбайд ажиллагсдын аюулгүй байдлыг дээд зэргээр хангах,

- ✓ Тээврийн хэрэгслийн жолоочид саад учруулах болон хөдөлгөөнийг саатуулах эрсдэлийг дээд зэргээр бууруулах,
- ✓ Хөдөлгөөний түр хяналтын зохицуулалтад зарцуулах зардлыг төслийн нийт өртөгтэй харьцуулахад дүйцэж байхаар хангаж өгөх.

2) Авто замын барилгын ажлын талбайд замын хөдөлгөөний аюулгүй байдалд анхаарах нь Шинэ авто замууд барих болон одоо байгаа авто замуудыг шинэчлэн засварлах нь аюултай ажил байж болох юм. Маш чадварлаг удирдаагүй тохиолдолд авто замын барилгын ажлын талбай нь авто зам ашиглагчид төдийгүй талбайд ажиллаж буй ажилчдын хувьд ч эрсдэлтэй газар болон хувирдаг.

Ажил олгогчид ажилчиддаа аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэх үүрэгтэй. Мөн ажил олгогчид нь тэдний хяналтад байгаа ажлын талбайгаар эсвэл ойр орчмоор зорчих аливаа бусад хүмүүсийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Иймд ажил олгогч нь ахлах мэргэжилтэн болон ажилтнуудаа зохих түвшинд бэлтгэж аюулгүй байдлыг хангаж, эрсдэлийг боломжит хэмжээнд бууруулах ажлын шаардлагад нийцсэн багаж хэрэгсэл, хамгаалах хувцас, нөөцөөр хангах үүрэгтэй.

Гүйцэтгэгчид болон ажлыг хянаж буй мэргэжилтнүүдийн зүгээс:

- Өөрсдийн хариуцаж байгаа ажилчдын аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж, олон нийтийг аюулгүй, таатай зорчих нөхцлөөр хангах үүргээ ухамсарлах,
- Замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааг бүхэлд нь хариуцаж, мөн авто замын барилгын ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр ажиллах аюулгүй байдлын ажилтан томилох,
- Замын тэмдэг байрлуулах болон хөдөлгөөнийг хянахад оролцож буй бүх хүнд юу хийхийг нь болон тэдний үүрэг хариуцлагын талаар ойлгуулж таниулах,
- Замын тэмдэг байрлуулах болон хөдөлгөөнийг хянахад оролцож буй бүх хүнийг сургалтад хамруулах,
- Авто замын ажлын бусад оролцогч талуудад мэдээлэл өгөх,
- Авто замын ажлын талаар зам ашиглагч нарт мэдээлэл өгөх шаардлагатай. Урт хугацааны ажлын үед авто замын барилгын ажлын хугацааг мэдээллэх шаардлагатай ба ингэснээр зам ашиглагчид авто замын ажлын нөлөөллийг урьдчилан мэдэх боломжтой болно. Хэт их ачаалалтай үед зам ашиглагчид өөр замын чиглэлийг сонгож болох юм.

- Хувийн эзэмшлийн өмч хөрөнгийг сүйтгэхээс сэргийлж талбайг зохион байгуулах шаардлагатай.
- Энэхүү баримт бичгийн нөхцлүүдтэй сайтар танилцаж, түүнийг дагаж мөрдөх.

Ажилчид нь:

- аюулыг урьдчилан харж, анхаарал болгоомжтой байж, өөрсдийн аюулгүй байдлыг хариуцах,
- барилгын ажлын талбайд байгаа бусад хүмүүс болон зочдын аюулгүй байдалд анхаарал тавих,
- өөрсдөд нь хангаж өгсөн хамгаалах хувцсыг тогтмол өмсөж хэрэглэх, өөрсдийг нь эсвэл аливаа бусад хүмүүсийг эрсдэлд оруулахааргүй тийм л ажлын арга барилыг хэрэглэх,

Зам ашиглагчид нь:

- барилгын ажлын талбайн бүхий л дүрэм журмын шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна аливаа замын хөдөлгөөний зохицуулагчийн заавар, зөвлөгөөг биелүүлэх шаардлагатай.
- Авто зам болон хөдөлгөөний нөхцөлд тохируулан аюулгүй хурдаар зорчих.

3) Инженерүүдийн оролцоо

Авто замын барилгын ажлын талбайд замын хөдөлгөөний аюулгүй байдал болон ажилчдын сайн сайхны төлөө санаа зовдог инженер нь тод харагдацтай ойлгомжтойгоор дүрсэлсэн тэмдэгүүдийг байрлуулах, зорчих хэсгийн захыг тэмдэглэх, үндэслэлтэй хурдны хязгаарлалтыг тогтоох арга хэмжээг авна. Энэ нь тийм ч хэцүү биш бөгөөд хийхэд өндөр зардал шаардахгүй ажил. Үүнийг хийхэд энгийн горим журам мөрдөгдөх бөгөөд хэрэгжүүлэх өртөг нь маш бага билээ.

Инженерүүд замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжрах өөрчлөлтүүдийг хийх чадвартай боломжтой. Хүний эрдэнэт амийг аврах, гэмтэл бэртлээс сэргийлэх болон авто замын осол гэмтлийг инженерүүд бууруулах боломжтой. Туршлагатай инженер авто зам ашиглагчдын оронд өөрийгөө тавьж, тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгож мэдэрч, мөн түүнчлэн ажлын талбайг ажиглан харахдаа өөрөөсөө “Зам ашиглагчдад ямар ашигтай? Энэ нь тодорхой ойлгомжтой байна уу? Тэд үүнийг ойлгож харж чадахаар байна уу?” гэж асууна. Зөв хариултыг олж авснаар тухайн инженерийн чармайлт замын хөдөлгөөний аюулгүй байдалд тус нэмэр болох баталгаа болно.

4) Авто замын ажлын аюулгүй байдлыг тодорхойлох

Авто замын ажлын аюулгүй байдал гэдэг нь барилгын ажлын талбайгаар дайран өнгөрөх авто зам ашиглагчдын болон барилгын ажлын талбайд ажиллаж буй авто замын ажилчдын эрсдэлийг боломжийн хэрээр хамгийн бага төвшинд байлгахын тулд замын тэмдэг, хашлага, тусгаарлагч болон бусад аюулгүйн төхөөрөмжийг авто замын барилгын ажлын талбайд хангаж өгөх гэсэн утгыг агуулсан нийтлэг нэр томъёо юм. Ажлын талбайд аюулгүй, үр дүнтэй замын хөдөлгөөний удирдлагыг нэвтрүүлэх зорилго нь:

- аюулгүй ажиллах орчинг замын ажилчдад олгох;
- авто замын ажлын талаар ойртож буй зам ашиглагч болон явган зорчигчдод анхааруулах;
- зам ашиглагч нарт авто замын барилгын ажлын талбайгаар аюулгүй дайран өнгөрөх, тойрон гарахыг зааварлан чиглүүлэх;
- зорчиж буй олон нийтийн тав тухыг аль болох бага алдагдуулах;
- ажилд хамгийн бага саад учруулах.

Ихэнх тохиолдолд авто замын ажил нь замын хөдөлгөөнийг нэвтрүүлж буй зам дээр эсвэл маш ойр явагддаг. Хөдөлгөөний ямар ч саадгүй “ногоон төгөл” цэлгэр талын дундуур шинэ авто зам барьсан ч эцэстээ замын эхлэл болон төгсгөл нь ашиглагдаж байгаа хуучин замтай нийлэх нь гарцаагүй. Хөдөлгөөний урсгалыг аюулгүй удирдаж чиглүүлэх нь чухал бөгөөд амаргүй зорилт юм.

Тиймээс, авто зам шинээр барих эсвэл одоо байгаа замыг засварлах ажлыг хариуцсан этгээдүүд ажлаа гүйцэтгэхийн тулд ихэвчлэн авто замын хэсгийг тусгаарлаж ажлаа явуулах шаардлагатай болдог. Энэ нь авто замаар нэвтэрч буй хөдөлгөөнд ямар нэгэн байдлаар саад учруулах ба энэ байдал нь хэдэн минут, хэдэн өдөр эсвэл олон сар ч үргэлжилж болно.

Зам ашиглагч ба/эсвэл жолооч нарыг авто замаар зорчих үед цочирдуулж болохгүй гэдгийг санах нь маш чухал юм. Зарим жолооч нар шинээр бий болсон ажлын талбай руу санамсаргүйгээр орж ирж болох юм. Магадгүй тэд тухайн хурдны замаар саяхан дайрч өнгөрөхөд ямар нэгэн онцгой зүйл байгаагүй; харин авто замын ажлаас шалтгаалан нэг эгнээг нь хаасан байгааг сая олж харж болох юм. Жолооч нарт анхааруулах, мэдээлэх, чиглүүлэх зорилгоор урьдчилан анхааруулах тэмдэг болон төхөөрөмжүүдийг хангалттай тавьж өгөөгүйгээс тэд хөдөлгөөний өөрчлөгдсөн нөхцөл байдлаас хамаарч цочролд орж, улмаар осол аваар эсвэл мөргөлдөөн үүсгэх үйлдэл гаргах магадлалтай.

Барилгын ажлын талбай дахь хөдөлгөөний удирдлагын чанарт тавигдах шаардлага замын

сүлжээний бусад хэсэгт тавигдах шаардлагаас өндөр байдаг нь зам ашиглагчдыг цочирдлоос хамгаалахад чухал үүрэгтэй. Жишээ нь, ажлын талбайд эгнээний төгсгөлийг төсөллөхдөө тохирох хурд, урьдчилсан анхааруулга, эгнээний тусгаарлалт зэргийг анхааран авч үзэж, зам ашиглагчдад анхааруулах, чиглүүлэх зорилгоор сайтар төлөвлөх шаардлагатай. Эгнээний байнгын нарийсалттай хэсгүүдэд ашиглагдах замын тэмдэг болон эгнээний тусгаарлагчийг ердийн хэмжээнээс ажлын талбайд хэд дахин илүүг байрлуулах шаардлагатай болдог. Авто замын түр хугацааны ажил нь зам ашиглагчдыг “цочирдуулах” эрсдэлийг үүсгэнэ. Замын хөдөлгөөний удирдлагад энэхүү эрсдэлийг авч үзэж зайлшгүй бууруулах шаардлагатай.

5) Аюулгүй байдлыг хангах зорилгоор эрсдлийг тодорхойлж, төлөвлөх

Авто замын томоохон төсөл эхлэхээс өмнө шаардлагатай стандартын дагуу хамгийн богино хугацаанд, хамгийн аюулгүй байдлаар хамгийн их эдийн засгийн хэмнэлттэйгээр төслийг хэрэгжүүлж дуусгах талаар хэд хэдэн шийдвэрүүдийг гаргах шаардлагатай байдаг. Ажлыг төсөвт багтаан цаг хугацаанд нь дуусгах шаардлага нь хамгийн том хүчин зүйл байсаар ирсэн ба энэ нь зам барилгын ажлын үе шатны хуваарь, ашиглагдах тоног төхөөрөмж болон бусад нөөц, ажлын хугацаа зэргийг үе шаттайгаар төлөвлөх шийдвэрт хүргэдэг. Гүйцэтгэгчийн хувьд ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд аль болох цаг хугацаа болон нөөцөө хэмнэхийг эрмэлздэг. Гүйцэтгэгч нь ажлын үе шат болон шаардлагатай нөөцийн талаар маш няхуур авч үздэг.

Эдгээр анхан шатны шийдвэрүүдийг гаргасны дараа гүйцэтгэгч нь ажилд учирч болох эрсдэлүүдийг тооцож, эдгээрийг хэрхэн багасгах боломжтой талаар авч үзэх шаардлагатай. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үүднээс ажлын үе шат болон цаг хугацааны талаарх анхны шийдвэрт өөрчлөлт оруулах тохиолдолд үүсч болно. Ажлын төлөвлөгөөг олон дахин өөрчлөх үйл явц нь бүхий л авто замын төслүүдийн салшгүй нэг хэсэг юм.

Авто замын барилгын ажлын талбай дахь замын аюулгүй байдлын эрсдэл маш их байдаг. Эдгээр эрсдэлүүд нь замын хөдөлгөөн болон замын ажлын хоорондох харилцан үйлчлэл, мөн ажлаас шалтгаалан тээврийн хэрэгслүүдийн харилцан үйлчлэл зэргээс үүсдэг. Эдгээр эрсдэлүүд нь зам ашиглагчид (автомашинны жолооч, ачааны машины жолооч, автобусны жолооч, зорчигчид, мотоциклтой хүн, явган зорчигч, унадаг дугуйтай хүн) төдийгүй замын ажилчид өртдөг.

Эрдэлийг удирдахад эрсдэлийн хоёр бүрдүүлэгч хэсгийг авч үзэх шаардлагатай ба үүнд: үйл явдал болох магадлал болон үйл явдал болсон тохиолдолд түүний үр дагавар. Эрсдэлийн матрицаар эдгээр бүрэлдэхүүнийг (магадлал болон үр дагавар) авч үздэг ба энэ нь тодорхой үйл явдалтай холбоотой эрсдэлийн зэргийг тогтооход туслах үр дагавартай байна.

Ажлын талбайд эрсдэлийг удирдахад зориулсан шаталсан дамжлагатай энгийн аргыг ашиглаж, ЗХЗБТ гаргах боломжтой болно. Эхний шат нь хийгдэх гэж буй төслийг авч үзэж, шаардлагатай нөөц болон ажлын үе шатны талаар шийдвэр гаргах юм. Авто замын төслийн төрлөөс хамаарч энэ шатанд маш олон төрлийн асуудлууд гарч ирнэ. Олон километр улсын чанартай замыг хоёр дахин өргөсгөх ажлын томоохон төслийн хувьд бага хурдны хязгаартай орон нутгийн замд хагарал нөхөх ажлыг бодвол илүү нарийн анхаарах шаардлагатай болно.

Талбайд эрсдэлийн үнэлгээ тогтоох нь дараагийн шат юм. Энэхүү үнэлгээ нь эрсдэлийг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл багасгахын тулд хөдөлгөөний зохицуулалт хамгаалалтын түвшин болон шаардагдах тэмдгийн тоо хэмжээ зэргийг тогтооход ач холбогдолтой.

Гуравдахь шат нь талбай дахь тодорхой эрсдэлийг авч үзэх явдал юм. Талбай нь өндөр эрсдэл бүхий талбай гэж үнэлэгдэж болох хэдий ч яг ямар эрсдэлүүдийг урьдчилан мэдэх боломжтой байна вэ? Эдгээрийн жагсаалтыг гаргах нь нэн чухал бөгөөд эрсдэл нэг бүрийг тодорхой болгосон эсэхийг нягтлан үзэх.

Урьдчилан мэдсэн эрсдэлүүдийг жагсаасан даруйд тэдгээр эрсдэлүүдийг багасгах бүхий л боломжуудыг судлах ажил эхэлнэ. Техник хэрэгслийн эрэмблэл энэ шатанд хэрэг болох ба энэ нь барилгын ажлын талбайд аюулгүй байдлыг хянах олон хувилбаруудыг санал болгодог. Техник хэрэгслийн эрэмблэлийн пирамид нь боломжуудыг санал болгох хэдий ч эрсдэлийг хянах ямар аргуудыг хэрэглэх вэ гэдэг шийдвэрийг гаргах шаардлагатай болно.

Чиглэл тодорхой болмогц эдгээр арга хэмжээнүүдийг багтаасан ЗХЗБТ-г боловсруулах ба үүнд тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бүхий л тэмдэг болон хөдөлгөөний хяналтын төхөөрөмжүүдийг тодорхой харуулсан байна. Ажил эхлэхээс өмнө ЗХЗБТ-г авто замын удирдах газраар баталгаажуулах шаардлагатай ба цаг хугацаанд нь ажлыг хийхийн тулд төлөвлөгөөг өөрийг нь онвчтой, цагт нь гаргахад анхаарвал зохино.

3 АВТО ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ҮЕД АШИГЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Автозам, барилгын ажилд геодезийн хэмжилт, боловсруулалт хийх үеийн геодезийн инженер, туслах ажилчдын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Геодезийн инженер, туслах ажилчид нь дараах шаардлагыг хангасан байна:
 - Инженер нь 25-аас дээш насны, мэргэжлийн үнэмлэх буюу дипломтой, ажлын дадлага туршлагатай хүн байх ба туслах ажилчин нь 18-аас дээш насны, ижил төрлийн ажил гүйцэтгэж байсан туршлагатай хүн байна.
 - Инженер, туслах ажилчид нь ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Геодезийн инженер, туслах ажилчид нь ажил олгогчоос тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал, ажлын бээлий, хамгаалалтын дохиоллын хантааз (гэрэл ойлгогчтой хантааз), Нүдний шил, Амны хаалт, Ажил явагдаж байгаа газарт хамгаалалтын малгай (каска)-тай ажиллана.
3. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд геодезийн инженер, туслах ажилчид нь компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.
4. Геодезийн инженер, туслах ажилчдын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Багаж хэрэгслийг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Туслах ажилчид нь зөвхөн инженерийн даалгаж өгсөн ажлыг гүйцэтгэнэ;
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байна.

5. Геодезийн инженер болон туслах ажилчид нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

6. Ажил эхлэхийн өмнө геодезийн инженер болон туслах ажилчин нь дараах шаардлагыг хангасан байна:
- Удирдаж буй хүнээс ажил гүйцэтгэх заавар, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
 - Ажлыг аюулгүй гүйцэтгэх болон багаж хэрэгсэлтэй аюулгүй ажиллах арга барил эзэмшсэн, ажлын байрны аюулгүй ажиллагааны шаардлагуудыг сайн мэддэг байх ба энэ талын мэдлэгээ удирдах ажилтандаа шалгуулж, бие даан ажиллах зөвшөөрөл авсан байна;
 - Ажлын хувцас, хэрэглэлийг бүрэн, зөв өмссөн байна;
 - Ажил эхлэхийн өмнө хэрэглэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгана.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

7. Геодезийн инженер, туслах ажилчид нь ажлын үеэр багаж төхөөрөмжтэй харьцахдаа дараах шаардлагыг ханган ажиллана:
- Багаж, тоног хэрэгслийг тээвэрлэхдээ түгжээ цоожийг сайтар үзэж шалгаад, хуй саванд хийж ,зориулалтын оосор бариулиас барин ачих буюу буулгана;
 - Электрон-тахеометрийг хайрцганд зөв байрлуулж түгжээг нэг бүрчлэн түгжээд, оосроор нь үүрч зөвхөн нэг хүн авч явна. Дамжлахгүй;
 - Штативыг оосроор нь, хөлийг нь дээш харуулж үүрэх буюу хэрэв нүхэн бариултай бол түүнээс барина;
 - Нивелирийг оосроос нь барьж, савахгүй авч явна;
 - Рейкийг хурааж эвхээд зориулалтын хуй уутанд хийж явна;
 - Ган туузаар хэмжилт хийх үед ажлын бээлийтэй ажиллана;
 - Ажлын шаардлага хангахгүй багаж хэрэгслийг ашиглах, хэмжилт хийхийг хориглоно;
 - Гадаслагаа хийх үед ажлын багаж хэрэгслийг бие биедээ шидэж дамжуулахыг хориглоно;

- Геодезийн багажийг зориулалтын газар байрлуулахдаа давхарлаж хураахыг хориглоно.
- 8. Геодезийн инженер, туслах ажилчид нь ажлын үеэр дараах шаардлагуудыг ханган ажиллана:
 - Ажил руу явахдаа үйлчилгээний машинаар явах бөгөөд бууж, суухдаа унах, халтирах, гар хөлөө машины хаалганд хавчуулахаас болгоомжилно;
 - Далан дээр ажиллахдаа машин механизмын хөдөлгөөнөөс болгоомжилж, анхааруулах гэрэл ойлгогчтой хантааз өмсөнө;
 - Шороон шуургатай үед ажиллахдаа нүдний хамгаалалт, амны хаалтыг заавал зүүнэ;
 - Өндөр далан, ухмалаас үсэрч буухыг хориглоно;
 - Далангийн нарийн тэгшилгээний үед грейдэрээс бууж суухдаа хутга болон дугуйнд хөл гараа гэмтээхээс болгоомжлон, анхаарал сэрэмжтэй ажиллана;
 - Грейдрийн өмнө, хойно гарч хэмжээ тавьж өгөхдөө грейдерт 10м-ээс ойр зайд ойртохыг хориглоно;
 - Гадас болон хадаас хадахдаа хуруу гараа лантуугаар цохиж, бяцлахаас болгоомжлон анхааралтай ажиллана;
 - Гадас бэлтгэх үед сүхийг ишнээс сугарахгүй байхаар бэхэлж, шалгана;
 - Хөрөө болон сүх, багаж хэрэгслийг хоорондоо шидэж дамжуулахыг хориглоно;
 - Машин механизмын кабинд орох, асаах, хөдөлгөхийг хориглоно;
 - Машин механизмын сүүдэрт суухыг хориглоно;
 - Ажлын явцад гар утас хэрэглэх, чихэвчний хөгжим сонсох зэрэг шалтгаанаар анхаарлаа сарниулахыг хориглоно;
 - Тороосыг татахдаа ажлын бээлий өмссөн байх ба тороос тасарч харвахаас сэргийлж, болгоомжтой ажиллана;
 - Дэвсэгчийн хаалт хамгаалалт, тавцан дээр зогсохыг хориглоно;
 - Хэмжилтийн явцад тухайн талбайн хязгаарыг тэмдэгжүүлж ажиллана;
 - Хэмжилтэнд гарах, талбайгаас буухдаа тээврийн хэрэгслийг түр зогсоолд байрлуулна.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

- 9. Ажил дуусахад геодезийн инженер болон туслах ажилчид нь дараах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй:

- Ажлын багажны бүрэн бүтэн байдлыг шалгана;
- Зөөж, тээвэрлэх үед зориулалтын сав хайрцганд хийж, унаж эвдрэхээргүй байдлаар авч явна;
- Зориулалтын биш тээврийн хэрэгсэлд сууж явахыг хориглоно.
- Хэмжилтийн даамал буюу хариуцсан инженерт ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч, ажлын үр дүнг мэдээлэн, зөвшөөрсний дараа ажлаас бууна.

Лабораторийн инженер, техникч, туслах ажилчдын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжын шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Лабораторийн инженер, техникч, туслах ажилчид нь дараах шаардлагыг хангасан байна:
 - Инженер болон техникч нь чиглэлийн мэргэжлийн диплом буюу үнэмлэхтэй, ажлын дадлага туршлагатай, дээд боловсролтой хүн байна;
 - Туслах ажилчид нь ижил төрлийн ажил эрхэлж байсан туршлагатай хүн байна;
 - Инженер, техникч, туслах ажилчид нь объектын эмчийн урьдчилан сэргийлэх (ажилд ороход) үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байна;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
3. Лабораторийн ажилчин нь ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсч, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал, ажлын бээлий, хамгаалалтын дохиоллын хантааз (гэрэл ойлгогчтой хантааз), Нүдний шил, Амны хаалт
 - Ажил явагдаж байгаа газарт хамгаалалтын малгай (каска)-тай ажиллана.
4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд лабораторийн ажилчид нь компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.

5. Лабораторийн ажилчдын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Багаж хэрэгслийг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Зөвхөн лабораторийн инженерийн даалгаж өгсөн ажлыг гүйцэтгэнэ;
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Лабораторийн ажилчид нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө геодезийн туслах ажилчин нь дараах шаардлагыг хангасан байна:
 - Удирдаж буй хүн(инженер)-ээс ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
 - Ажлын хувцас, гутал өмсөнө;
 - Ажлын багаж, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгана.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

8. Лабораторийн инженер, техникч болон туслах ажилчид нь ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Ажил эхлэхийн өмнө хэрэглэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгана;
 - Ажил руу явахдаа үйлчилгээний машинаар явах бөгөөд бууж, суухдаа унах, халтирах, гар хөлөө машины хаалганд хавчуулахаас болгоомжилно;
 - Далан дээр ажиллахдаа машин механизмын хөдөлгөөнөөс болгоомжилж анхааруулах гэрэл ойлгогчтой хантааз өмсөнө;
 - Шороон шуурга тавьж байгаа үед нүдний хамгаалалт, амны хаалтыг заавал зүүнэ;
 - Өндөр далан, ухмалаас үсэрч харайж буухыг хориглоно;
 - ЦБСуурин дээр нягт үзэхдээ гэрэл ойлгогчтой тэмдэг урд хойноо тавина;
 - Элсэн конусаар нягт үзэхдээ лантуу болон цүүц зэрэг багажаар гар хуруугаа гэмтээхээс болгоомжилно;
 - Машин механизмын кабинд орох, асаах, хөдөлгөхийг хориглоно;

- Машин механизмын сүүдэрт суухыг хориглоно;
- Ажлын явцад гар утас болон чихэвчний хөгжим сонсох зэрэг шалтгаанаар анхаарлаа сарниулахыг хориглоно;
- Дэвсэгчийн хаалт хамгаалалт, тавцан дээр зогсохыг хориглоно;
- Ажлын багажаа бие биерүүгээ шидэхийг хориглоно.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

9. Ажил дуусахад лабораторийн ажилчид дараах зүйлсийг хийх үүрэгтэй:

- Ажлын багажны бүрэн бүтэн байдлыг шалгана;
- Зөөж тээвэрлэх үед зориулалтын сав хайрцганд хийж, унаж эвдрэхээргүй байдлаар авч явна;
- Зориулалтын биш тээврийн хэрэгсэлд сууж явахыг хориглоно.

Лабораторийн туслах ажилчид нь техникч буюу хариуцсан инженерт ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч ажлыг хүлээлгэн өгч зөвшөөрсөний дараа ажлаас бууна.

Төмөр бетон хоолойн барих үеийн туслах ажилчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамж, ХАБЭА-н менежментийн системийн үнэлгээний OHSAS 18001 стандартуудын шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Туслах ажилчнаар 18-аас дээш насны, ижил төрлийн ажил эрхэлж байсан туршлагатай эрчүүд ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн өдөр тутмын үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байх;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж,

- аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Туслах ажилчин ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох дараах үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Дуу шуугиан,
 - Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон бусад хортой хүчин зүйл нэмэгдэх,
 - Машин, механизм болон эд ангиудын хөдөлж буй хэсгүүд,
 - Ойр орчимд ажиллаж буй хүмүүс.
 3. Үйлдвэрлэлийн бохирдол болон механик нөлөөнөөс хамгаалахын тулд машинист ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал, ажлын бээлий, өвөл ажиллахад зориулан дулаалсан чихэвч, ажлын хувцас, эсгий гутал.
 4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд нийт ажилчид компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
 5. Ажилчид нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

6. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
 - Удирдаж буй инженертээ ажлыг аюулгүй гүйцэтгэх талаарх мэдлэгээ шалгуулж, үүрэг даалгавар авах бөгөөд ажлын заавар, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
 - Тавьж өгсөн ажлын хувцас, гутлыг бүрэн өмсөнө.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Төмөр бетон хоолойн суурийн нүх ухахдаа аюулгүй ажиллагааны дараах шаардлагуудыг ханган ажиллана:
 - Суурийн нүхийг механизмаар гүйцэтгэж байх үед түүний ойр орчимд хүн зогсохыг хориглоно.

- Суурийн нүхийг шалгахдаа дуранг механизмын хөдөлгөөнөөс зайтай байхаар байрлуулах ба түвшин шалгах болон гар тэгшилгээ хийх үед механизмыг суурийн нүхнээс гаргаж зогсооно.
 - Механизмын оператор нь авто ачигч, бульдозер, эксковаторын операторын ажлын байрны аюулгүй ажиллагааны шаардлагуудыг ханган ажиллана.
 - Гар тэгшилгээг хийх үед туслах ажилчид нь ажлын хувцас өмссөн байх ба гар багажаар /хүрз гэх мэт/ тэгшилгээ хийнэ.
8. Төмөр бетон суурийг услах үеэр дараах шаардлагуудыг хангаж ажиллана:
- Усны машин ул суурийг усалж байх үед аюулгүй байдлыг хангах үүднээс талбайд хүн зогсохыг хориглоно.
 - Индүүний кабинд гадны хүн суух, мөн явж байх үед нь хүн ойртох, бууж суухыг хориглоно.
 - Машин механизмын жолооч, операторын аюулгүй ажиллах зааварчилгааг Тухайн машины жолоочийн ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаанаас дэлгэрэнгүй үзнэ.
9. Хэв хашмал угсрах, арматур боох үед суурийн хэвийг полигон дээр урьдчилж бэлдэх ба хэв хашмал хийж байгаа ажилчид ажлын хувцас өмсч, гар багажаар ажлыг гүйцэтгэнэ. Ажлын багажийг бие бие рүүгээ шидэхийг хориглоно. Мөн гар багажаар ажил гүйцэтгэхдээ анхаарал болгоомжтой байж, хөл гараа гэмтээхгүй байх арга хэмжээг авч ажиллана.
10. Төмөр бетон хоолойн суурийн бетон цутгах үед аюулгүй ажиллагааны дараах шаардлагыг ханган ажиллана:
- Хэрэв өндөр далантай бол мексерээс зуурмаг шууд бэлдсэн сууринд бууж байхаар модон эсвэл туузан төмрөн конвейроор дамжуулна.
 - Далангийн ирмэг нурж унахаас сэргийлж мексерийг далангийн ирмэгээс зайтай байрлуулна.
 - Туслах ажилчид бетоны ажилд зориулагдсан ажлын хувцас өмссөн байна. Үүнд усны гутал болон резинэн бээлий байна. Ажлын явцад ажлын багаж хэрэгслийг ажилчид нь хоорондоо шидэж дамжуулах, мөн ноцолдохыг хориглоно.
11. Төмөр бетон хоолойн хэсэглэл угсрах үед дараах шаардлагуудыг ханган ажиллана:
- Арматур тасдах үед ажилчид нь ажлын хувцас заавал өмссөн байх ба гар, хуруугаа тайрч гэмтээхээс урьдчилан сэргийлж ажиллана.
 - Арматур матах үед болон ажлын талбай дээр багаж, хэрэгслээ шидэж дамжуулах, ноцолдохыг хориглоно.

- Цутгалтын үед вибраторыг сайн тавих ба зуурмаг үсрэхээс хамгаалж хамгаалалтын шил зүүнэ.
 - Бетоны хэвийг цутгахын өмнө сайтар тосолсон байна.
 - Ажилд бэлэн болсон, бат бэх нь хангагдсан кольцоог ачиж тээвэрлэхдээ суурин дээр нь сайтар тросс болон татлагаар бэхэлж, бэхэлсэн ажилчид холдсоны дараа кольцоог дээш өргөж ачна.
 - Талбай дээр ирээд кольцоог буулгахдаа мөн адил сайтар бэхэлж, өргөх кольцооноос холдсоны дараа краны жолоочид өргөх дохиог өгч газар буулгана.
 - Буулгасны дараа бэхэлгээг авч дараагийн кольцоог мөн адил буулгана.
 - Кольцоог суурин дээр кранаар зөөж авчрах ба өргөх, буулгах үед аюулгүй ажиллагааны зааварчилгааны заалтуудыг чанд баримтална. Буулгах явцад кольцоонд хүн дарагдахаас сэргийлж, краны сумыг аажим буулгана.
 - Кольцоог нэг захаас нь эхэлж өрөх ба өнхрөхөөс сэргийлж 2 талаас нь лоом эсвэл хатуу биетээр тулж өгнө. Өрж байх явцад сонор сэрэмжтэй ажиллана.
12. Төмөр бетон хоолойн хүзүүвчний залгаас хийх, тулаас бетон хийх үед тавигдах шаардлагууд:
- Залгаас хийх торыг кольцооны тойргийн уртын дагуу зориулалтын багажаар тайрна.
 - Тайрах үед хуруу, гараа гэмтээхээс сэргийлнэ.
 - Тулаас бетоныг цутгах үед бетон цутгах үеийн болон талбайн аюулгүйн ажиллагааны дүрэм журмыг мөрдөнө.
13. Төмөр бетон хоолойнд ус тусгаарлах материал түрхэх үед аюулгүй ажиллагааны дараах шаардлагуудыг ханган ажиллана:
- Битумыг хайлуулахдаа тусгай саванд хийн галлаж хайлуулна.
 - Гал алдахаас сайтар сэргийлнэ.
 - Ус тусгаарлах материал түрхэх үедээ ажлын хувцас өмссөн байх ба түлэгдэж, гэмтэхээс урьдчилан сэргийлнэ.
14. Төмөр бетон хоолойн буцаан дүүргэлт хийхдээ дараах шаардлагуудыг хангаж ажиллана:
- Буцаан дүүргэлтийг хийх үед ажилчид ажлын хувцас өмссөн байх ба гар багаж ашиглана.
 - Шороог үе үеэр авч тараахдаа бээлий заавал өмссөн байна.
 - Индүүгээр явах үед зам дагуух том чулууг зайлуулах ба замд нь хөлөө дайруулахаас сэргийлнэ.
15. Төмөр бетон хоолойн чулуун бэхэлгээ хийхдээ дараах шаардлагуудыг ханган ажиллана:

- Чулуун өрлөгийг хийхдээ урьдчилж чулуугаа бэлдэх ба ажил эхлэхээс өмнө ажилчид нь ажлын хувцас, бээлий өмссөн байна.
 - Чулууг гараар бэлдэх явцад аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ба ажилчид нь гар, хөлөө болон гэмтэж бэртээхээс урьдчилан сэргийлнэ.
16. Дохионы шон суулгахдаа аюулгүй ажиллагааны дараах шаардлагуудыг ханган ажиллана:
- Шонгийн нүхийг ухахдаа гар багаж ашиглана.
 - Ажилчид нь ажлын хувцас болон хамгаалах хэрэгслийг бүрэн авч ажилд гарна.
 - Дохионы шонг инженерийн зааврын дагуу заасан газар суурилуулна.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

17. Ажлын үеэр багаж хэрэгсэлд ямар нэг эвдрэл гэмтэл, зөрчил дутагдал, осолд дөхөлт илэрвэл удирдах ажилтандаа мэдэгдэх бөгөөд багаж хэрэгсэл, техникийг бүрэн бүтэн байдалд орохоос нааш хэрэглэж болохгүй.
18. Хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учирвал компанийн Үйлдвэрлэлийн ослыг судлах бүртгэх дүрмийн дагуу ажиллана.
19. Гал гарсан үед ажилчид нэн даруй гал унтраагуул болон гарын доорх элс, шороо, брезент гэх мэт зүйлээр галыг унтраах арга хэмжээ авч, даамал болон бусад удирдлагадаа мэдэгдэнэ.
- Галыг усаар тургиж унтраах гэж оролдож болохгүй. Галыг өөрөө унтраах боломжгүй бол галаас хамгаалах алба дуудна.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

20. Ажил дуусахад ажилтнууд дараах үүрэгтэй:
- Ашигласан машин механизмыг зогсоолд тавина;
 - Багаж хэрэгслийг хурааж, зориулалтын хадгалах газарт эмх цэгцтэй тавина;

Хариуцсан инженерт ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгнө.

Дэвсгэчийн туслах ажилтнуудын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Туслах ажилчин нь 18-аас дээш насны, ажилласан тодорхой туршлагатай эрчүүд ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн өдөр тутмын үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байх;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Туслах ажилчин нь ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Ажил эхлэхийн өмнө ажлын талбарт үзлэг хийж аюулгүй эсэхийг шалгах
 - Дэвсэгчийг ажиллаж байгаа үед эд анги руу нь гар хуруу, багаж хүргэх, засвар үйлчилгээ хийхийг, хориглоно.
 - Автосамосвал дэвсэгчийн бункерт хольцыг буулгах үедээ арын порчкийг авч хольц чөлөөтэй буух нөхцлийг бүрдүүлээгүй тохиолдолд дэвсэгчийн бункерт орох эсвэл машины тэвшин дээр гарахыг хориглоно.
 - Машины тэвшин дээр үлдсэн үлдэгдэл хольцыг буулгахдаа зориулалтын багажаар буулгана.
 - Автосамосвалын ухрах, буулгах, урагш хөдлөх үед хөдөлгөөнд нь саад болохгүйгээр анхаарал болгоомжтой ажиллана.
 - Хөвөөг манах үед автосамосвал, индүү, дэвсэгчийн хөдөлгөөнөөс болгоомжилж ажиллах.
3. Үйлдвэрлэлийн бохирдол болон механик нөлөөнөөс хамгаалахын тулд туслах ажилчин нь ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал, ажлын бээлий, хамгаалалтын дохиоллын хантааз (фосфортой хантааз).

Ажил явагдаж байгаа газарт хамгаалалтын малгай (каска)-тай ажиллана.
4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд туслах ажилчин нь компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.
5. Туслах ажилчны өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Зөвхөн инженерийн даалгаж өгсөн ажлыг гүйцэтгэнэ;

- Ажлын байранд эмх цэгцтэй байж, хог, цас, хальтиргаа үүсгэх аюултай бусад бүх зүйлийг цэвэрлэнэ.
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Туслах ажилчин нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө туслах ажилчин нь дараах шаардлагыг хангасан байна:
- инженерээс ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
 - Ажлын хувцас, гутал өмсөнө;
8. Үүрэг даалгавар авсны дараа туслах ажилчин нь дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- Хөдөлмөрийн багаж хэрэгслээ бүрэн бүтэн байдлыг хангаж, цэвэрлэсэн байна.
 - Дэвсэгчийн бункерийг цэвэрлэнэ.
 - Суурийн доод үе дээр байгаа хог новш гадны зүйлийг зайлуулна.
9. Машинистууд аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн тохиолдолд ажил гүйцэтгэж болохгүй:
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үед
 - Эрүүл мэндийн шалтгаанаар ажил үүрэг гүйцэтгэх чадваргүй болсон үед
 - Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл бүрэн гүйцэд биш үед ажиллахыг хориглоно.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

10. Дэвсэх ажлын үед ямар нэгэн техник хэрэгсэл гэмтсэн тохиолдолд уг техникээс 5-аас доошгүй метрийн зайд холдож ажлыг бүрэн зогсоож хариуцсан инженер даамалд мэдэгдэнэ.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

11. Ажил дуусахад туслах ажилчин нь дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- a. Дэвсэгчийг цэвэрлэж дараагийн өдрийн ажилд бэлдэнэ.
 - b. Ажлын талбарыг цэвэрлэж, багаж хэрэгслийг цэвэрлэж, зориулалтын газарт нь хадгалуулна.

Дэвсэгчийн даамал буюу дэвсэгчийн ажиллагааг хариуцсан инженер механикт ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч зөвшөөрсөний дараа ажлаас бууна.

Дэвсэгчийн тоологчийн ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Тоологч нь 18-аас дээш насны, ажилласан тодорхой туршлагатай эрчүүд ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн өдөр тутмын үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байх;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Үйлдвэрлэлийн бохирдол болон механик нөлөөнөөс хамгаалахын тулд туслах ажилчин нь ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал, ажлын бээлий, хамгаалалтын дохиоллын хантааз (фосфортой хантааз).

Ажил явагдаж байгаа газарт хамгаалалтын малгай (каска)-хамгаалалтын нүдний шилтэй ажиллана.
3. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд тоологч нь компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.
4. Тоологчийн өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Зөвхөн даамлын даалгаж өгсөн ажлыг гүйцэтгэнэ;
 - Ажлын байранд эмх цэгцтэй байж, хог, цас, хальтиргаа үүсгэх аюултай бусад бүх зүйлийг цэвэрлэнэ.
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.

5. Тоологч нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

6. Ажил эхлэхийн өмнө тоологч нь дараах шаардлагыг хангасан байна:
инженерээс ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
— Ажлын хувцас, гутал өмсөнө;
7. Үүрэг даалгавар авсны дараа дэвсгэчийн тоологч нь дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
— Хөдөлмөрийн багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, цэвэрлэсэн байна.
— Дэвсгэчийн бункерыг цэвэрлэнэ.
— Суурийн доод үе дээр байгаа хог новш, гадны зүйлийг зайлуулна.
8. Тоологч аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн тохиолдолд ажил гүйцэтгэж болохгүй:
— Согтууруулах ундаа хэрэглэсэн үед;
— Эрүүл мэндийн шалтгаанаар ажил үүрэг гүйцэтгэх чадваргүй болсон үед;
— Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл бүрэн гүйцэт биш үед ажиллахыг хориглоно.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

9. Тоологч нь ажил гүйцэтгэх үеэр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дараах шаардлагуудыг ханган ажиллана:
— Ажил эхлэхийн өмнө ажлын талбарт үзлэг хийж, аюулгүй эсэхийг шалгана;
— Машины тэвшин дээр үлдсэн үлдэгдэл хольцыг буулгахдаа зориулалтын багажаар буулгана;
— Автосамосвалын ухрах, буулгах, урагш хөдлөх үед хөдөлгөөнд нь саад болохгүйгээр анхаарал болгоомжтой ажиллана;
— Хөвөөг манах үед автосамосвал, индүү, дэвсгэчийн хөдөлгөөнөөс болгоомжилж ажиллана;
— Тоологч нь дохио өгч машиныг чиглүүлэхдээ гэрэл ойлгогчтой дохиур, гар чийдэнтэй байна;
- 15.1. Машинд зогсох дохио өгмөгцөө машин болон дэвсгэгчээс 5м-ээс доошгүй зайнд холдож аюул осолгүй байдлыг хангана.
10. Дэвсгэчийн тоологчид ажил гүйцэтгэх үед дараах зүйлсийг хориглоно:
— Дэвсгэчийг ажиллаж байгаа үед эд ангид гар хүргэх, багаж хүргэх, засвар үйлчилгээ хийхийг хориглоно;

- Автосамосвал дэвсэгчийн бункерт хольцыг буулгах үед арын порчикийг авч хольц чөлөөтэй буух нөхцлийг бүрдүүлээгүй тохиолдолд дэвсэгчийн бункерт орох эсвэл машины тэвшин дээр гарахыг хориглоно;

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

11. Дэвсэх ажлын үед ямар нэгэн техник хэрэгсэл гэмтсэн тохиолдолд уг техникээс 5-аас доошгүй метрийн зайд холдож ажлыг бүрэн зогсоож хариуцсан инженер, менежерт мэдэгдэнэ.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

12. Ажил дуусахад туслах ажилчин нь дараах зүйлсийг хийх үүрэгтэй:

- Дэвсэгчийг цэвэрлэж дараагийн өдрийн ажилд бэлдэнэ.
- Ажлын талбарыг цэвэрлэж, багаж хэрэгслийг цэвэрлэж, зориулалтын газарт нь хадгалуулна.

Дэвсэгчийн менежер буюу дэвсэгчийн ажиллагааг хариуцсан инженер механикт ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч зөвшөөрсөний дараа ажлаас бууна.

Туслах ажилтнуудын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү заавар нь улсаас аюулгүй байдал, эрүүл ахуйд тавигддаг шаардлага, асфальт бетон болон хар зуурмагаар боловсруулсан бусад материалаар замын хучилт тавих, засах ажилд зориулсан хууль, эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн боловсруулагдсан болно.

Аюулгүй байдлын ерөнхий шаардлага

1. 18-аас дээш насны, асфальт бетон хучилттай зам барих ажил гүйцэтгэх мэргэжлийн дадлага эзэмшиж, бэлтгэл хангасан эрчүүд бие даан ажиллаж эхлэхээсээ өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Ажлыг хэвийн гүйцэтгэж чадах эсэхийг магадлах үүднээс эмчийн анхны заавал (ажилд ороход) болон тогтмол (хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад) үзлэг (шалгалт)-т орох;
 - Ажлыг гүйцэтгэх аюулгүй арга, аргачлалд суралцах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах, ажлын байранд дадлагажих, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагуудын тухай мэдлэгээ шалгуулах.

2. Асфальт бетоны ажилчин нь ажлын онцлогоос шалтгаалсан үйлдвэрлэлийн дараах аюултай болон хортой хүчин зүйлийн нөлөөнөөс өөрийгөө хамгаалахад чиглэсэн хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг хангах үүрэгтэй:
 - Ажлын бүст тоосжилт ихсэх, агаарт хий цацагдах;
 - Тоног төхөөрөмжийн гадаргын температур ихсэх;
 - Чичиргээ ихсэх;
 - Машин болон түүний хөдөлгөөнт хэсгүүд хөдлөх.
3. Механик нөлөө болон бохирдолтоос хамгаалахын тулд асфальт бетоны ажилчин ажил олгогчоос тавьж өгсөн хөвөн даавуун материалтай ажлын хувцас, арьсан гутал, таарсан хос бээлий, хөвөн дээр брезентээр хийсэн өвдөгний боолтыг хэрэглэх үүрэгтэй. Дээрх материал байхгүй бол хөвөн материалтай комбинзон, арьсан ботинка буюу түрийтэй гутал, хос бээлий байна.

Үйлдвэрлэлийн талбайд байрлаж байхдаа асфальт бетоны туслах ажилчид хамгаалах төмөр малгай, харин бутлуурын алхтай хэсэгт ажиллахдаа хамгаалалтын нүдний шилтэй ажиллах ёстой.
4. Үйлдвэрлэлийн талбайд, үйлдвэрлэлийн буюу ердийн байрлалд, ажлын хэсэг буюу ажлын байранд асфальт бетоны ажилчин тухайн байгууллагад мөрдөгддөг Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг биелүүлэх үүрэгтэй.

Дээрх газруудад согтуу ажилчин буюу гадны хүнийг нэвтрүүлэхийг хориглоно.
5. Асфальт бетоны ажилчны өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:

Жижиг механик хэрэгсэл, машин, механизмын зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;

Ажлын байранд эмх цэгцтэй байх, ажлын байран дахь хог, цас, тошин (наледь)-г цэвэрлэх, бараа материал болон машин механизмыг хадгалах горимыг зөрчихгүй байх;

Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Асфальт бетоны ажилчин нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд удирдлага болон дээд удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй байдлын шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө асфальт бетоны ажилчин дараах шаардлагыг хангасан байна:
 - Ажлын удирдлагчдаа аюулгүй ажиллах арга барилын талаарх мэдлэгтэй гэдгээ шалгуулах;

- Ажлын хувцас, гутал, дохиоллын (фосфортой) хантааз, хамгаалалтын малгай өмсөх;
 - Инженер болон бусад удирдах ажилтнаас үүрэг даалгавар авах, гүйцэтгэж буй ажлынхаа онцлогийн талаар ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах;
 - Замын тэмдэг болон хамгаалалтыг барих газрыг тодорхойлох.
8. Ажлын хэсгийн даамал, менежер эсвэл инженер, эсвэл удирдах ажилтнаасаа үүрэг даалгавар авсны дараа асфальт бетоны ажилчин дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- Ажлын байр болон түүнд нэвтрэх гарцуудыг аюулгүй байдлын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгах, хамгаалах болон урьдчилан сэргийлэх тэмдгүүд байгаа эсэхийг шалгах;
 - Ажил гүйцэтгэхэд шаардлагатай технологийн тоног төхөөрөмж болон багаж хэрэгслийг бүрдүүлж, тэдгээрийн аюулгүй байдлын шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана.
9. Асфальт бетоны ажилчин аюулгүй байдлын шаардлагууд дараах байдлаар зөрчигдсэн тохиолдолд ажил гүйцэтгэхийг хориглоно:
- Үйлдвэрээс өгсөн зааварт заасан ажилчин буюу багаж хэрэгслийн хамгаалалтын хэрэгсэл, технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл эвдэрсэн байвал;
 - Ажил, үйлдвэрлэл явагдах газарт хамгаалалт буюу анхааруулах тэмдэг байхгүй бол;
 - Ажлын байр болон түүн рүү нэвтрэх гарцуудад гэрэлтүүлэг хангалтгүй, эсвэл хэт их байвал.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчлүүдийг асфальт бетоны ажилчин өөрийн хүчээр арилгахыг эрмэлзэх ба боломжгүй нөхцөлд бригадын ахлагч, эсвэл ажлын удирдагчдаа мэдэгдэж засуулах үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй байдлын шаардлагууд

10. Ажлын үеэр асфальт бетоны ажилчин дараах үүрэгтэй:
- Ажлын байранд эмх цэгцтэй байх, үйлдвэрийн хаягдал, эд материал, янз бүрийн зүйлсийг ажлын байранд оруулж, бөөгнөрүүлэхгүй байх;
 - Ажлын байрыг хамгаалж, тохирох замын тэмдгүүдээр тэмдэглэх: хориглох тэмдэг – “орох хориотой”, “хурдны дээд хязгаар”, анхааруулах тэмдэг – “замын ажил”.
Хоногийн харанхуй үед дохио өгөх гэрэлтүүлгийг асаах.

- Хоногийн харанхуй цагуудад ажлын байранд гэрэлтүүлэг асаах. Гэрэлтүүлгийг хааж халхлах зүйлсийг зайлуулж, гэрэлтүүлэгт саад болохооргүй байрлуулна.
11. Үйлдвэрийн материал болон хаягдлууд ажил гүйцэтгэх талбайд байвал асфальт бетоны ажилчин тэднийг замын засвар хийгдэж буй, эсвэл шинээр тавигдаж буй хэсэгтэй нийлсэн хажуу буюу захын хэсэгт тавих үүрэгтэй. Материал, хаягдлыг замын хажуу талд тавихдаа тэдгээрийн өмнө 5-10 метрийн зайд тээврийн хэрэгсэл орох хэсэгт анхааруулах тэмдэгтэй саад байрлуулж, шөнийн цагт гэрэлтүүлж байх ёстой. Материалыг сул асгасан шороон дундуур явдаг замын захад тавьж, шороон овоолгоноос 1м-ээс ойр зайд оруулахгүй.
12. Бутлах алхыг хэрэглэхдээ дараах шаардлагыг хангана:
- Ажил эхлэхийн өмнө алх, түүнд шахсан агаар өгдөг шланг, тэдгээрийг холбодог хоолой зэргийн эвдрэл, гэмтлийг шалгана;
 - Шлангийг шахсан агаар орох оролттой зөвхөн агаар хуваарилагч хайрцаг болон гол хоолойноос зайлуулагч дээр суурилуулсан эргүүлгэн хаалт буюу таглаагаар холбоно. Шлангийг холбох буюу салгахдаа агаар өгөлтийг заавал хаасан байна;
 - Хагардаггүй хамгаалалтын нүдний шил, эсвэл хамгаалалтын хаалттай ажиллана.
13. Замын хучилтан дахь гологдлыг бутлахдаа бутарсан хэлтэрхийнүүд үсэрч болох бүс газарт өөр ажилчдыг байлгахгүй.
14. Самосвалаар ачиж авчирсан асфальтан бетон хольцыг асфальт бетон дэвсэгчид цэнэглэх үүднээс асфальт бетоны ажилчин дараах шаардлагуудыг хангах үүрэгтэй:
- Замын хажуу тал руу самосвал орох үед жолоочид харагдах газарт байрлаж байх;
 - Самосвал зогсож, тэвшээ өргөсний дараа л самосвал руу очно;
 - Самосвалын тэвшний асфальт бетон хольцыг уртасгасан бариултай хүрз буюу хусуураар цэвэрлэнэ;
 - Самосвалаар асфальт бетон хольц тээвэрлэж байх үед унасан хольцыг самосвал асфальт бетоноо бүрэн зөөж дууссаны дараа бункер руу зөөнө.
15. Асфальт бетон хольцыг цутгахад дараах зүйлсийг хориглоно:
- Замын шинэхэн дэвссэн халуун хучилтан дээр зогсох;
 - Асфальт бетон хольц асгасны дараа индүүгээр тэгшилсэн хэсэгт хүрэх;
 - Хөдөлж буй булт индүү буюу хийн дугуйт индүүний өмнө зогсох.
16. Асфальт бетон хольцыг гараараа цутгахад дараах шаардлагуудыг хангана:
- Халуун хольцыг 8м-ээс дээш зайд цутгахдаа гурван талаас нь хязгаарлсан борттой носилка эсвэл цойцон тэргэн дээр ачиж урагш нь тонгойлгон асгана;
 - Халуун хольцыг цутгах хэсэг рүү зөөхгүй.

17. Замын зурвасыг хар наалдамхай зүйлийг боловсруулсан материалаар хийхдээ дараах шаардлагуудыг биелүүлнэ:

- Замын дэвссэн хучилтын түвшинг шалгах, материалыг тухайн зурваст механикаар цутгаж дууссан, машины ажил зогссоны дараа материалын илүү хэсгийг авах буюу утгаж хийх;
- Замыг хар наалдамхай зүйлээр хучиж цутгах үед цутгалтын газарт 10м-ээс ойр зайд гадны хүн байлгахгүй байх. Цутгалтын талбай хязгаарлагдсан байх ёстой.

Ослын үеийн аюулгүй байдлын шаардлага

18. Ажил дараах нөхцөлд зогсоно:

- Ажлын фронтод үзэгдэх орчныг хязгаарласан аадар бороо, бороо, манан, цастай үед;
- Асфальт бетон дэвсэгч, эсвэл гар багаж хэрэгсэл эвдэрсэн үед;
- Автогудронатораас битум алдагдахад;
- Замын тэмдэг, үйлдвэрлэлийн ажлын газрын хязгаарлалтыг тээврийн хэрэгслээр унагасан буюу гэмтээсэн үед;
- Тээврийн хэрэгсэл ажлын байрандаа орохтой холбоотой үүссэн зам тээврийн осол болсон үед.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

19. Асфальт бетоны ажилчин ажлын төгсгөлд дараах зүйлсийг хийх ёстой:

- Механикжсан багаж хэрэгслийг сүлжээнээс салгах;
- Ажлын цагт ашигласан багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг хадгалахад зориулсан байранд авч ирж тавих;
- Ажлын байран дахь эмх журмыг тогтоох;

Бригадын ахлагч, эсвэл ажлын удирдагчдаа ажлын үеэр гарсан эвдрэл, дутагдлын талаар мэдээлэл өгөх.

Бульдозерын операторын аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, ILO OSH 2001 удирдамж, OHSAS 18001 стандартуудын шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Оператороор 18-аас дээш насны, мэргэжлийн үнэмлэх болон ажилласан тодорхой туршлагатай эрчүүд ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн урьдчилан сэргийлэх болон өдөр тутмын үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан ;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан , ажлын байранд дадлагажиж шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Оператор ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох дараах үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Дуу шуугиан,
 - Чичиргээ,
 - Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон бусад хортой хүчин зүйл нэмэгдэх,
 - Машин, механизм болон эд ангиудын хөдөлж буй хэсгүүд,
 - Ойр орчимд ажиллаж буй хүмүүс.
3. Үйлдвэрлэлийн бохирдол болон механик нөлөөнөөс хамгаалахын тулд машинист ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал,ажлын бээлий,
өвөл ажиллахад зориулан дулаалсан чихэвч, ажлын хувцас, эсгий гутал.
4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд оператор компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
5. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана.
 - Ямар нэг зөрчил, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно;
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах,

мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
 - Удирдах ажилтны хамт бульдозерын ажиллах газар, тус газрыг туг дарцгаар тэмдэглэсэн эсэх, аюултай бүст аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээ тавигдсан эсэх, бусад машин механизмууд саад болж буй эсэхийг шалгана. Мөн ажил гүйцэтгэх болон аюулгүй ажиллагааны арга хэмжээ авах дарааллыг нарийн тогтооно,
 - Бульдозерт өдөр тутмын техник үйлчилгээ хийнэ,
 - Машинд үйлчилгээ хийж буй ажилтан болон машиныг ажиллах ойр орчимд байгаа хүмүүст хөдлөх гэж буйгаа анхааруулах бөгөөд араан дамжуулга нейтраль дээр байгаа эсэхийг шалгана;
Хөдөлгүүрийг асааж, ажлын бүх механизм хэвийн ажиллаж байгаа эсэхийг , тоормосны ажиллагааг бага зэрэг явж шалгана.
8. Операторууд аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн тохиолдолд ажил гүйцэтгэхийг хориглоно:
 - Бульдозерын агрегатуудад ямар нэг эвдрэл үүссэн тохиолдолд;
 - Ажлын бүст хүн, машин, бусад тоног төхөөрөмж байхад;
 - Үйлдвэрээс зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү налуу газарт ажиллах;
 - Удирдагчийн хэлж заагаагүй ямар нэг шугам, хоолой, холбооны шугам харагдсан тохиолдолд.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчлүүдийг машинист өөрөө арилгахыг эрмэлзэх ба боломжгүй нөхцөлд кемпийн удирдагч, менежер, эсвэл бульдозерын техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцдаг инженерт мэдэгдэж засуулах үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

9. Хөдөлгөөн эхлэхийн өмнө ажлын бүст хүн, мал байгаа эсэхийг шалгаж, дуут дохио өгнө.
10. Машиныг өөрөөр нь нэг газраас нөгөө газар луу аваачихдаа:
 - Бульдозерын хутгыг операторын харах боломжийг хязгаарлахгүй байх хамгийн дээд түвшинд хүртэл өргөнө;
 - Хутга нь зам дээр байгаа ямар нэг зүйлд тээглэхгүй, хатгаж шигдэхгүй байхаар зохицуулж явна;

- МУ-ын замын хөдөлгөөний дүрмийг мөрдөнө;
- Төмөр замыг зөвхөн гармаар, зөвшөөрсөн гэрэл дохиогоор гатална;
- Шөнийн цагаар бульдозерыг зам дээр зогсоох хэрэг гарвал Замын хөдөлгөөний дүрмийн дагуу оврын буюу ослын дохионы гэрэл асааж зогсоно.

11. Бартаатай газар ажиллах:

- Налуу газарт ажиллахдаа машиныг 1 дүгээр араагаар ажиллуулна,
- Налуу газар зогсоохдоо машины тоормозыг татна.

12. Гаргаж авсан зүйлсийг буцааж асгахын өмнө тэнд машинист хүн, тоног төхөөрөмж, барилгын материал байхгүй эсэхийг шалгана. Асгах үед бульдозерын соёог налуу газрын захад хүргэхгүй ажиллана.

Ухмал нүхний ирмэг дээр бульдозерын эргэх үйлдлийг хориглоно.

13. Эксковатор ажиллаж буй ойр орчимд бульдозер ажиллуулахыг хориглоно.

Эксковаторыг зогсоож, шанагыг газарт хүргэл тавьсны дараа л бульдозер ойр орчимд нь ажиллахыг зөвшөөрнө.

14. Чиргүүлтэй хоёр бульдозер зэрэг ажиллах боломжтой хамгийн бага зай нь 20 м. Чиргүүлгүй хоёр бульдозер зэрэг ажиллах хамгийн бага зай нь 10 м-ээс доошгүй байна.

15. Тэсэлгээний ажил хийгдэж байгаа үед бульдозерыг тэсэлгээний ажлын удирдагчийн заасан аюулгүй газарт байрлуулж, зөвшөөрсөн дохио өгсний дараа л буцаж очихыг зөвшөөрнө.

16. Соёо болон хутгыг цэвэрлэх шаардлагатай үед оператор түүнийг газарт хүргэж байрлуулаад, хөдөлгүүрээ унтраана.

17. Хажуу хэвгий газар ажиллах үед операторт дараах зүйлс хийхийг хориглоно:

- Огцом эргэлт хийх;
- Хутга нь доор байрласан байхад эргэх;
- Машины паспортод заасан хэмжээнээс илүү өнцөг үүсгэсэн хазгай газарт хөндлөнгөөр явах.

18. Бульдозерыг трейлерт ачихын өмнө машинистууд трейлер тогтвортой зогссон эсэх, зогсоолын тоормозыг ажиллуулсан эсэхийг шалгана. Бульдозерыг ачсаны дараа хутгыг буулгаж, бульдозерыг бэхэлнэ. Бульдозерыг тээвэрлэж явах үеэр бүхээгт нь оператор сууж явахыг хориглоно.

19. Ажлын үеэр операторт дараах зүйлсийг хориглоно:

- Хөдөлгүүрийг асаалттай чигээр нь орхиж явах;
- Машины бүхээгт гадны хүн тээвэрлэх;
- Машиныг явж байх үед буух, суух.

20. Бульдозерын техник үйлчилгээний үеэр оператор хөдөлгүүрийг унтрааж, гидросистемийн даралтыг зогсооно.
21. Бульдозерт шатахуун хийж байхад оператор болон ойр орчимд байгаа бусад этгээдэд тамхи татах, ил гал гаргахыг хатуу хориглоно. Машинд шатахуун хийсний дараа урссан түлш, тосыг арчиж, тос болсон эд зүйлийг тагтай метал саванд хийнэ.
22. Засвар болон урьдчилан сэргийлэх үзлэг хийх шаардлагатай үед анжисыг доош болгон түгжиж, бат бэх бөгөөд тогтвортой ивүүрээр тулна. Деталь эд ангиудыг угаахдаа этилийн бензин хэрэглэхийг хориглоно.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

23. Газар шорооны ажил гүйцэтгэж байх үед газар доорх шугам, хоолой, сүлжээ, эсвэл тэсэрч дэлбэрэх аюултай зүйл гарч ирвэл оператор ажлыг нэн даруй зогсоож, менежер болон удирдах хүндээ мэдэгдэнэ.
24. Ажлын үеэр ямар нэг эвдрэл гэмтэл, зөрчил дутагдал илэрвэл машиныг ашиглахыг хориглох бөгөөд машины техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцдаг инженерт мэдэгдэнэ.
25. Гал гарсан үед оператор нэн даруй гал унтраагуул болон гарын доорх элс, шороо, брезент гэх мэт зүйлээр галыг унтраах арга хэмжээ авч, даамал болон бусад удирдлагадаа мэдэгдэнэ.
Галыг усаар тургиж унтраах гэж оролдож болохгүй. Галыг өөрөө унтраах боломжгүй бол галаас хамгаалах алба дуудна.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

26. Ажил дуусахад оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
 - Бульдозерыг зогсоолд тавина;
 - Хурд түгжих хөшүүргийг нейтраль дээр тавьж, зогсоолын тоормозыг ажиллуулна;
 - Хөдөлгүүрийг унтраана;
 - Бүхээгний хаалгыг хааж, түгжинэ;
 - Менежер буюу бульдозерын инженер механикт ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч, ээлжийн Бүртгэлд тэмдэглүүлнэ.

Автогрейдерийн опероаторын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжын шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Оператороор 18-аас дээш насны, мэргэжлийн үнэмлэх болон ажилласан тодорхой туршлагатай эрчүүд ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн өдөр тутмын үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байх;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Операторууд ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Уулын чулуулаг (шороо) нурах,
 - Дээрээс юм (шороо, чулуу) унах,
 - Хөдөлгөөнт болон бусад ажлын хэсгүүд,
 - Машин хөмөрч унах, ажлын хэсгүүд эвдэрч унах гэх мэт.
3. Үйлдвэрлэлийн бохирдол болон механик нөлөөллөөс хамгаалахын тулд оператор ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал, ажлын бээлий, дуу шуугианаас хамгаалах чихэвч (касканд бэхэлсэн), хамгаалалтын 2-р зэргийн дохиоллын хантааз (фосфортой хантааз).

Ажлын байран дээр хамгаалалтын малгай (каска)-тай ажиллана.
4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд оператор компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд болон согтуу хүн оруулахыг хориглоно.
5. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:

- Жижиг механик хэрэгсэл, механизмыг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Зөвхөн даамал буюу менежерийн даалгаж өгсөн ажлыг гүйцэтгэнэ;
 - Ажлын байранд эмх цэгцтэй байж, хог, цас, хальтиргаа үүсгэх аюултай бусад бүх зүйлийг цэвэрлэж, бараа материал болон машин механизмыг хадгалах горимыг зөрчихгүй байх;
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
- Удирдаж буй хүндээ автогрейдер жолоодох эрхийн үнэмлэхээ үзүүлж, түүнээс гүйцэтгэх ажлын онцлогтой холбоотой ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
 - Ажлын хувцас, гутал өмсөнө;
 - Даамал, менежер юмуу инженер механикаасаа даалгавар авах ба үүний зэрэгцээ газар доогуур явсан байгууламж, харилцаа холбоо, усны гэх мэт шугамын байрлалыг үзэж нягтална. Иймэрхүү газарт дарцаг буюу өөр зүйлээр тэмдэглэгээ хийсэн байх ёстой.
8. Үүрэг даалгавар авсны дараа оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- Грейдерийн өдөр тутмын техник үйлчилгээг хийнэ;
 - Хөдөлгүүрийг асаахын өмнө машины тавцан дээр байгаа гадны бүх биетийг зайлуулж, хөдөлгүүрийн эргэх хэсгүүд дээр ямар нэг гадны биет байхгүй эсэхийг шалгана;
 - Хөдөлгүүрийг асаасны дараа машиныг хий ажиллуулж, механизмын ажиллаж байгаа эсэхийг шалгана;
 - Грейдерийг ажиллах газарт байрлуулахын өмнө далангийн өргөн маневр хийхэд хангалттай зай байгаа эсэх, байрлах газрын хэвгий нь автогрейдерийн паспортод заасан хэмжээнээс хэтэрсэн налуугүй эсэхийг шалгана.
9. Операторууд аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсэн тохиолдолд ажил гүйцэтгэж болохгүй:

- Механизм, түүний метал хэсгүүд болон автогрейдерийн гидросистемийн татлага эвдэрсэн тохиолдолд,
- Автогрейдерийн ажиллах байр аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэхгүй байгаа үед,
- Автогрейдерийн ажиллах орчинд гадны хүмүүс байхад, түүнчлэн аюулгүй байдлын бусад шаардлагыг зөрчсөн зөрчлүүдийг оператор өөрөө арилгахыг эрмэлзэх ба боломжгүй нөхцөлд автогрейдерийн техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцдаг этгээд, эсхүл даамал, менежертээ мэдэгдэж засуулах үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Автогрейдерийг ажиллуулж байх үед маневр хийхийн өмнө автогрейдерийн ойр орчимд аюултай зайд хүн байхгүй эсэхийг шалгана. Автогрейдерийн ойр орчмын аюултай зайд гэдэгт машины урд хойно буюу хажуу талд хутгыг урагш, дээш, доош өргөх буюу сунгах, өргөсөн буюу сунгасан байрлалтайгаар хөдлөхөд хүн цохигдож, дайруулж болзошгүй зайд байрлаж байгааг хэлнэ.
11. Автогрейдерийг ажиллуулж байх үед операторт дараах зүйлсийг хориглоно:
 - Анхааруулах дохио өгөлгүй хөдөлгөөнийг эхлэх үйлдэл,
 - Автгрейдер, ажлын объект (түрж буй шороо, хусаж буй хөрс гм) хоёрын хооронд хүн зогсож байхад ажлаа үргэлжлүүлэх,
 - Хутгаа өргөсөн байдлаар ажлын байрыг орхиж явах.
12. Газар доорх байгууламж, цахилгаан, дулааны шугам сүлжээ, цахилгааны кабельтай газар ажиллахдаа тэдгээрийн хууль ёсны өмчлөгч буюу эздээс бичгээр зөвшөөрөл авсны дараа ажиллахыг зөвшөөрнө.
13. Хөрсний халдварт эмгэгтэй газар (тухайлбал, хогийн цэг, мал нядалгааны бой, оршуулгын газар гм) ажиллахдаа Хот тохижуулах газраас бичгээр зөвшөөрөл авсан байна.
14. Хутгыг цэвэрлэх, солих шаардлага гарсан үед оператор хутгыг газарт буулгаж, хөдөлгүүрийг унтраана.
15. Автогрейдерийг трейлер буюу тавцан дээр байрлуулж нэг объектоос нөгөө рүү тээвэрлэхдээ кабинд нь зорчигч байлгахыг хориглоно.
Харин автогрейдерийг өөрөөр нь явуулж, эсвэл чирч зөөвөрлөхөд оператор кабинд сууж явах бөгөөд Замын хөдөлгөөний дүрмийн дагуу жолоодож явна.
16. Автогрейдерийн операторт дараах зүйлсийг хориглоно:
 - Эрхгүй этгээдэд жолоогоо шилжүүлэх,
 - Хөдөлгүүрийг асаалттай чигээр нь орхиж явах,

- Автогрейдерийн бүхээгт гадны этгээд тээвэрлэх. Зайлшгүй тохиолдолд оператор автогрейдерээс гарахдаа арааг нейтраль байдалд шилжүүлж, хөдөлгөөнөө зогсооно.
- 17. Техник үйлчилгээний үеэр автогрейдерийн оператор хөдөлгүүрийг зогсоож, гидросистемийн даралтыг бууруулна.
- 18. Автогрейдерт шатахуун хийх үед автогрейдерийн ойр орчмын хүмүүст тамхи татах, ил гал гаргахыг хориглоно. Автогрейдерийн ажиллаж буй болон зогсоолд тавьсан газраас 50м-ээс ойр зайд ил гал гаргахыг хориглоно.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

- 19. Автогрейдерийн ажиллаж буй хэсэгт даамлын зүгээс анхааруулаагүй ямар нэг шугам, труба, тэсрэх аюултай зүйл, эсвэл үл танигдах ямар нэг зүйл гарч ирвэл ажлыг нэн даруй зогсоож, зохих зөвшөөрөл авахыг хүлээнэ.
- 20. Хөрс хагарах буюу халтирах үзэгдэл тохиолдвол оператор ажлыг зогсоож, тухайн газраас яаралтай холдож аюулгүй газар зогсох бөгөөд даамалд энэ тухай мэдэгдэнэ.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

- 21. Ажил дуусахад оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
 - Автогрейдерийг зориулалтын зогсоолын талбайд зогсоох,
 - Хутгыг газарт тавих,
 - Хөдөлгүүрийг унтраах,
 - Бүхээгийг хааж, цоожлох,
 - Автогрейдерийг цэвэрлэж дараагийн өдрийн ажилд бэлдэнэ
 - Кемпийн даамал, менежер буюу автогрейдерийн ажиллагааг хариуцсан инженер механикт ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч автогрейдерээ хүлээлгэн өгч, зөвшөөрөл авсны дараа ажлаас бууна.

Авто ачигчийн операторын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Оператороор 18-аас дээш насны, мэргэжлийн үнэмлэх болон ажилласан тодорхой туршлагатай эрчүүд ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн урьдчилан сэргийлэх (ажилд ороход) болон өдөр тутмын (ажиллаж байх хугацаанд) үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байх;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Операторыг ажилд авахдаа "...” ХХК-н зохих албан тушаалтны тушаалаар ажилд авах бөгөөд авто ачигчийн ашиглалтын заавар, энэхүү аюулгүй ажиллагааны заавартай танилцуулсан байна. Авто ачигчийн операторыг өөр авто ачигч болон шинэ загварын авто ачигч дээр ажиллуулахдаа тухайн техникийн онцлогтой танилцуулж, ашиглалтын заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай ахин танилцуулна.
3. Операторууд ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Уулын чулуулаг (шороо) нурах,
 - Дээрээс юм (шороо, чулуу) унах,
 - Хөдөлж буй машин болон түүний ажлын хэсгүүд,
 - Машин хөмөрч унах, ажлын хэсгүүд эвдэрч унах.
4. Механик нөлөөллөөс хамгаалахын тулд оператор ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, түрийтэй ажлын гутал, ажлын бээлий, шуугианиас хамгаалах чихэвч буюу хавчуурга, хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз.

5. Өвлийн улиралд ажиллахдаа хүйтнээс хамгаалах дулаан ажлын хувцас, гутал, бээлхий, хантааз өмсөнө. Барилгын талбайд ажиллах бол хамгаалалтын каска өмсөнө.
6. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд машинист компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
7. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Даамал, менежер буюу удирдах хүний үүрэг болгосон ажлыг л гүйцэтгэнэ,
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана,
 - Ямар нэг зөрчил дутагдал, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно,
 - Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгаж, хог, цас, шаврыг арилгах ба материал, машиныг хадгалах дүрмийг зөрчихгүй,
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
8. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

9. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
 - Удирдаж буй хүндээ авто ачигчийн тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхээ үзүүлж, түүнээс гүйцэтгэх ажлын онцлогтой холбоотой ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
 - Ажлын хувцас, гутал өмсөнө;
 - Удирдаж буй хүн буюу даамал, эсхүл менежерээсээ үүрэг даалгавар авах ба үүний зэрэгцээ ачих шороо, чулууны хэмжээг машины даацын хэмжээнд тохируулж ажиллана.
10. Үүрэг даалгавар авсны дараа оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
 - Хөдөлгүүрийг асаахын өмнө машины тавцан дээр байгаа гадны бүх биет, шатны бариул гишгүүр дээрх бохир зүйлс болон асгарсан тос маслыг цэвэрлэж, шанага болон өргөгч хэсгүүд дээр шороо, чулуу, бусад гадны биет байхгүй эсэхийг шалгана;

- Хөдөлгүүрийг асаасны дараа машиныг хий ажиллуулж, хөдөлгүүр, тоормосны болон жолооны механизм, өргөх буулгах механизм, шагана зэрэг нь бүгд хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана;
- Авто ачигчийг ажиллах газарт байрлуулахын өмнө хөрсийг тэгшилсэн эсэх, ачааг бункерт хийх үед байрлах газар нь бат бэх, тэгш байгаа эсэх, хөрс нь хангалттай нягтарсан, нурах аюулгүй эсэх, бункерт ачааг буулгахаар өндөрлөж зассан газрын бат бэх, тэнцвэртэй байдал зэргийг шалгана.

11. Оператор аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн тохиолдолд ажил гүйцэтгэхийг хориглоно:

- Авто ачигч болон түүний ажлын аль нэг хэсэгт ямар нэг эвдрэл, дутагдал үүссэн,
- Авто ачигчийн ажиллах орчин аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэхгүй байгаа,
- Ачаа ачих хэсэгт зөрчил дутагдал илэрсэн буюу түүний хүчин чадал нь ачих ачааны онцлог, жин хэмжээ, өндөртэй тохирохгүй бол,
- Ажлын бүст хүн, мал, тоног төхөөрөмж, бусад саад байртаа байгаа үед,
- Зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү налуутай газар байгаа үед.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчлүүдийг оператор өөрөө арилгахыг эрмэлзэх ба боломжгүй нөхцөлд авто ачигчийн техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцдаг ажилтан, эсхүл даамалдаа мэдэгдэж засуулах үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

12. Ажил эхлэхийн өмнө ойр орчимд, авто ачигч дээр хүн байхгүй эсэхийг шалгана. Мөн машины цэвэрлэгээ, тосолгоо, засварыг хийлгэхгүйгээр ажилд гарч болохгүй.
13. Авто ачигчийг ажиллуулж байх үед хөдлөх буюу маневр хийхийн өмнө ачигчийн ойр орчимд аюултай зайд хүн байхгүй эсэхийг шалгана. Авто ачигчийн ойр орчмын аюултай зай гэдэгт машины урд хойно буюу хажуу талд шанагыг урагш, дээш, доош өргөх буюу сунгах, өргөсөн буюу сунгасан байрлалтайгаар хөдлөхөд хүн цохигдож, дайруулж болзошгүй зайд байрлаж байгааг хэлнэ.
14. Машиныг хөдөлгөхийн өмнө ойр орчимд хүн байхгүй эсэхийг магадалж, дуут дохио өгнө.
15. Авто ачигчийн шанагыг өргөхдөө оператор өргөх үйл явцыг сайтар хянах бөгөөд шанага дээд цэгтээ хүртэл өргөгдсөн бол өргөх механизмыг зогсооно.
16. Чулуу шороог авах зорилгоор хөрсийг тэслэх үед тэсэлгээний ажлын удирдагчийн заасан газар буюу 50м-ээс ойргүй зайд авто ачигчийг холдуулан байрлуулна.
17. Харин хөрсийг цохих аргачлалаар (шаантган, эсвэл бөмбөрцгөн лантуугаар) хуулахдаа авто ачигчийн урд шилийг хамгаалалтын төмөр тороор тоногдсон байна.

18. Авто ачигчийг ажиллуулж байх үед операторт дараах зүйлсийг хориглоно:
- Шанагыг газраас хөндийрүүлж өргөөгүй байхад эргэх үйлдэл хийх,
 - Шанагаар хөрсийг тэгшлэх буюу талбайг цэвэрлэхгүй байх,
 - Шанагыг өргөсөн байхад авто ачигчийг цэвэрлэх, тослох, засах,
 - Авто ачигч, ажлын объект (ачиж буй шороо, чулуу, ачааг буулгаж буй бункер гм) хоёрын хооронд хүн зогсож байхад ажлаа үргэлжлүүлэх,
 - Шанагаа өргөсөн байдалтайгаар ажлын байрыг орхиж явах.
19. Шанагыг цэвэрлэх шаардлага гарсан үед оператор шанагыг газарт буулгаж, хөдөлгүүрийг унтраана.
20. Авто ачигчийг трейлерийн тавцан дээр байрлуулж нэг объектоос нөгөө рүү тээвэрлэхдээ кабинд нь оператор болон өөр хүн байлгахыг хориглоно.
Харин авто ачигчийг өөрөөр нь явуулж, эсвэл чирч зөөвөрлөхөд оператор кабинд сууж явах бөгөөд Замын хөдөлгөөний дүрмийн дагуу жолоодож явна.
21. Авто ачигчийн операторт дараах зүйлсийг хориглоно:
- Эрхгүй этгээдэд жолоогоо шилжүүлэх,
 - Хөдөлгүүрийг асаалттай чигээр нь орхиж явах,
 - Машины бүхээгт гадны этгээд тээвэрлэх.

Зайлшгүй тохиолдолд оператор авто ачигчаас гарахдаа арааг нейтраль байдалд шилжүүлж, хөдөлгөөнөө зогсооно.

22. Авто ачигчид шатахуун хийх үед түүний ойр орчмын хүмүүст тамхи татах, ил гал гаргахыг хориглоно. Авто ачигчийн ажиллаж буй болон зогсоолд тавьсан газраас 50м-ээс ойр зайд ил гал гаргахыг хориглоно.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

23. Авто ачигчийн ажлын механизмуудад үл тохирол болон эвдрэл гэмтэл гарсан үед оператор ачигчийн эвдрэл гэмтлийг засах хүртэл ажлаа зогсооно. Машины эвдрэл гэмтэл, аливаа асуудал бэрхшээлийг оператор өөрөө засч шийдвэрлэх боломжгүй бол удирдаж буй хүн буюу авто ачигчийн бүрэн бүтэн байдлыг хариуцдаг инженерт мэдэгдэж, засуулах арга хэмжээ авна.
24. Авто ачигч хазгай газарт явж байгаад хальтрах буюу дугуй нь нүхэнд орж тэнцвэрээ алдвал оператор шанагаа газрын хөрсөнд хүртэл буулгаж, машинаас буух бөгөөд чирүүлж тэгш газар аваачина.

25. Хөрс хагарах буюу халтирах үзэгдэл тохиолдвол оператор ажлыг зогсоож, тухайн газраас яаралтай холдож аюулгүй газар зогсох бөгөөд даамал буюу менежерт энэ тухай мэдэгдэнэ.
26. Шатах тослох материал буюу өөр ямар нэг материал гал авалцан шатаж эхэлвэл оператор нэн даруй гал унтраагуул болон гарын доорх элс, шороо, брезент гэх мэт зүйлээр гарыг унтраах арга хэмжээ авна.
- Галыг усаар тургиж унтраах гэж оролдож болохгүй. Галыг өөрөө унтраах боломжгүй бол галаас хамгаалах алба дуудаж, даамал, менежер болон бусад удирдлагадаа мэдэгдэнэ.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

27. Ажил дуусахад оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- Авто ачигчийг зогсоолын талбайд зогсооно,
 - Зогсоолын тоормосыг татна,
 - Шанагыг газарт хүргэж буулгах,
 - Хөдөлгүүрийг унтрааж, араг нейтраль байдалд тавина,
 - Бүхээгийг хааж, цоожлох,
 - Ажлын хувцсыг тайлж, хадгалах газарт тавина,
 - Кемпийн даамал, менежер буюу грейдерийн ажиллагааг хариуцсан инженер механикт грейдерийн техникийн байдал, ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч, ээлжийн Бүртгэлд тэмдэглүүлнэ.

Мексерийн жолоочийн ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль болон бусад эрх зүйн актуудын шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагууд

1. 18-аас дээш насны, тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй, ажлын дадлага туршлагатай эрчүүд шинээр ажилд орохдоо дараах шаардлагуудыг хангасан байна:
 - Эрүүл мэндийн урьдчил үзлэгт орж ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулах;

- Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
 - 2. Жолооч ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Хөдөлж буй машин механизм болон түүний ажлын хэсгүүд;
 - Машины эргэх хэсгүүд;
 - Ажлын байран дахь дуу чимээ, чичиргээ ихсэх;
 - Ачаа ихсэх.
 - 3. Механик нөлөөллөөс хамгаалахын тулд жолооч ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын хатуу ултай арьсан ботинка буюу резинэн түрийтэй гутал, ажлын бээлий, шуугианиас хамгаалах чихэвч, хамгаалалтын нүдний шил, хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз.
- Хүйтний улиралд байнга гадаа ажиллах бол нэмэлтээр дараах зүйлсийг хэрэглэнэ:
- дулаалгатай ажлын хувцас буюу хүйтнээс хамгаалах зориулалттай ноосон болон холимог материалтай ажлын хувцас;
 - доод талдаа резинэн эсгий гутал юм уу, хатуу ултай дулаалгатай арьсан ботинка;
 - хөлдөлтөөс хамгаалдаг, арьсан хавчуургатай, хамгаалалтын гадаргатай бээлий;
 - хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз.

Зам барилгын үйлдвэрлэлийн талбайд ажиллахдаа хамгаалалтын каска өмсөх шаардлагатай.

- 4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд машинист компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
- 5. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - менежер буюу удирдах ажилтны үүрэг болгосон ажлыг л гүйцэтгэнэ,
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана,

- Ямар нэг зөрчил дутагдал, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно,
 - Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгаж, хог, цас, шаврыг арилгах ба материал, машиныг хадгалах дүрмийг зөрчихгүй,
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
- Автомашин жолоодох эрхийн үнэмлэхээ биедээ авч явна;
 - Эмчийн үзлэгт орсон байна,
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байна
 - Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байна,
 - Автомашины техникийн хуудсыг авч явах,
 - Ажлын хувцас, гутал өмссөн байх.
8. Удирдаж буй хүнээсээ үүрэг даалгавар авсны дараа дараах үүргийг хүлээнэ:
- Эмийн сан, гал унтраагуул болон бусад хэрэгтэй зүйлс байгаа эсэхийг шалгана,
 - Машины техникийн бүрэн бүтэн байдлыг шалгана. Ингэхдээ машины дугуй, тоормосны систем, жолооны механизм, карданан голын болтуудын бэхэлгээ, сүлжээ, урд гэрэл, зогсох дохио, эргэх чиг заадаг гэрэл дохио, дуут дохио, хяналтын самбар, ар талыг харуулах толь зэрэг хэвийн байгаа эсэхийг шалгаж, баталгаажуулах,
 - Ээлж бүрийн техникийн үйлчилгээг үзүүлж, машины түлш, тос масло, ус, тоормозны шингэнийг шалгаж, дүүргэх бөгөөд аккумуляторын цэнэгийн электролитийн түвшинг шалгана,
 - Машинд түлш, тос маслаг хийсний дараа нефтийн төрлийн бүтээгдэхүүн болсон хэсгүүдийг цэвэрлэж, машины бүх хэсгийг хуурай болгоно,
 - Бетон зуурагч агрегатын хэвийн эсэхийг шалгана,
 - Хөдөлгүүрийн ажиллах чадварыг хий ажиллуулж шалгах ба гэрэлтүүлэх, хянах хэрэгслүүдийг шалгаад, тоормос болон жолооны хүрдийн ажиллагааг бага зэрэг явж шалгана,

- Машиныг гаражаас гаргахдаа хариуцдаг хүнд нь техникийн бүрэн бүтэн машин авч гарч байгаагаа баталж, машины техникийн бүрэн бүтэн байдлыг шалган хөтөлдөг жагсаалтад тэмдэглүүлнэ.
9. Жолооч аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн үед машиныг авч ажилд гарахыг хориглоно:
- Механизм, системд эвдрэл гэмтэл гарсан,
 - Арал болон бетон зуурагчийг оролцуулаад металл байгууламжийн аль нэг хэсэгт ан цав үүссэн, гажсан тохиолдолд,
 - Гал унтраах анхан шатны хэрэгсэл байхгүй үед.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчлүүдийг машинист ажилд гарахын өмнө өөрөө арилгахыг эрмэлзэх ба боломжгүй нөхцөлд инженер механикт мэдэгдэж засуулах үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Хуурай хольц буюу бэлэн болсон бетон зуурмагийг тээвэрлэхийн өмнө жолооч бетоны узелийн савны амсар мексерийн хоолойтой таарч байрласан эсэхийг шалгана.
11. Замын жагсаалт буюу маршрутаар заасан объект дээр ирэхэд машинист дараах зүйлсийг хийх ёстой:
- Бетон зуурмагийг буулгах газарт ирээд жолооч удирдах ажилтны хамт ойр орчимд ажиллаж буй машин механизм, цахилгаан сүлжээний утас, хүн, мал, бусад саад тотгор байхгүй эсэхийг магадална,
 - Мексерийн жолооч бетон зуурмагийг буулгахдаа бетончинтой дуут дохио болон гар дохиогоор ойлголцож ажиллана,
 - Зуурмагийг буулгаж дууссаны дараа мексерийн барабаныг удирдагчийн тусгайлан зааж өгсөн газарт угааж, угаадсыг мөн удирдагчийн заасан газарт асгана.
12. Зуурмагийг асгахдаа жолооч мексерийг орох гарах замтай, тэгш гадаргатай газарт зогсооно. Мексерийн эргэн тойронд 1 м-ээс багагүй сул зай байх ёстой. Бетон асгах газарт хошууг чиглүүлсний дараа жолооч мексерийн барабаныг эсрэг чиглэл рүү эргүүлж, бетон зуурмагийг шаардлагатай хэмжээнд хүртэл асгана.
13. Жолооч мексерийг ухмал нүх, жалгатай газарт зогсоох буюу нүх, жалганы хажуугаар бетон зуурмаг тээвэрлэхэд доорх хүснэгтэнд зааснаас дээш зай барихыг зөвшөөрнө.

Нүхний гүн, м	Нүхнээс мексерийн дугуй хол байх хамгийн бага хэмжээ, м			
	элсэрхэг	элсэнцэр	шаварлаг	шавартай
1	1,5	1,5	1,5	1,5
2	3,0	3,0	3,0	3,0
3	4,0	4,0	4,0	4,0
4	5,0	5,0	5,0	5,0
5	6,0	6,0	6,0	6,0

14. Ажил гүйцэтгэх үед жолооч дараах үүрэгтэй:

- Мексерийн бүхээг болон барабаныг цэвэр байлгаж, барабанд бетон зуурмаг үлдээхгүй цэвэрлэж байх;
- Мексерийн даацаас хэтэрсэн бетон зуурмаг тээвэрлэхгүй байх;
- Мексерийн хөдөлгүүр асаалттай байхад харах хүнгүйгээр орхиж явахгүй байх;
- Мексерийн гишгүүр дээр, эсвэл гадна талын аль нэг хэсэгт хүн байхад мексерийн хөдөлгөөн эхлэхгүй байх;
- Мексерийн ажиллах ойр орчмын аюултай зайд хүн байхад бетон зуурмагийг асгахгүй байх.

15. Мексерээр нийтийн хэрэгцээний замаар тээвэрлэлт хийхдээ МУ-ын Замын хөдөлгөөний дүрмийн заалтуудыг мөрдөнө.

16. Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед мексерийг замын гэрэлтүүлэггүй хэсэгт зогсоохдоо МУ-ын Замын хөдөлгөөний дүрмийн дагуу оврын болон ослын дохионы гэрэл асаана.

Ослын үеийн аюулгүй байдлын шаардлага

17. Дараах зөрчил дутагдал илэрвэл ажлыг зогсооно:

- Зуурагч агрегат болон машины бусад хэсэг, эд ангиуд ан цав, эвдрэл гэмтэлтэй байх;
- Мексерийн түлш, тос масло гоожиж, алдагдах;
- Дугуйны хий алдагдсан байх;
- Мексерийн хөдөлгүүр болон зуурагч агрегатад дуу орох, ямар нэг мэдэгдэхүйц гажиг, доголдол үүсэх;
- Ажлын болон зогсоолын тоормосны системийн хэвийн ажиллагаа алдагдах;
- Гал унтраах хэрэгсэл байхгүй байх.

18. Мексерт гал гарвал галын хэсэгт түлш, шатахуун оруулахгүй байж, галын голомтыг гал унтраагуул, элс, шороо, брезентээр хучиж унтраана. Шатаж буй түлш болон цахилгаан дамжуулагчийг усаар унтраахыг хориглоно.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

19. Ажил дуусахад жолооч дараах үүрэгтэй:

- Барабаныг угааж, мексерийн бетон зуурмаг болсон хэсгүүдийг цэвэрлэнэ;
- Мексерийг зогсоолд тавина;
- Хөдөлгүүрийг унтраана;
- Зогсоолын тоормосыг татаж, араг нейтраль дээр тавина;
- Удирдах ажилтан буюу мексерийн аюулгүй ашиглалтыг хариуцсан этгээдэд ажлын үеэр гарсан бүх төрлийн асуудал, хүндрэл, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгч, бүртгэл хөтөлнө.

Авто самосвалын операторын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжын шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Ерөнхий шаардлага

1. Авто самосвалаар бие даан ажил гүйцэтгэхийг дараах шаардлагыг хангасан ажилтнуудад зөвшөөрнө:

- Ажлын заавар,
- Галын болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа,
- Ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа,

Автосамосвалаар ажил үүрэг гүйцэтгэхийг тухайн төрлийн механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй, эмчийн үзлэгт орсон, 18-аас дээш насны хүнд зөвшөөрнө.

2. Оператор дараах заавар, зааварчилгааг авсан байна:

- Хамгийн багадаа улиралд нэг удаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ээлжит давтан зааварчилгаа,

- Ажил гүйцэтгэх технологийн аргачлал буюу хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өөрчлөгдсөн, авто машиныг сольсон буюу шинэчилсэн, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдсөн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг зөрчсөн, ажил 30 хоногоос илүү хугацаагаар завсарласан зэрэг үед давтан зааварчилгаа авсан байна.
- 3. Оператор дараах үүрэгтэй:
 - Компанийн хөдөлмөрийн дотоодын журмын заалтуудыг мөрдөн ажиллах,
 - Энэхүү зааварчилгаа, автомасосвалаар ажил гүйцэтгэх заавар, галын аюулаас хамгаалах заавруудыг мөрдөх,
 - Карьерт ажиллах үеийн шаардлагуудыг хангах,
 - Хувийн хамгаалах хэрэгслүүдэд хайр гамтай хандаж, зориулалтын дагуу ашиглах.
- 4. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана.
 - Ямар нэг эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно;
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
- 5. Оператор дараах чадвартай байх ёстой:
 - Осол аюул учирсан үед анхны тусламж үзүүлэх,
 - Машинд анхны тусламжийн хайрцаг болон гал унтраагуултай байх,
 - Зөвхөн удирдлагын зүгээс үүрэг даалгавар өгсөн ажлыг гүйцэтгэх бөгөөд тухайн ажлыг өөр хэн нэгэнд дамжуулахгүй байх,
 - Ажлын үеэр анхаарал болгоомжтой байж, бусдад саад болохгүй, ажлын байранд ажилд хамаагүй этгээдийг оруулахгүй байх,
 - Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгах.
- 6. Оператор хувийн сахилга баттай байж, сахилга батын шаардлагуудын талаар мэддэг, биелүүлдэг байх үүрэгтэй. Үүнд: Хоол идэх, тамхи татах, амрах зэргийг зөвхөн тусгайлан заасан, зориулалтын газарт зөвшөөрнө. Ус ууж, завсарлага авахыг тусгайлан зориулсан зогсоол, буюу амрах газарт зөвшөөрнө.
- 7. Авто машин, түүний аль нэг механизм, эд ангиудын хэвийн бус ажиллагаа болон бусад аюултай, зөрчил дутагдалтай тал ажиглагдвал машиныг нэн даруй зогсооно. Зөрчил дутагдлыг арилгаж, эвдрэл гэмтлийг зассаны дараа ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө. мөр
- 8. Автомашинд гал гарвал:

- Автомашиныг зогсоож, галыг унтраах бөгөөд шатахуун болон шатах тослох материал ордог хэсгүүдийг хаана,
 - Гал унтраах гар доорх хэрэгсэл, үүнд элс, шороо, брезент, ашиглан галыг унтраана,
 - Гал унтраах боломжгүй бөгөөд хүний амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл бүрдвэл объектыг орхин явна.
9. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, ажлын үеэр тохиолдсон бүх аюул осол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
10. Энэхүү зааварчилгааны шаардлагуудыг биелүүлээгүйгээс үүдсэн аливаа зөрчил дутагдал, гамшиг ослын хариуцлагыг жолооч хүлээнэ.
11. Оператор байгууллагаас тавьж өгсөн ажлын хувцас, бээлий өмсөнө.
12. Үйлдвэрлэлийн хамгийн аюултай, хортой зүйлст дараах зүйлс орно:
- Автомашины хөдөлгөөнт эд ангиуд,
 - Хөдөлгүүр, хөргөх систем, яндангийн халсан гадарга,
 - Автомашины тэвшээ өргөж буй үе,
 - Асгарсан бензин,
 - Ажлын орчинд байгаа автомашин, тоног төхөөрөмж, хүмүүс.
13. Хоёр буюу түүнээс дээш тооны хүн карьер дээр ажиллаж байвал оператор удирдах хүнээс заан томилсон аюулгүй ажиллагаа хариуцаж, шаардлага тавих хүний хэлсэн дараалал, зааврыг дагаж мөрдөнө.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

14. Ажил эхлэхийн өмнө оператор эмнэлийг үзлэгт орсон байна.
15. Диспетчер юм уу механик инженерээс замын хуудас болон карьер дээр ажиллах бүрэн заавар авна,
16. Механикийн хамт машины техникийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, замын хуудсанд зохих тэмдэглэгээг хийнэ. Үзлэгийн үеэр дараах зүйлст онцгой анхаарал хандуулах хэрэгтэй:
- Аккумуляторын цэнэг, асаалтын систем, тормозны систем, жолооны систем, гадна талын гэрэл, дохио, салон, кабины хаалга, халаалтын систем, кузовны бүрэн бүтэн байдал, хөдөлгүүрийн болон хурдны хайрцагны шингэний түвшин, тэвшний түгжээ, машины гадна тал;
17. Машины гадна хэсгийн үзлэгээр дараах зүйлсийн бүрэн бүтэн байдлыг нягталж, шалгана:

- Машин болон тэвшний бүрэн бүтэн байдал, дугуйн хий, тоормозны систем, жолооны систем, гэрэлтүүлэх хэрэгсэл, дуут дохио, шил арчигч, толинууд, машины дугаар цэвэр бөгөөд харагдахуйц байгаа эсэх.
 - Түлш, тос масло, ус гоожсон эсэх,
 - Дугуйн хий;
 - Шаардлагатай багаж хэрэгсэл байгаа эсэх;
 - Түлш, тос масло, ус, тоормозны шингэн, аккумуляторын цэнэглэгчийн электролитийн түвшин зохих хэмжээнд байгаа эсэх.
18. Хөдөлгүүрийг асаахын өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
- Зогсоолын (гар) тоормосыг татсан,
 - Арааг нейтраль байдалд тавьсан,
 - Түлшний сав тагтай байх
19. Хөдөлгүүрийг асаасны дараа аажуу хөдөлгөөн хийж жолооны механизм, тормозны систем, дуут болон гэрлэн дохио хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана. Энэ үед ямар нэг гэмтэл илэрвэл хариуцсан ажилтанд мэдэгдэж дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахуулна. Дутагдал бүрэн арилахаас өмнө машиныг ажиллуулахыг хориглоно.
20. Хөдөлгүүр хөрсний дараа радиаторын тагийг авч болох ба гар, нүүрээ ууранд түлэхээс болгоомжилно.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

21. Зогсоолоос хөдлөхдөө ойр орчимд ажилчин, гадны хүмүүс байгаа эсэхийг шалгаж, дуут дохио өгнө.
- Автосамосвалын кузовыг заавал буулгасан байна.
 - Кабинаас гарахдаа түлш өгөлтийг зогсоож, урагш хойш хөдлөх чигт хүн, саад бартаа байхгүй эсэхийг шалгана. Машиныг бүрэн зогсоогүй байхад бууж, суухыг хатуу хориглоно.
22. Самосвалыг явж байх үед зогсоох шаардлага гарвал машиныг замын зорчих хэсгээс хажуу руу гаргаж тавих ба тэнд налуу байгаа бол дугуйн доор ивүүр хийж зогсооно .
23. Карьер дээр ажиллаж байх үед:
- Карьерт ажиллах нь онцгой анхаарал болгоомж шаардсан ажил тул оператор байнга анхаарал болгоомжтой ажиллана;
 - Карьерын даамлын өгсөн аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу ажлаа гүйцэтгэнэ;
 - Самосвалын зогссон талбай хальтиргаатай үед кузовыг шууд өргөх, буулгахыг хориглоно;

- Ачилт хийх зогсоолын байдлыг үнэлнэ;
 - Машинд ачаалахдаа арын юмуу хажуугийн хашлаганаас ачаална .
 - Эксковаторын шанагыг машины кабин дээгүүр явуулахыг хориглоно;
 - Автосамосвалын кабины дээд талд хамгаалалтын төмөр хаалт байхгүй үед мөн жолоочийг кабинд байхад эксковатороор самосвалд ачилт хийхийг хориглоно;
 - Карьерт ажиллаж байгаа самосвалын хөдөлгөөний хурд 20 км.цаг-с хэтрэхгүй байна.
24. Ачилт хийхээс өмнө самосвалын оператор гишгүүрийг хуурай хальтиргаагүй болтол цэвэрлэсэн байна .
25. Самосвалд ачилт хийхээр ухрахдаа аюултай зайд хүн мал амьтан байгаа эсэхийг хянаж шалгана.
26. Радиаторын тагийг авахдаа бээлий өмсөх эсвэл алчуураар жийрэглэж онгойлгоно. Онгойлгохдоо халуун шингэн даралттай гарна гэж тооцоолон маш хянамгай онгойлгоно.
27. Самосвалыг түлшээр цэнэглэхдээ хөдөлгүүрийг унтраах ба энэ үед гал гаргах, тамхи татахыг хатуу хориглоно
28. үлшийг зайлшгүй шаардлагаар шавхах хэрэг гарвал зориулалтын төхөөрөмж ашиглах ба үүний тулд шланг хийж, амаараа сорохыг хориглоно.
29. Самосвалд засвар үйлчилгээ хийх болсон үед урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг авна:
- Замын зорчих хэсгээс гаргаж зогсооно,
 - Үзэгдэлт хангалтгүй үед оврын гэрлээ асаах буюу шаардлагатай бол Замын хөдөлгөөний дүрмийн дагуу ослын дохионы гэрлээ асаана,
 - Зогсоолын тоормозыг татна,
 - Нэг дүгээр араанд хийнэ,
 - Дугуйн дор ивүүр хийнэ.
- Самосвалд засвар үйлчилгээ хийх үедээ замын зорчих хэсэгт байрлахыг хориглоно. Засвар үйлчилгээ хийж байгаа үед гадны хүн байлгахыг хориглоно.
30. Операторт дараах зүйлсийг хориглоно:
- Архи, согтууруулах ундаа болон бусад төрлийн мансууруулах бодис хэрэглэсэн үедээ самосвалыг жолоодох;
 - Өвчтэй буюу ядарсан үед, эрүүл мэндийн байдал нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй бол самосвалыг жолоодох,
 - Ачих, буулгах механизм ажиллаж буй бүсээс 5м-ээс ойр зайд техник үйлчилгээ, засвар хийх,
 - Түлш, шатахуун хийх газарт ил гал гаргах, тамхи татах,

- Хөдөлгүүрийг 2 төрлийн түлш холилдсон байдлаар ажиллуулах,
- Хөдөлгүүр ажиллаж байх үед, бүхээгийг халаалтын систем ажиллаж байх үед бүхээгт унтах, амрах, жолоог гадны этгээдэд шилжүүлэх,
- Ачаа ачиж, буулгаж байх үед техник үйлчилгээ, засвар хийх,
- Хүн тээвэрлэхэд зориулан тоноглоогүй бол машинд зорчигч тээвэрлэх, машины бүхээгт зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүн тээвэрлэх,
- Самосвалыг асаах гэж чирэх,
- Хөдөлгүүр болон бусад эд ангийг халаах гэсгээх зорилгоор ил гал ашиглах,
- Самосвалын хаалгыг ачаагаар хаах,
- Кузов дээр хүн тээвэрлэх,
- Кабины гишгүүр дээр хүн зогсож байхад хөдөлгөөн хийх,
- Аюултай болон хортой ачааг нэг дор тээвэрлэх, хэрэв ийм ачаа тээвэрлэх бол холбогдох эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа тээвэрлэнэ,
- Самосвалын хөдөлгүүрт цэвэрлэгээ үйлчилгээ хийх үедээ бензин ашиглах, хөдөлгүүр болон түлшний банкны ойр тамхи татах, ил гал гаргах.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

31. Оператор нь зам тээврийн осолд өртсөн тохиолдолд хамт явсан хүмүүсийг эхний машинаар аль болох түргэн эмнэлэгт хүргэх, Замын цагдаагийн газарт мэдээлэх, осолд өртсөн хүмүүст анхны тусламж үзүүлэх, хэрэг болсон газрыг хамгаалалтанд авах, ямар ч зүйлийг тухайн үеийн байдлаар нь байлгана.
32. Осолдсон машиныг зөвхөн замын цагдаагийн газрын ажилтан зөвшөөрсөн нөхцөлд чирэгч буюу трейлерт ачиж замыг чөлөөлнө.
33. Хүчтэй бороо цас орж байгаа болон манантай, карьерт ажиллах орчин муу үзэгдэж байгаа үед карьерт ажил гүйцэтгэхийг хориглоно.

Ажил дуусах үеийн аюулгүй байдлын шаардлага

34. Ажил дуусахад оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
 - Самосвалын техникийн байдалд үзлэг хийж, ямар нэг эвдрэл гэмтэл илэрвэл засвар үйлчилгээ хийлгэх тухай инженер механиктаа мэдэгдэж хийлгэнэ.
 - Машиныг зогсоосны дараа түлш асгараагүй эсэхийг шалгана.
 - Машиныг тэвшний хамт хог хаягдал, бохирдсон зүйлээс нь цэвэрлэж, гал гарах боломжгүй байгаа эсэхийг сайтар нягталж, зогсоолын тоормосыг татна.

- Диспетчер болон хариуцсан ажилтанд замын хуудсыг өгнө.
- Ажлын хувцсыг тайлж, шүүгээнд хийх бөгөөд гар, нүүрээ усаар угааж, шүршүүрт орно. Угаалганд химийн ямар нэг бодис хэрэглэхийг хориглоно.

Асфальт бетон дэвсэгчийн операторын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагууд

1. 18-аас дээш насны, тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй, ажлын дадлага туршлагатай эрчүүд шинээр ажилд орохдоо дараах шаардлагуудыг хангасан байна:
 - Урьдчилсан (ажилд шинээр ороход) болон өдөр тутмын (хөдөлмөрийн үйл ажиллагааны үед) эмчийн үзлэгт орж ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулах;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Операторууд ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох дараах үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Дуу шуугиан,
 - Чичиргээ,
 - Хөдөлж буй машин механизм болон түүний ажлын хэсгүүд;
 - Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон бусад хортой хүчин зүйл нэмэгдэх;
 - Тоног төхөөрөмж болон материалын гадарга халах.
3. Үйлдвэрлэлийн бохирдол, механик нөлөөллөөс хамгаалахын тулд оператор ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас,
 - ажлын гутал: резинэн түрийтэй гутал буюу арьсан ботинка, эсвэл хатуу ултай арьсан түрийтэй гутал,
 - ажлын бээлий,
 - шуугианиас хамгаалах чихэвч буюу хавчуурга,

- хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз.
- Өвлийн цагаар байнга гадаа ажиллах бол нэмэлтээр дараах зүйлсийг хэрэглэнэ:
- дулаалгатай ажлын хувцас буюу хүйтнээс хамгаалах зориулалттай ноосон болон холимог материалтай ажлын хувцас;
 - резинэн ултай эсгий гутал юм уу, хатуу ултай дулаалгатай арьсан ботинка;
 - хамгаалалтын гадаргатай хос, таарсан бээлий;
 - дуу шуугианаас хамгаалах чихэвч;
 - хамгаалалтын нүдний шил;
 - хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз;
 - үйлдвэрлэлийн бүст ажиллах бол хамгаалалтын каска.
4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд оператор компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
5. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
- Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Даамал, менежер буюу удирдах ажилтны үүрэг болгосон ажлыг л гүйцэтгэнэ,
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана,
 - Ямар нэг зөрчил дутагдал, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно,
 - Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгаж, хог, цас, шаврыг арилгах ба материал, машиныг хадгалах дүрмийг зөрчихгүй,
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
- Тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхээ биедээ авч явна;

- Эмчийн үзлэгт орсон байна;
 - Ажлыг аюулгүй гүйцэтгэх тухай мэдлэгээ баталгаажуулж ажиллах зөвшөөрөл авсан ба машины техник ашиглалтын хуудсыг биедээ авч явах ба ажил гүйцэтгэх үүрэг даалгавар (битум цэнэглэх болон ажиллах газар) авна;
 - Байгууллагаас тавьж өгсөн ажлын хувцас, гутал өмсөнө.
8. Үүрэг даалгавар авсны дараа оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- Удирдах ажилтны хамт ажлын байр, ажлын онцлог, ажил гүйцэтгэх газрын онцлогтой танилцаж, анхаарууштай зүйлсийн талаар заавар авна;
 - Асфальт бетон ачих, дэвсэх, зогсох үеийн аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ боолн хамгаалах, урьдчилан сэргийлэх тэмдгүүдийн талаар нарийн мэдээлэл авна;
 - Дэвсэгчийн техник үйлчилгээг хийсэн эсэхийг хянаж, өдөр тутмын техник үйлчилгээг хийсэн байна;
 - Ажлын бүст байгаа машин механизмын жолооч буюу оператор, ажилчдад анхааруулж дуут дохио өгөх ба араа нейтраль байдалд байгаа эсэхийг шалгана;
 - Дэвсэгчийг асааж, хөдөлгүүр болон тоормос, жолооны системүүдийн ажиллагааг шалгана.
9. Аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн үед оператор ажил гүйцэтгэхийг хориглоно:
- Дэвсэгчийн ажлын механизм, системүүд эвдрэлтэй, эсвэл доголдолтой ажиллаж байгаа;
 - Дэвсэгчийн хөдөлгөөн эхлэх орчинд хүн, мал, саад болох зүйлс байгаа;
 - Операторын ажлын байр болон ажиллах талбайд гэрэлтүүлэг хангалтгүй;
 - Ажлын хувцас, гутал, бусад хамгаалах хэрэгсэл байхгүй;
 - Гал унтраах анхан шатны хэрэгсэл байхгүй.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчил дутагдлыг ажил эхлэхийн өмнө оператор өөрийн хүчээр арилгахыг эрмэлзэх ба боломжгүй тохиолдолд удирдах ажилтан, эсвэл ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Ажил эхлэхийн өмнө оператор хөдөлгөөн хийх бүст байгаа хүн, машин механизмын жолооч буюу операторт дуут дохио өгч анхааруулаад, замд саад болох зүйлс арилсны дараа ажиллаж эхэлнэ.

11. Дэвсэгчийн ажлын үеэр оператор механизмын удирдлагын хэсэгт байрлаж, хөдөлгүүрийн ажлын горимыг баримтлах ба хянах самбарыг ажиглаж байх нь зүйтэй.
12. Асфальт бетоны хоёр дэвсэгч нэг талбайд зэрэг ажиллах бол 10 м-ээс багагүй зай барих ёстой. Харин дэвсэгч болон индүү хоёр нэг талбайд зэрэг ажиллах бол 3 м-ээс багагүй зай барих ёстой.
13. Ажлын механизм, үзэлүүдийг асфальт бетон хольцоос цэвэрлэх шаардлагатай болсон үед машиныг бүрэн зогсоож, хөдөлгүүрийг унтраасан байна.
14. Асфальт бетон хольцыг дэвсэгчийн бункер руу хийх, самосвалын тэвшийг цэвэрлэх зэрэг ажлыг асфальт бетоны туслах ажилчид гүйцэтгэнэ.
15. Ажлын үеэр оператор дараах зүйлсийг хориглоно:
 - Жолоодох эрхгүй хүнд жолоо шилжүүлэх;
 - Машиныг бүрэн зогсоогоогүй байхад удирдлагын талбайгаас гарах, орох;
 - Дэвсэгчид халуун хольц хийх үед бункерын хажуугийн халсан хананд ойр зогсох;
 - Асфальт бетон хольцыг дэвсэгчийн бункерт байхад бункерт хүрэх;
 - Дэвсэж буй үеийн зузааныг тохируулж байх үед асфальт бетон дэвсэгчийг талбайд оруулах;
 - Хөдөлгүүрийг тохируулахаас бусад нөхцөлд дэвсэгчийн хөдөлгүүр асаалттай байхад техник үйлчилгээ, засварын ажил хийх буюу хийлгэх.
16. Цахилгааны шугамтай газар ажиллах бол шугамыг эзэмшдэг этгээдийн бичгээр өгсөн зөвшөөрөлтэй үед ажил гүйцэтгэнэ.
17. Дэвсэгчид техник үйлчилгээ, засвар хийхдээ бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай багаж хэрэгсэл ашиглана. Цохилтот багаж хэрэгсэл ашиглахдаа оператор хамгаалалтын нүдний шил зүүх шаардлагатай.
18. Асфальт бетон дэвсэгч өндөрт ажиллах буюу уруудаж явах үед оператор арааг шилжүүлж болохгүй.
19. Асфальт бетон дэвсэгч нийтийн хэрэгцээний замаар хөдөлгөөнд оролцож байгаад өдрийн цагаар замын зорчих хэсэгт зогсох шаардлагатай болвол улаан дарцаг, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед – оврын гэрэл буюу улаан гэрэлтүүлүүр ашиглана.
20. Дэвсэгчийг трейлер дээр ачихдаа трейлер тогтвортой эсэх, сайтар тоормослосон эсэхийг заавал шалгана. Дэвсэгчийг трейлерт ачсаны дараа найдвартай бэхэлнэ. Дэвсэгчийг трейлерээр тээвэрлэх үед дэвсэгчийн бүхээгт оператор байж болохгүй.
21. Асфальт бетон дэвсэгчид түлш, шатахуун хийж байх үед ойр орчимд нь тамхи татах, ил гал гаргахыг хориглоно. Түлш, шатахуун авч дууссаны дараа асгарсан түлш, шатахуун, тос маслыг цэвэрлэж, цэвэрлэсэн зүйлээ тагтай металл саванд хийнэ.

22. Дэвсэгчийн ажиллах бүс болон зогсоолд тавих бүст 50 м- ээс ойр зайд ил гал гаргахыг хориглоно.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

23. Дэвсэгчийн ажиллах замд замын гэрэлтүүлэг хэт ихсэх буюу ажлын механизмыг өргөөд давчихаж болохооргүй саад гарч ирвэл дэвсэгчийг нэн даруй зогсоож, саадыг арилгах арга хэмжээ авна.
24. Дэвсэгчийн ажлын механизмд ямар нэг доголдол, зөрчил дутагдал илэрвэл ажлыг шууд зогсоож, удирдах ажилтандаа мэдэгдэх ба зөрчлийг арилгах арга хэмжээ авна.
25. Гал гарсан үед ажлыг нэн даруй зогсоох шаардлагатай бөгөөд галыг унтраах арга хэмжээ авна. Оператор өөрийн хүчээр унтраах боломжгүй бол удирдаж буй ажилтандаа нэн даруй мэдэгдэж, гал команд дуудна.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

26. Ажил дуусах үед оператор дараах арга хэмжээг авах үүрэгтэй:
- Дэвсэгчийг зогсоолд тавина;
 - Хөдөлгүүрийг унтраана;
- Удирдах ажилтан буюу инженер механикт ажлын үеэр гарсан техникийн бүхий л зөрчил дутагдал, осолд дөхөлтийн талаар мэдээлж, ажлын хуудаст тэмдэглэнэ.

Индүүний операторын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй байдлын ерөнхий шаардлагууд

- 1.1. 18-аас дээш насны, тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй, ажлын дадлага туршлагатай эрчүүд шинээр ажилд орохдоо дараах шаардлагуудыг хангасан байна:
- Урьдчилсан (ажилд шинээр ороход) болон тогтмол (хөдөлмөрийн үйл ажиллагааны үед) эмчийн үзлэгт орж ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулах;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.

2. Операторууд ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох дараах үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Дуу шуугиан,
 - Чичиргээ,
 - Хөдөлж буй машин механизм болон түүний ажлын хэсгүүд;
 - Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон бусад хортой хүчин зүйл нэмэгдэх.
3. Үйлдвэрлэлийн бохирдол, механик нөлөөллөөс хамгаалахын тулд оператор ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас,
 - ажлын гутал: резинэн түрийтэй гутал буюу арьсан ботинка,
 - ажлын бээлий,
 - шуугианиас хамгаалах чихэвч,
 - хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз.Өвлийн цагаар байнга гадаа ажиллах бол нэмэлтээр дараах зүйлсийг хэрэглэнэ:
 - дулаалгатай ажлын хувцас буюу хүйтнээс хамгаалах зориулалттай ноосон болон холимог материалтай ажлын хувцас;
 - резинэн ултай эсгий гутал юм уу, хатуу ултай дулаалгатай арьсан ботинка;
 - хамгаалалтын гадаргатай хос, таарсан бээлий;
 - дуу шуугианаас хамгаалах чихэвч;
 - хамгаалалтын нүдний шил;
 - хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз;
 - үйлдвэрлэлийн бүст ажиллах бол хамгаалалтын каска.
4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд оператор компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
5. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Даамал, менежер буюу удирдах ажилтны үүрэг болгосон ажлыг л гүйцэтгэнэ,
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана,

- Ямар нэг зөрчил дутагдал, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно,
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
- Эмчийн үзлэгт орсон байна;
 - Ажлыг аюулгүй гүйцэтгэх тухай мэдлэгээ баталгаажуулж ажиллах зөвшөөрөл авсан ба машины техник ашиглалтын хуудсыг биедээ авч явах ба ажил гүйцэтгэх үүрэг даалгавар (битум цэнэглэх болон ажиллах газар) авна;
 - Байгууллагаас тавьж өгсөн ажлын хувцас, гутал өмсөнө.
8. Үүрэг даалгавар авсны дараа оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- Удирдах ажилтны хамт ажлын байр, ажлын онцлог, ажил гүйцэтгэх газрын онцлогтой танилцаж, анхаарууштай зүйлсийн талаар заавар авна;
 - Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ болон хамгаалах, урьдчилан сэргийлэх тэмдгүүд бүрэн байгаа эсэхийг шалгана;
 - Индүүний техник үйлчилгээг хийсэн эсэхийг хянаж, сар тутамд үйлчилгээг хийлгэж байна;
 - Ажлын бүст байгаа машин механизмын жолооч буюу оператор, ажилчдад индүүг ажиллуулах гэж буйг анхааруулан дуут дохио өгөх ба араа нейтраль байдалд байгаа эсэхийг шалгана;
 - Хөдөлгүүрийг асаана;
 - Индүүг асаасны дараа бүх агрегатуудын ажиллагаа, тоормосны системийн ажиллагааг шалгана.
9. Аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн үед оператор ажил гүйцэтгэхийг хориглоно:
- Индүүний ажлын механизм, системүүд эвдрэлтэй, эсвэл доголдолтой ажиллаж байгаа;
 - Индүүний түлш, тос масло асгарсан, алдагдсан үед;

- Индүүний байрлаж болох налууугийн түвшин хэтэрсэн үед;
- Ажлын байрны хаалт, хамгаалалт байхгүй буюу ажлын бүст хүн, мал байгаа үед;
- Ажлын хувцас, гутал, бусад хамгаалах хэрэгсэл байхгүй;
- Гал унтраах анхан шатны хэрэгсэл байхгүй.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчил дутагдлыг ажил эхлэхийн өмнө гудранаторын оператор өөрийн хүчээр арилгахыг эрмэлзэх ба боломжгүй тохиолдолд удирдах ажилтан, эсвэл авто гудранаторын ашиглалтын аюулгүй ажиллагааг хариуцсан этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Ажил эхлэхийн өмнө оператор хөдөлгөөн хийх бүст байгаа хүн, машин механизмын жолооч буюу операторт дуут дохио өгч анхааруулаад, замд саад болох зүйлс арилсны дараа ажиллаж эхэлнэ.
11. Хоёр буюу түүнээс дээш тооны индүү нэг талбайд зэрэг ажиллах бол хоорондын зайг 10 м-ээс багагүй, хажуугийн зайг 1 м –ээс багагүй байлгах ёстой. Харин индүү болон дэвсэгч хоёр нэг талбайд зэрэг ажиллах бол индүүний оператор дэвсэгчээс 5 м-ээс багагүй зай барьж ажиллана.
12. Индүүгээр уруу замд ажиллахдаа хальтрах, гулгах, хөмрөх аюулаас сэргийлж, огцом эргэлт хийхгүй байх ба индүүгээр уруудаж яваа бол нэг дүгээр араагаар, өгсөж яваа бол арааг шилжүүлэн ажиллуулна.
13. Ухмал нүх, жалгатай газарт ойр байрлан явахдаа индүүний аль нэг тал нүхнээс хамгийн багадаа 1 м зайтай байх ёстой.
14. Гидро системтэй индүүгээр ажил гүйцэтгэхдээ оператор хамгаалалтын клапан болон уян шлангийн бэхэлгээг шалгаж байх хэрэгтэй. Хийтэй шланг буюу бэхэлгээнээс нь тос гоожсон байвал солих хэрэгтэй бөгөөд өндөр даралттай шлангийг засч болохгүй. Хэрэв гидросистем буюу бусад узельд хэвийн биш дуу орвол оператор индүүг нэн даруй зогсоож, зөрчлийг арилгана.
15. Зөрчил дутагдлыг арилгаж засварлах, индүүний узелүүдэд үзлэг хийх, тослох, тохируулах зэргийг индүүний хөдөлгүүрийг унтрааж, зогсоолын тоормосыг татсан, арааг нейтраль дээр тавьсан үед гүйцэтгэнэ.
16. Индүүний хөдөлгүүр хэт халсан бол оператор салхины дээд талд зогсож радиаторын хоолойг болгоомжтой нээх ба нүүр, гараа түлэхгүйн тулд аюулгүй байрлалд эзлэн зогсоно;
17. Ажлын үеэр операторт дараах зүйлсийг хориглоно:

- Хөдөлгүүр ажиллаж байх үед буюу хөдөлгүүрийг дөнгөж унтраасны дараа ус асгах цоргыг нээх;
 - Хөдөлгүүр халсан байхад радиаторт шингэн хийх;
 - Хөдөлгүүр асаалттай байхад шатах материал хийхгүй байх;
 - Хөдөлгүүр асаалттай байхад индүүг орхиж явах, түүнчлэн жолоодох эрхгүй хүнд жолоо шилжүүлэх;
 - Индүүний бүхээгт гадны этгээд болон шатамхай бодис тээвэрлэх.
18. Индүүнд шатах материал (түлш) хийж байх үед индүүний оператор болон ойр орчимд байгаа хүмүүст тамхи татах, гал гаргахыг хориглоно.
19. Индүүнд түлш хийсний дараа асгарсан зүйлс, тос маслыг арчиж цэвэрлэх ба эдгээрийг арчсан даавуу, материалыг тагтай металл саванд хийж хадгална. Индүүний ажиллах болон зогсох ойр орчимд 50 м-ээс ойр зайд ил гал гаргахыг хориглоно.
20. Индүүг трейлер дээр ачихдаа трейлер тогтвортой эсэх, зогсоолын тоормосыг ажиллуулсан эсэхийг сайтар нягтална. Индүүг ачсаны дараа индүүний тоормосыг ажиллуулж, булыг хөдөлгөөнгүй болгох ба зохих бэхэлгээг хийнэ. Индүүг тээвэрлэх үед индүүний бүхээгт оператор сууж явахыг хориглоно.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

21. Индүүний ажлын механизмд ямар нэг доголдол, зөрчил дутагдал илэрвэл ажлыг шууд зогсоож, удирдах ажилтандаа мэдэгдэх ба зөрчлийг арилгах арга хэмжээ авна.
22. Индүүнд шатах тослох материал буюу өөр хүчин зүйлээс үүдэн гал гарвал гал унтраагуулаар, бусад газарт гарсан галыг элс, шороо, брезент буюу эсгийгээр хучиж унтраах арга хэмжээ авна. Галыг усаар унтраахыг хориглоно.
23. Оператор галыг өөрийн хүчээр унтраах боломжгүй бол удирдаж буй ажилтандаа нэн даруй мэдэгдэж, гал команд дуудна.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

24. Ажил дуусах үед оператор дараах арга хэмжээг авах үүрэгтэй:
- Дэвсэгчийг зогсоолд тавина;
 - Арааг нейтраль дээр тавьж, зогсоолын тоормос татна;
 - Хөдөлгүүрийг унтраана;
 - Бүхээгийг хааж, түгжинэ;

Удирдах ажилтан буюу инженер механикт ажлын үеэр гарсан техникийн бүхий л зөрчил дутагдал, осолд дөхөлтийн талаар мэдээлж, ажлын хуудаст тэмдэглэнэ.

Авто гудронаторын операторын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй байдлын ерөнхий шаардлагууд

1. 18-аас дээш насны, тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй, ажлын дадлага туршлагатай эрчүүд шинээр ажилд орохдоо дараах шаардлагуудыг хангасан байна:
 - Урьдчилсан болон өдөр тутмын эмчийн үзлэгт орж ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулах;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Операторууд ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Хөдөлж буй машин механизм болон түүний ажлын хэсгүүд;
 - Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон газжилт;
 - Тоног төхөөрөмж болон материалын гадарга халах.
3. Механик нөлөөллөөс хамгаалахын тулд оператор ажил олгогчоос тавьж өгсөн дараах зүйлсийг өмсөж, хэрэглэнэ:
 - хөвөн даавуун материалтай комбинзон эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, түрийтэй ажлын гутал, ажлын бээлий, чихэвч ,
 - хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз.Өвлийн цагаар байнга гадаа ажиллах бол нэмэлтээр дараах зүйлсийг хэрэглэнэ:
 - дулаалгатай ажлын хувцас буюу хүйтнээс хамгаалах зориулалттай ноосон болон холимог материалтай ажлын хувцас;
 - резинэн ултай эсгий гутал юм уу, хатуу ултай дулаалгатай арьсан ботинка;
 - хөлдөлтөөс хамгаалдаг, арьсан хавчуургатай, хамгаалалтын гадаргатай бээлий;
 - хамгаалалтын 2-р зэргийн дохионы (фосфортой) ажлын хантааз.

Халуун битумтай ажиллах үед хөвөн даавуун материалтай ажлын хувцасны оронд брезентэн ажлын хувцас хэрэглэх шаардлагатай.

Зам барилгын үйлдвэрлэлийн талбайд ажиллахдаа хамгаалалтын каска өмсөх шаардлагатай.

4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд оператор компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно.
5. Операторын өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - менежер буюу удирдах ажилтны үүрэг болгосон ажлыг л гүйцэтгэнэ,
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана,
 - Ямар нэг зөрчил дутагдал, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно,
 - Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгаж, хог, цас, шаврыг арилгах ба материал, машиныг хадгалах дүрмийг зөрчихгүй,
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
6. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй байдлын шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө оператор дараах шаардлагыг хангасан байна:
 - Тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхээ биедээ авч явна;
 - Эмчийн үзлэгт орсон байна;
 - Ажлыг аюулгүй гүйцэтгэх тухай мэдлэгээ баталгаажуулах бичиг, машины техник ашиглалтын хуудсыг биедээ авч явах ба ажил гүйцэтгэх үүрэг даалгавар (битум цэнэглэх болон ажиллах газар) авна;
 - Байгууллагаас тавьж өгсөн ажлын хувцас, гутал өмсөнө.
8. Үүрэг даалгавар авсны дараа оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
 - Эмийн сан, гал унтраагуул болон бусад шаардлагатай зүйлс байгаа эсэхийг шалгана;
 - Ажлыг аюулгүй, доголдолгүй гүйцэтгэх нөхцлийг хангах үүднээс гудранаторын техникийн байдлыг шалгана. Үүнд дугуй, тоормосны систем, жолооны систем, кардан голын бэхэлгээний болтууд, дамжуулах утас, машины гэрэлтүүлэг, зогсох дохио, эргэлтийн чиг заагч, дуут дохио, хяналтын самбар, толь зэргийг шалгана;

- өдөр тутмын техник үйлчилгээг хийж, машины түлш, тос, ус, антифриз (хүйтний үед) тоормосны шингэн, аккумуляторын ажиллагааг шалгана;
- Машиныг түлш, тосоор цэнэглэсний дараа нефтийн бүтээгдэхүүн асгарч бохирдсон машины бүх хэсгийг цэвэрлэнэ. Шатах тослох материалыг цэнэглэж байх үед асгарсан хэсгийг цэвэрлэхдээ элс, даавуу, үртэс зэргийг ашиглана;
- Битум хайлуулагчийн ажиллагааг шалгана (халаах шингэн, битум дамжуулах труба, цацагч, битум шахах хөдөлгүүр насос, хаалт гм);
- Хөдөлгүүрийг хий ажиллуулж, гэрэлтүүлэх болон хянах хэсгүүд зөв ажиллаж байгаа эсэхийг шалгах ба бага зэрэг хөдөлгөж тоормосны болон жолооны системийг шалгана;
- Ажлын өдрийн эхэнд гудранаторыг гараж буюу зогсоолоос авч гарахдаа хариуцаж харж байсан этгээдэд техникийн бүрэн бүтэн байдалтай авто гудранатор авч гарснаа мэдэгдэн, Ажлын хуудаст бүрэн бүтэн техник хүлээж авсан тухайгаа тэмдэглэнэ.

9. Аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсэн үед оператор ажил гүйцэтгэхийг хориглоно:

- Авто гудранаторын ажлын механизм, системүүд эвдрэлтэй, эсвэл доголдолтой ажиллаж байгаа;
- Битум цэнэглэх механизм болон битум хадгалах савуудад ан цав, ямар нэг эвдрэл гэмтэл ажиглагдсан;
- Битум халаах шингэн болон хайлуулах аль нэг хэсэгт зөрчил, дутагдал илэрсэн;
- Ажлын хувцас, гутал, бусад хамгаалах хэрэгсэл байхгүй;
- Гал унтраах анхан шатны хэрэгсэл байхгүй.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчил дутагдлыг ажил эхлэхийн өмнө гудранаторын оператор өөрийн хүчээр арилгахыг эрмэлзэх ба боломжгүй тохиолдолд удирдах ажилтан, эсвэл авто гудранаторын ашиглалтын аюулгүй ажиллагааг хариуцсан этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Гудранаторт үйлчилгээ хийх (битум цэнэглэх, хайлуулах болон цацах) үед оператор брезентэн ажлын хувцас, резинэн гутал, бээлий, каска, маска, ажлын өмд өмсөх шаардлагатай.
11. Авто гудранаторын цистернийг шингэн битумаар дүүргэх үед оператор дараах үүрэгтэй:

- Автогудранаторыг тэгш талбайд байрлуулж, зогсоох ба цистернийн патруба болон тагны бэхэлгээ найдвартай эсэхийг нягтална;
 - Автогудранаторт халуун шингэн битум цэнэглэж дууссаны дараа асгарсан хэсгийг цэвэрлэж, сайтар таглана.
12. Битум цацах талбайд ирээд оператор дараах үүрэг хүлээнэ:
- Ажил удирдаж буй хүнээс заавар, зааварчилгааг авах;
 - Машин байрлах газарт үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл, хүн, мал байгаа эсэхийг шалгаж, холдуулна;
 - Трубануудын бэхэлгээг хянаж, битумны савтай холбогдсон хэсгийн бат бэх, найдвартай эсэхийг шалгаж байна;
 - Ажил дууссаны дараа таглаж, бэхэлнэ.
13. Шингэн битумыг авто гудранаторын цистернд халаах үед оператор дараах үүрэгтэй:
- Халаахын өмнө цистерн дэх шингэн битумын хэмжээг шалгана. Битумыг халаах ажиллагааг шингэн битумын хэмжээ халаах трубанаас 200 мм-ээс дээш байгаа үед зөвшөөрнө.
 - Форсунк-д хажуугийн, урт бариултай (1.5 – 2 м) асаагуурын тусламжтайгаар гал өгнө;
 - Форсунк-д түлшийг эхлээд бага хэмжээгээр өгч, аажим аажмаар нэмсээр хэвийн хэмжээгээр өгнө;
 - Халаах үед халаах системийн ажиллагаанд хяналт тавина.
14. Авто гудранаторыг суурийн нүх, ухмалд ойр газар байрлуулах буюу явуулахдаа оператор хазгай газарт ойртож болох хамгийн бага зайг заавал баримтална. Энэхүү ойртож болох хамгийн бага зай нь дараах хүснэгтэнд заасан хэмжээтэй байна.

Нүх, ухмалд машины аль нэг хэсгийг ойртуулж болох хамгийн бага зай

Нүхний гүн, м	Нүх, ухмалаас авто гудранаторын ойрын дугуй буюу тулгуур хүртэлх зай, м, гүнээр			
	элсэрхэг	элсэнцэр	шаварлаг	Шавранцар
1	1,5	1,25	1,00	1,00
2	3,0	2,40	2,00	1,50
3	4,0	3,60	3,25	1,75
4	5,0	4,40	4,00	3,00
5	6,0	5,30	4,75	3,50

15. Шингэн битумыг цацахын өмнө оператор форсункийг унтрааж, түлш өгөх трубан оролтыг хаах шаардлагатай.
16. Авто гудранаторыг ашиглах үед битум алдагдаж гоожихоос сэргийлэхийн тулд оператор бэхэлгээ, болтуудыг үе үе чангалж, битумны түвшинг шалгаж байна. Битум урсч гоожсон тохиолдолд дээд түгжээний тагаар нягтруулах жийргийг солино.
17. Шингэн битумыг цацаж дууссаны дараа оператор насосыг унтрааж, хаалтыг хаах ба битумын үлдэгдлийг шлангаар шавхаж, түгжээний тагийг хааж, бэхэлнэ.
18. Автогудранаторыг засварлах, тослох, цэвэрлэх ажлыг зөвхөн хөдөлгүүрийг унтрааж, жолоочоос өөр хүн хөдөлгөх боломжгүй болгох арга хэмжээг авсны дараа гүйцэтгэнэ.
19. Автогудранаторыг өөрөөр нь нэг газраас нөгөө рүү шилжүүлэхдээ оператор МУ-ын Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөнө.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

20. Битум цистерн дотор шатаж эхэлвэл оператор дараах үүрэгтэй:
 - Сайтар таглах ба хэрэв шатаж буй хэсгүүд цистерн дээр байвал гал унтраагуулаар унтраана.
 - Галыг оператор өөрийн хүчээр унтраах боломжгүй бол гал команд дуудаж, удирдах ажилтандаа мэдэгдэнэ.
21. Хэрэв битумыг дамжуулах труба цуурах буюу тасарвал насос буюу машины хөдөлгүүрийг унтрааж, хаалтыг хааж, битумын үлдэгдлийг шлангаар юүлэх ба битумыг дамжуулагч трубаны эвдэрч гэмтсэн хэсгийг солино.
22. Ажил гүйцэтгэж байх үед авто гудранаторын хөдөлгүүр буюу ажлын хэсгүүдэд доголдол, зөрчил дутагдал илэрвэл ажлыг шууд зогсоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

23. Ажил дуусах үед оператор дараах арга хэмжээг авах үүрэгтэй:
 - Цистерн болон битум дамжуулагч трубануудаас үлдэгдэл битумыг юүлж гаргах;
 - Авто гудранаторыг зогсоолд тавьж, зогсоолын тоормосыг ажиллуулах ба жолоочоос өөр хүн машиныг хөдөлгөхгүй байх арга хэмжээ авах;
 - Авто гудранаторыг цэвэрлэнэ;Удирдах ажилтан буюу гудранаторын аюулгүй ашиглалтыг хариуцсан ажилтан ажлын үеэр гарсан бүхий л зөрчил дутагдал, осолд дөхөлтийн талаар мэдээлж, ажлын хуудаст тэмдэглэнэ.

Түлш, усны машины ашиглалтын заавар

1.1. Түлш усны машиныг ажиллуулахын өмнө

Түлш болон Усны машиныг өмнө ажиллуулах зааврыг уншиж, бүрэн ойлгосон эсэхийг шалгуулах.

Ажил хийхэд аюултай ямар нэг зүйл байвал даамал буюу удирдаж буй хүнтэйгээ Түлш болон Усны машиныг ажиллуулахаас өмнө ослоос урьдчилан сэргийлэх үзлэг хийнэ.

Үйл ажиллагааны зааварт заасны дагуу өдөр бүр үзлэг, шалгалт хийж, Түлш болон Усны машиныг эвдэрч, гэмтсэн хэсгүүдийг засч, суларсан болтуудыг чангалсны дараа ажиллуулна.

Эвдрэл гэмтэлтэй түлш болон усны машиныг ажиллуулахыг хориглоно. Бүрэн засварласны дараа ажиллуулахыг зөвшөөрнө.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Түлш болон усны машиныг ажлын дадлагатай, эрх бүхий ажилтнууд ажиллуулна.

Түлш болон усны машиныг ажиллуулах буюу засварлах үед аюулгүй ажиллагааны бүхий л зааварчилгаа, журам, сэрэмжлүүлэг, заавруудыг мөрдөж ажиллана.

Ажлын орчинд буюу замын хөдөлгөөнд өөр жолооч юм уу, хувь хүнтэй хамт ажиллах бол тэдгээр нь бүгдээрээ гар дохиог ойлгодог эсэхийг нягталсан байх нь зүйтэй.

АЮУЛГҮЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛҮҮД

Хаалт хамгаалалтын хэрэгслүүд бүрэн байгаа эсэхийг шалгана. Хэрэв эвдэрч, гэмтсэн байвал засна.

Суудлын бүс зэрэг хамгаалалтын хэрэгслүүдийг зөв хэрэглэнэ.

Хамгаалалтын хэрэгслүүдийг **хэзээ ч** устгаж, үрэгдүүлж, эсвэл авч хаяж болохгүй. Ажлын үед хамгаалах хэрэгслүүдийг **байнга** хэрэглэж байх.

Хамгаалалтын хэрэгслийг буруу хэрэглэх бие эрхтний хүнд гэмтэл буюу үхэлд хүргэж болзошгүй аюултай.

ГАЛ УНТРААГУУЛ БОЛОН АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХЭРЭГСЭЛ

Гал унтраагуул байгаа эсэх, түүнийг хэрхэн хэрэглэхийг мэддэг байна.

Зориулалтын хэсэгт анхны тусламжийн хэрэгслүүд байлгана.

Гал гарсан үед ямар арга хэмжээ авах вэ гэдгийг мэддэг байна

Аливаа осол, гамшиг гарсан үед холбоо барих ёстой хүмүүсийн утасны дугаарын мэддэг байх.

СУУДЛЫН БҮС

Түлш болон усны машиныг ажиллуулахаас өмнө суудлын бүс болон суурилуулсан техник хангамжийн бүрэн бүтэн эсэхийг шалгана.

Суудлын бүсийг үзэмж төрхөөс нь хамааруулан гурван жил тутамд шинэчлэн тавьж байх хэрэгтэй.

1.2. Ажиллуулах үеийн ашиглалтын заавар

Түлш болон усны машинд үсэрч суух, эсвэл үсэрч буухыг хориглоно Шат, бариул тос масло, шатахуун болж, бохирдсон байвал түүнийг нэн даруй цэвэрлэх бөгөөд эдгээр хэсгүүд бохирдсон байж болохгүй.

Түлш болон усны машиныг ажиллуулахаас өмнө ойр орчимд байгаа хүмүүст анхааруулах үүднээс дуут дохио өгнө.

Түлш болон усны машиныг ажиллах орчинд саад болох ямар нэг ажилтан, хүн, эсвэл эд юм байгаа эсэхийг хянаж болгоомжтой ажиллана.

Шаардлагатай бол хамгаалалтын хэрэгслүүдийг байрлуулах.

Ажлын тоног төхөөрөмжийг ажиллуулж байх үедээ ажилдаа бүрэн анхаарал хандуулах.

Битүү орчинд ажиллахдаа түлш болон усны машиныг утаа, угаарын аюулаас сэргийлэх үүднээс агааржуулалтыг шалгах.

Хэрэв түлш болон усны машин цахилгаан хүчдэлийн утсанд хүрвэл, ажиллуулж буй ажилтан суудалдаа үлдэж, бусад хүмүүст хүрч болохгүй гэдгийг сайтар ойлгуулж, хүргэхгүй байх. үсрэн буух бөгөөд буухдаа огт хүрэхгүй байх хэрэгтэй.

Ёмкостонд ачаа ачсан бол огцом эргэх, эсвэл өргөхийг хориглоно. Даацаас хэтэрсэн хэмжээний ачаа ачих нь аюултай. Ачаа зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг хянаж байна.

Түлш болон усны машиныг налуу газар ажиллуулах нь аюултай. Ачаатай үед 10 градусас дээш налуутай газарт ажиллуулахыг хориглоно.

Налуу газарт ажиллах шаардлагатай бол тухайн газрын нөхцөлд тохируулан машины байрлал хурдыг тохируулан ажиллуулна.

Налуу буюу уруу, эсвэл өгсүүр газарт түлш болон усны машиныг түр буюу удаан зогсоохоос сэргийл. Удаан зогсохдоо гар тормозыг татаж, ивүүрээр хаалт хийнэ.

Налуу газарт ажиллахдаа түлш болон усны машиныг хөмрөх буюу гулсах аюултай тул хөндлөн чиглэлээр явахаас сэргийлэх хэрэгтэй.

Налуу газраар явах нь аюултай.

Уруу газарт ажиллуулахдаа болгоомжтой удаавтар явах, тохиромжтой хурдыг сонгож явна.

Чиглэлээ өөрчлөх зайлшгүй шаардлага гарвал тэгш, хатуу гадаргатай хэсэгт эргэх үйлдлийг зөвшөөрнө.

Хөдөлгүүр 30 градусаас дээш хэмжээгээр хазайлгаж ажиллах хориглоно. Ямар ч нөхцөлд дээрх лимитийг хэтрүүлэхгүй байна.

Орчин тойронд аюул байхгүй эсэхийг харж, ачаа зөөх үед түлш болон усны машины ойр орчимд саад байхгүй үед ажиллана.

Түлш болон усны машиныг хөмөрч болзошгүй эрэг газарт ажиллуулахгүй байх.

Бороо орсон буюу хүчтэй салхи, шуурга гарсны дараа ажиллахдаа сэрэмжтэй байх нь зүйтэй. Учир нь хөрс зөөлөрсөн байж болзошгүй юм.

Түлш болон Усны машин нь зөвхөн шингэн тээвэрлэхэд зориулагдсан тул хатуу материалыг тээвэрлэж болохгүй.

Саад, бартаатай буюу тэгш бус газраар явахдаа хурдаа сааруулж, удаан явна.

Усанд ажиллах буюу гүехэн ус гатлах хэрэгтэй болбол ёроолын хөрс шорооны байдал, усны гүн, усны урсгалын хурд зэргийг шалгаж, ус түлш болон усны машины тэнхлэгт хүрэхгүй байх нөхцлийг хангаж, анхаарал болгоомжтой ажиллана.

Түлш болон усны машины буулгалт хийх цэгт хэнийг ч бүү оруул. Ухрах үед дайруулах буюу дарагдах аюултай.

Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед гэрлээ асааж байх.

Тэнгэр бүрхсэн, бороо буюу цас орсоноос шалтгаалан үзэгдэлт хангалтгүй болсон үед болгоомжтой ажиллана.

Гулгаатай буюу мөстсөн зам дээр ажиллах, эсвэл явах үед хурдыг тохируулж, огцом хөдлөх, зогсох, эргэх үйлдэл хийхгүй байх.

Цас орсны дараа зам дээр цасанд дарагдсан ямар нэг зүйл байж болзошгүйг анхаарч, болгоомжтой ажиллана.

Мөстсөн гадарга дээр явахдаа болгоомжтой ажиллана.

Өндрийн хязгаарлалттай хонгил, давхар зам, дээгүүр татсан цахилгааны утастай газраар явахдаа болгоомжтой байна.

1.3. Засвар үйлчилгээ хийх үеийн заавар

Засвар, үзлэгийн үеэр түлш болон усны машины ойр орчимд эрх бүхий этгээдээс бусад хүн, ажилтан байхыг хориглоно.

Түлш болон усны машин чичрэх, хэт халах, эсвэл эд ангиудад ямар нэг эвдрэл гарсан бол нэн даруй зогсоож, үзлэг хийх буюу засна.

Үзлэг буюу засвар хийх үед тэгш газар байрлуулж, хөдлөхгүй байх арга хэмжээг (асаах түлхүүрийг авна) авна.

Хөдөлгүүр халсан үед радиаторын тагийг авч болохгүй. Хөдөлгүүр цельсийн 50 хэмээс доош хүртэл хөрсөн үед тагийг авч болох ба ажилтан халуун шингэн цацрах буюу халуун уур савссанаас үүсэх аюулаас сэргийлнэ.

Доогуур орж ажиллаж болохгүй. Заавал хөдөлгүүрийг унтрааж гар тормоз татаж ивүүрийг ашиглана.

Түлш, тосноос үүдэн галын аюул үүсч болох тул машиныг сэрүүн, хуурай газарт, ил гал гарахгүй газарт байрлуулна. Түлш хийх үед хөдөлгүүрийг үргэлж унтрааж байна.

Тос, тослох материал гоожсон байх нь аюултай тул үргэлж цэвэр, хуурай байлга.

Галын аюулаас сэргийлж, гал унтраагчтай байх. Мөн орон нутгийн хамгийн ойр гал командын газрын утасны дугаарыг мэддэг байх.

Хөдөлгүүрийн хэсгийн хаалт нээлттэй үед хөдөлгүүрт үзлэг, үйлчилгээ хийхдээ анхаарал болгоомжтой байх хэрэгтэй.

Яндан буюу ноцтой түлэгдэл үүсгэж болзошгүй бусад хэсэгт хүрэхийг хориглоно. Капотыг өргөхдөө анхаарал болгоомжтой байж, өргөсний дараа заавал түгшээг түгжсэн байна.

Хөдөлгүүрийг харахдаа капотонд дарагдахгүй байх аюулгүй байрлалд зогсоно . Хүчтэй салхи зэргийн гадны нөлөөллөөс сэргийлнэ .

ЦЭВЭР БАЙЛГА

Үргэлж цэвэр, эмх цэгцтэй байлгана . Шатах, тослох материал гоожсон, замбараагүй орхисон багаж хэрэгсэл, хагарч асгарсан зүйлс зэрэг нь осол гэмтлийн шалтгаан болдог. Цахилгаан системд ус аюултай.

1.4. Зогсоолд тавих үеийн заавар

Орхиж явахдаа зогсох талбайд аюулгүй байрлуулаад, хөдөлгүүрийг унтрааж түлхүүрийг авна. Мөн бүхээгний хаалгыг түгжинэ.

Зориулалтын зогсоолоос өөр газар зогсоох бол машиныг тэгш, аюулгүй газар байрлуулна.

2. Үйл ажиллагааны заавар

Эхний 7000 км дараа хөдөлгүүрийн тос, хөдөлгүүрийн тосны шүүрийг солино.

1.1. Хөдөлгүүрийг асаахын өмнөх шалгалт

Эргэн тойрон харж, доогуур нь суларсан эрэг, болт, бөөгнөрсөн шавар шороо бий эсэх, тос, түлш, хөргөгч шингэний хэмжээ, ажлын тоног төхөөрөмж болон шингэний системийн байдал хэвийн байгаа эсэхийг шалгана. Түүнчлэн цахилгааны утас тасарсан эсэх, их халдаг хэсгээр тоос шороо болсон эсэхийг шалгана.

Ажил хийхэд бэлтгэж, суудлаа аятай байдлаар тохируулна.

Ард талыг харуулах толийг тохируулна.

1.2. Хөдөлгүүрийг асаах болон унтраах ажиллагаа

Индикатор гэрлийг шалгах.

- Зогсоолын тоормосны гэрэл ON байгаа эсэхийг шалгах,
- Хөдөлгөх арааг саармаг байрлалд байгаа эсэхийг шалгах,
- Түлхүүрийг ON гэсэн байрлалд хүртэл түлхэж, дараах зүйлсийг шалгана:

- Зөвхөн 1, 2-р гэрэл асаалттай үлдэж, бусад нь 5 секундын дараа унтрах ёстой.

Хөлөлгүүрийг асаах (хэвийн болон хүйтэн температуртай үед)

Ажлын бүст хүн буюу саад бартаа ажиглагдвал дуут дохио өгч анхааруулна.

Хөдөлгүүрийг асаахын тулд асаах товчлуурыг START хүртэл эргүүлнэ. Хэрэв хөдөлгүүр асахгүй байвал 2 минут орчим хүлээгээд, ахин оролдоно.

Хөдөлгүүр ажиллаж эхлэхэд, ямар нэг доголдол мэдрэгдвэл даруй унтраана.

Хөдөлгүүрийг асаасны дараах хяналт

Хөдөлгүүрийг асаасны дараа дараах зүйлсийг хянаж, баталгаажуулсны дараа ажиллуулж эхэлнэ:

- Ус, тос, түлш гоожсон зүйл байна уу?
- Анхааруулах гэрэл дохионууд бүгд OFF дээр байна уу?
- Халаасны дараа дараах зүйлсийг шалгана:
 - Усны температур заагуур
 - Тосны температур заагуур
 - Моторын дуу болон яндангийн утаа хаялт хэвийн байгаа эсэх,
 - Дуу болон чичиргээ хэвийн байгаа эсэх
 - ❖ Асаасны дараа хөдөлгүүрийн эргэлтийг огцом нэмэгдүүлж болохгүй.
 - ❖ Хянах самбарт ямар нэг асуудал байвал хөдөлгүүрийг унтрааж, шаардлагын дагуу асуудлыг шийдвэрлэж, засна.

Хөдөлгүүрийг унтраах

❖ Хөдөлгүүр өндөр эргэлттэй ажиллаж байхад гэнэт унтраах нь хөдөлгүүрийн ашиглалтын хугацааг богиносгоно. Тиймээс, хөдөлгүүрийг нормал эргэлтэнд ажиллаж байхад нь унтраана.

❖ Хэрэв хөдөлгүүр хэт халсан байвал шууд унтраахгүйгээр, хөртөл нь дундаж хурдтайгаар ажиллуулж байгаад унтраавал зохино.

- Хөдөлгөх арааг саармаг байрлалд тавина.
- Зогсоолын тоормосыг татна.
- Хөдөлгүүрийн эргэлтийг багасгасаар 5 мин хий ажиллуулж, асаалттай байлгана.
- Start буюу хөдлөх байрлалд байгаа түлхүүрийг OFF байрлалд тавина.
- Өөр хүн хэрэглэхээс сэргийлж, түлхүүрээ авна.
- Бүхээгний хаалгыг хаана.

1.3. Халаах ажиллагаа

- Хөдөлгүүрийн эргэлтийг бага багаар нэмэгдүүлж, хөдөлгүүрийг дундаж хурдаар нь ажиллуулна.

1.4. Машиныг хөдөлгөх

1) Үндсэн үйл ажиллагаа.

Хөдөлгөх байдал. эргэн тойрон харж шалгана. Мөн ивүүрийг авч хөдөлгүүрийг анхаарал болгоомжтой асаана.

a) Хөдөлгөх ажиллагаа.

Хөдөлгүүрийг асааж, халаах ажиллагааг дуусгасны дараа дараах дарааллаар машиныг хөдөлгөнө:

- Зогсоолын тоормосыг буулгана,
- Хөдөлгөх арааг эхний араанд хийгээд, хаазан дээр зөөлөн гишгэж хөдөлгөнө. .

b) Хурд өөрчлөх.

a) Хурдаа өөрчлөхийг хүсвэл консыг гишгэж хөдөлгөх арааг хүссэн байрлалдаа аваачина.

b) Урагшлах буюу ухрах ажил хийж байх үед машиныг 1 буюу R дугаар хурдаар нь ажиллуулна.

❖ Өндөр хурдтай явж байх үед хурдаа хасах шаардлагатай бол зогсох тоормос дээр гишгэх ба үүний оронд хүч дамжуулах хөшүүргээр хурд бууруулж болохгүй.

d) Чиглэл өөрчлөх.

a) Машиныг зогсоолгүйгээр чиглэл өөрчлөх боломжтой (урагшлах, ухрах).

b) Чиглэлийг өөрчлөхийн тулд хүрдийг хүссэн зүг рүүгээ зална.

❖ Чиглэлээ өөрчлөхийн өмнө тухайн чигт ямар нэг саад бартаа байхгүй эсэхийг нягталж байх хэрэгтэй.

❖ Өндөр хурдтай явж байхдаа чиглэл өөрчлөхөөс зайлсхийх хэрэгтэй.

e) эргүүлэх.

a) Жолооны хүрдийг хүссэн чиглэл рүүгээ залж, машиныг эргүүлж болно.

b) Та машиныг зүүн буюу баруун тийш 90 градуст эргүүлж чадна.

❖ Машин өндөр хурдтай явж байгаа, эсвэл налуу газар ажиллаж байгаа үед огцом эргүүлж болохгүй.

❖ Хөдөлгүүр унтарсан үед жолооны хүрд ажиллахгүй.

f) Жолоо барьж байх үеийн сэрэмжлүүлэг.

a) Хянах самбарт анхааруулах гэрэл ассан бол хөдөлгөх арааг саармаг байрлалд аваачиж, зогсооно. Бага зэрэг хий ажиллуулсны дараа хөдөлгүүрийг унтраана. Дараа нь үйл ажиллагааг доголдуулсан аливаа асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

- b) тэгш бус газарт ажиллаж байгаа бол бага хурдтай ажиллуулна .
- g) зогсоох.
- a) Машиныг зогсоохын тулд тоормосны дөрөөн дээр гишгэнэ .
- b) Хөдөлгөх арааг саармаг байрлалд шилжүүлнэ.
- c) Зогсоолын тоормосыг дарна.
- ❖ Налуу газарт тавих гэж байгаа бол дугуйг өнхрөхгүй болгож, ивүүр хийнэ
- h) *Хөдөлгүүрийг унтраах.* .
- a) Хөдөлгөх арааг саармаг байрлалд тавьсан эсэхийг шалгана.
- d) Зогсоолын тоормосыг дарна.
- b) Хөдөлгүүрийг 5 минут асаалттай байлгана.

Start буюу хөдлөх байрлалд байгаа түлхүүрийг OFF байрлалд хүртэл эргүүлээд, түлхүүрээ авна.

i) *Хөдөлгүүр унтарсны дараах шалгалт.*

- a) тос масло, ус гоожсон эсэх,
- b) Хөдөлгүүрт ямар нэг хог хаягдал орсон байвал авч хаях.

2) **Налуу газарт ажиллуулах.**

- a) Хэрэв хазайх буюу тэнцвэрээ алдаж эхэлвэл, тоормос дээр гишгэнэ.
- b) Налуу газар зогсоолд тавихдаа өнхрөхөөс сэргийлж дугуйнуудын ард ивүүр

тавина

- ❖ Налуу газар ажиллахдаа маш болгоомжтой байх хэрэгтэй. Энэ нь тэнцвэржилтийг алдагдуулж, хазайх аюулд хүргэж болзошгүй.

1.5. Үр дүнтэй ажиллах арга

1) Ерөнхий зүйл.

- a. Даац хэтрүүлэн ачаалахгүй байх талаар анхаарна.
- b. Буулгах ажил хийхдээ крантыг нээж дууссаны дараа хаана.
- c. Хөдөлгүүрт тоос шороо оруулахгүй тулд машиныг салхины эсрэг зүгт ар талаар

нь харуулж зогсооно.

d. Хүчин чадлаас нь хэтэрсэн хэмжээгээр ажиллуулвал ашиглалтын хугацаа богиносно.

Түлшний машины жолоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

1. 18 болон түүнээс дээш насны, тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй, эмчийн үзлэгт орсон, ажлын дадлага туршлагатай эрчүүд ажиллана.
2. Жолооч бие даан ажил гүйцэтгэж эхлэхийн өмнө ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна:
3. Жолооч нь ажлыг аюулгүй гүйцэтгэх аргачлалд суралцаж, удирдах ажилтандаа энэ талаарх мэдлэгээ шалгуулсан байна.
4. Тогтоосон хугацаанд энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон ажлыг аюулгүй гүйцэтгэх аргачлалын талаарх мэдлэгээ шалгуулаагүй этгээд бие даан ажил гүйцэтгэхийг хориглоно.
5. Жолооч ажил гүйцэтгэх үеэр дараах заавар, зааварчилгааг авч, шаардлагыг хангасан байна:
 - Ажлын байрны давтан зааварчилгаа – улиралд 1-ээс доошгүй удаа авсан;
 - Энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгааг "... ХХК-ийн үйлдвэрүүд болон зам барилгын ажлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журам"-ын дагуу тогтоосон хугацаанд авсан;
 - Эмчийн үзлэгт орж, ажил гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан.
6. Мэргэжлийн чадвар шалгах шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан этгээд түлшний машинаар бие даан ажил гүйцэтгэх эрхгүй бөгөөд нэг сараас ихгүй хугацаанд ахин шалгалт өгч, тэнцсэний дараа ажил гүйцэтгэнэ. Хэрэв техникийн болон энхүү аюулгүй ажиллагааны шаардлагуудыг зөрчсөн бол зөрчлийн онцлогоос хамааруулан давтан зааварчилгаа өгөх ба мэргэжлийн мэдлэг чадварыг шалгах тест дахин авна.
7. Энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгааны шаардлагуудыг зөрчсөний улмаас үүсэх аливаа хохирол, хариуцлагыг жолооч хүлээнэ.
8. Жолооч түлшний машинаар ажил гүйцэтгэх болон машинд үйлчилгээ хийх үед үүсч болох дараах үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөхцлөөс болгоомжлон, өөрийгөө хамгаалах арга хэмжээ авах (аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлэн ажиллах) үүрэгтэй:
 - Машины хөдөлгөөнт, эргэх хэсгүүд;
 - Ажлын бүс дэх агаарын тоосжилт ихсэх;
 - Ажлын байран дахь дуу чимээ ихсэх;
 - Түлш, шатахуун үнэртэх;

- Ямар нэг зүйл унах, цохих;
 - Ажлын бүст агаарын температур нэмэгдэх буюу буурах (халуун болох, хүйтрэх).
9. Түлшний машины жолоочид ажил олгогчоос дараах хамгаалах хэрэгслийг үнэгүй тавьж өгч, хэрэглүүлнэ:
- Хөвөн даавуун материалтай ажлын хувцас
 - Арьсан ботинка
 - Брезентэн бээлий
 - Шуугианаас хамгаалах чихэвч (ажлын байран дахь дуу чимээ ихэссэн үед шуугианаас хамгаалах чихэвч хэрэглэнэ),
 - Амны хаалт (ажлын бүс дэх агаарын тоосжилт ихэсвэл тоосноос хамгаалах амьсгалууртай ажиллана).
- Этилийн бензинтэй харьцах бол резинэн энгэрэвч (хормогч) өмсөнө.
- Хүйтний улиралд ажиллах бол нэмэлтээр хөвөнтэй куртка өгнө. Ажлын хувцас хэрэглэл бага элэгдсэн, цаашид хэрэглэх боломжтой бол ашиглалтын хугацааг хоёр дахин ихэсгэж болох ба ажлын онцлогтой холбоотойгоор нэмэлт ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг тухай бүр олгож байна.
10. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд жолооч компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд машинд гадны этгээд, согтуу хүн тээвэрлэхийг хориглоно.
11. Жолоочийн өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
- Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Даамал, менежер буюу удирдах ажилтны үүрэг болгосон ажлыг л гүйцэтгэнэ,
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана,
 - Ямар нэг зөрчил дутагдал, эвдрэл гэмтэл илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно,
 - Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгаж, хог, цас, шавар, асгарсан ус, тос масло, түлш зэргийг нэн даруй цэвэрлэж байх ба машин, материалыг хадгалах дүрмийг зөрчихгүй,
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
12. Ажлын байр руу явах замд түлшний машины жолооч дараах үүрэгтэй:
- Тээвэрлэлт хийх зориулалттай нийтийн хэрэгцээний замаар явахдаа МУ-ын Замын хөдөлгөөний дүрмийг баримтална;

- Кемп дотор хөдөлгөөнд оролцохдоо тусгайлан бэлтгэсэн түр замаар явна. Түр замаар явахдаа баруун гар талаа барьж явах ба өөдөөс гарч ирэх машин механизмын хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар тооцож явна;
 - Нийтийн хэрэгцээний замаар зорчихдоо 50 км/цаг-с ихгүй, кемп дотор явахдаа 10 км/цаг-с ихгүй хурдтай явна.
 - Бусад тээврийн хэрэгслийн дохиог сайтар анхаарч, замын тэмдэг, тэмдэглэгээ, дохионы шаардлагыг биелүүлнэ;
 - Тээврийн хэрэгслээс бугаад урдуур нь тойрч гарах, эсвэл урдуур нь зам хөндлөн нэвтрэхгүй байна;
 - Төмөр замыг гармаар, зөвшөөрсөн гэрэл дохиогоор гатлах ба хаалтгүй гармаар гарахдаа хоёр талаас ойртон ирж буй галт тэрэг байхгүй эсэхийг нягталж, галт тэрэг ойртож ирж байвал Замын хөдөлгөөний дүрмийн дагуу төмөр замын гармаас 10 м-ээс хол зайд зогсож, өнгөрүүлнэ. Хаалттай гармын өмнө зогсохдоо Зогс тэмдэг, Зогс шугамын өмнө буюу гэрлэн дохио, эсвэл хаалтнаас 5 м-ээс багагүй зайд зогсоно;
 - Ажил явагдаж буй, эсвэл ачаа тээвэрлэж буй газарт аюулгүй байрлалд зогсож, орохыг хориглосон аюултай бүст нэвтрэхгүй байна.
13. Түлшний машинд шатахуун, керосин, спирт, тос болон бусад төрлийн шатамхай бодис хадгалах буюу тээвэрлэхийг хориглоно. Тос маслыг ажлын байрны ойролцоо зориулалтын төмөр сав, хайрцганд ээлжийн хэрэгцээнээс илүүгүй хэмжээгээр хадгалахыг зөвшөөрнө.
14. Машин механизмд ээлжит үзлэг хийх, машинд засварчнаар үзлэг, тохиргоо, засвар, үйлчилгээ хийлгэх, машиныг өдөр тутам ашиглах зэрэгт түлшний машины жолооч удирдах ажилтны зөвшөөрлийг авах ёстой.
15. Жолооч нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед шууд ажлаа зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлага

16. Үүрэг даалгавар авсны дараа оператор дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
- Түлшний машины цистерн дээр “Аюултай ачаа” гэсэн анхааруулах тэмдэг байх ёстой бөгөөд энэ нь 690X300 мм тэгш өнцөгт хэлбэртэй, баруун тал нь 400X300 мм хэмжээтэй улбар шар өнгөтэй, зүүн тал нь цагаан өнгөтэй хар хөвөөтэй 15 см өргөнтэй байна;

- цистерн буюу түлшний савны ар тал болон хоёр хажуу талд улаан өнгөөр “Галын аюултай” гэж бичсэн байх ба галын үед хэрэглэх гал унтраагуул, 25 кг элс, эсгий авч явна;
- Түлшний машины цистерн дээр машины ашиглалтын болон аюулгүй байдлын товч заавартай хүснэгт, анхааруулах тэмдгүүд байх ёстой.
- Түлшний машинд түлш цэнэглэх үед машинд газардуулга хийсэн байх ёстой.
- Эмийн сан, гал унтраагуул, элс, эсгий болон бусад шаардлагатай зүйлс байдаг газрыг бүх жолооч, ажилчид мэддэг байх хэрэгтэй;
- Жолоочийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс цистерн рүү авирах шат, тавцан байх хэрэгтэй;
- Ажлыг аюулгүй, доголдолгүй гүйцэтгэх нөхцлийг хангах үүднээс түлшний машины техникийн байдлыг шалгана. Үүнд түлшний сав, шланг, шлангны бэхэлгээ, дугуй, тоормосны систем, жолооны систем, кардан голын бэхэлгээний боолтууд, дамжуулах утас, машины гэрэлтүүлэг, зогсох дохио, эргэлтийн чиг заагч, дуут дохио, хяналтын самбар, толь зэрэгт анхаарлаа хандуулна (Хөдөлгүүрийг хий ажиллуулж, гэрэлтүүлэх болон хянах хэсгүүд зөв ажиллаж байгаа эсэхийг шалгах ба бага зэрэг хөдөлгөж тоормосны болон жолооны системийг шалгана);
- Түүнчлэн машины тос масло түлш алдагдаж байгаа эсэх, тос масло, тоормосны шингэн, хөргөгч шингэн, аккумуляторын цэнэг зэргийг шалгана;
- Сар тутмын техник үйлчилгээг хийж, машины түлш, тос, ус, антифриз (хүйтний үед) тоормосны шингэн, аккумуляторын ажиллагааг шалгана;
- Машинд түлш цэнэглэсний дараа нефтийн бүтээгдэхүүн асгарч бохирдсон машины бүх хэсгийг цэвэрлэнэ. Шатах тослох материалыг цэнэглэж байх үед асгарсан хэсгийг цэвэрлэхдээ элс, даавуу, үртэс зэргийг ашиглана;
- Машинд ямар нэг шатамхай бодис, тухайлбал керосин, бензин, ацетон тээвэрлэх буюу хадгалж явахыг хориглоно;
- Ажлын өдрийн эхэнд машиныг гараж буюу зогсоолоос авч гарахдаа хариуцаж харж байсан этгээдэд техникийн бүрэн бүтэн байдалтай түлшний машин авч гарснаа мэдэгдэн, Ажлын хуудаст бүрэн бүтэн техник хүлээж авсан тухайгаа тэмдэглэнэ.

17. Ажилд гарахын өмнө жолооч хувцас хэрэглэл өмсөх дараах шаардлагыг хангасан байна:

- Ажлын хувцсаа бүрэн өмсч, бүх товчийг товчилсон байна. Ажлын хувцсыг өмсөхдөө ил гарсан, түлшний болон бусад машин механизмуудын эргэх хэсэг, эд ангиудад татагдаж болохуйц унжсан зүйл байхгүй эсэхийг шалгана;
- Үсээ самнаж, хамгаалалтын каска өмссөн байна;

- Гутлыг бүрэн үдсэн буюу түрийтэй бол түрийг дээш татаж өмссөн байна,
- Ажлын өмдийг хром, түрийтэй гутал буюу эсгий гутал дотор хийж өмсөнө.
- Ажлын хувцасны ханцуйг нугалах, шамлах, гуталны түрийг нугалах, өсгийн дээр гишгэхийг ХОРИГЛОНО;

18. Аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсэн үед оператор ажил гүйцэтгэхийг хориглоно:

- Түлшний машины ажлын механизм, системүүд эвдрэлтэй, эсвэл доголдолтой ажиллаж байгаа;
- Түлшний сав болон түлш дамжуулах хэрэгсэл, машины бусад хэсгүүдэд ан цав, ямар нэг эвдрэл гэмтэл ажиглагдсан.

Аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчил дутагдлыг ажил эхлэхийн өмнө машины жолооч өөрийн хүчээр арилгахыг эрмэлзэх ба боломжгүй тохиолдолд удирдах ажилтан, эсвэл түлшний машины ашиглалтын аюулгүй ажиллагааг хариуцсан этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

19. Дараах зүйлсийг ХОРИГЛОНО:

- Эвдрэл, доголдолтой машины механизм, эд ангиудыг солих буюу засварлахаас өмнө ажиллуулах;
- Ээлжинд согтуугаар гарах, ажлын байранд спиртийн төрлийн ундаа уух, мансууруулах бодис хэрэглэх;
- Ээлж хүлээлгэж өгөлгүй буух, ажлын хуудаст ажлын өдрийн тэмдэглэл хөтлөлгүй ажлаас буухыг хориглоно.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

20. Машиныг асаахын өмнө ойр орчмын машин техникийн жолооч, оператор, ажиллаж буй хүмүүст сонсогдохуйц дуут дохио өгнө.
21. Түлшний машинд түлш цэнэглэх үед машинд газардуулга хийсэн байх ёстой.
22. Түлшний машины жолооч бэртэл гэмтэл авахаас сэргийлж, ёмкостиг давж гарах, дээгүүр нь эд зүйлс өгөлцөж авалцах, машины доогуур хэвтэх, түлш дамжуулах хэсэгт гараа хийхийг ХОРИГЛОНО.
23. Жолооч шатаар дээш гарахдаа яарахгүй байх, ус, тос, бохир зүйлс асгарсан хэсэг дээр гишгэхгүй байх бөгөөд өндөр гишгүүртэй шатнаас буухдаа гишгүүрт нь нүүрээ цохихоос сэргийлж анхаарал болгоомжтой байна.
24. Ажлын үеэр дараах зүйлсийг ХОРИГЛОНО:
 - Хөдөлгүүр асаалттай байхад бүхээгт унтах, амрах;

- Өвчтэй буюу ажлын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд ядарсан үед ажилд гарах;
 - Жолоодох эрхийн үнэмлэхгүй буюу машиныг ажиллуулах зөвшөөрөлгүй бусад этгээдэд жолоо шилжүүлэх;
 - Эргэх механизмуудыг ажиллаж байх үед нь цэвэрлэх, арчих, тослох;
 - Ажлын байр болон үйлчилгээ хийж буй машины ажлын орчинд гэрэлтүүлэг хангалтгүй байвал цахилгаанчныг дуудах ба түүнийг ирэх хооронд гар чийдэн ашиглана;
 - Машины ёмкостон дээр багаж хэрэгсэл, бусад зүйлсийг тавих, хадгалах;
 - Үйлдвэрийн цахилгааны щит, цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж, газардуулгагүй дамжуулагч зэрэгт хүрэх, хаалтыг нээх, оролдох.
25. Хэвийн бус ажиллагаатай болсон, өөрөөр хэлбэл эвдрэл гэмтэл, ан цавтай болсон багаж хэрэгсэл, эд ангитай машиныг ашиглаж ажил гүйцэтгэх, ослын үеийн хамгаалах хэрэгслүүд байхгүй буюу дутуу, эсвэл ажиллагаагүй үед ажил гүйцэтгэх зэргийг ХОРИГЛОНО.
26. Ёмкость руу шлангаар түлш дамжуулах үед ойр орчимд нь тамхи татах, ил гал гаргахыг ХОРИГЛОНО.
27. Машинд засвар, цэвэрлэгээ, тосолгоо, үйлчилгээ хийхдээ бүрэн унтрааж, машины түлхүүр дээр “асааж болохгүй, хүн ажиллаж байна” гэсэн тэмдэг тавина.
28. Машин механизм руу түлш хийж байх явцад түлш гацаж, явахаа больвол механик аргаар буюу гар багажаар доголдлыг арилгах арга хэмжээ авна.
29. Энэ зорилгоор шланг буюу машины түлшний сав, банкинд гараа оруулахыг ХОРИГЛОНО.
30. Түлшний машинд гал, дэлбэрэлт үүсэхээс сэргийлж жолооч машиныхаа тоос шороог үе үе цэвэрлэж ариун цэврийг сайтар сахих ба ойр орчмын хүмүүст ил гал гаргахгүй, тамхи татахгүй байх шаардлагыг тавьж ажиллана.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

31. Осол гарсан үед машины хөдөлгүүрийг унтрааж, хохирогчид анхны тусламж үзүүлэх бөгөөд түргэн тусламж дуудаж, удирдах ажилтандаа яаралтай мэдэгдэнэ.
32. Гал гарвал гал унтраагуул, элс, шороо, эсгий зэргээр галыг унтраах арга хэмжээ авна.
33. Хэрэв жолооч өөрөө осолд өртвөл бэртэл гэмтлийн байдлыг харгалзан объектын эмч, эмнэлгийн тусламж авах буюу өөртөө анхны тусламж үзүүлнэ.
34. Ажил гүйцэтгэж байх үед түлшний машины хөдөлгүүр, түлшний сав буюу ажлын бусад хэсгүүдэд доголдол, зөрчил дутагдал илэрвэл ажлыг шууд зогсоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

35. Ажил дуусахад түлшний машины жолооч дараах үүрэгтэй:
 - Машиныг зогсоолд тавьж, зогсоолын тоормосыг татах ба жолоочоос өөр хүн машиныг хөдөлгөхгүй байх арга хэмжээ авах;
 - Машинаа цэвэрлэж, суларсан боолтыг чангалж, хэрэгтэй газар нь тосолгоо хийлгэнэ. Машины гадна талыг цэвэрлэхдээ арчих материалыг гартаа буюу хуруундаа ороохыг ХОРИГЛОНО;
 - Шланг болон ажилд хэрэглэгддэг эд хэрэгслийг хураах үед шатамхай бодис, тухайлбал керосин, бензин, ацетон хэрэглэх буюу ойр хавьд байлгахыг ХОРИГЛОНО;
 - Удирдах ажилтан буюу инженер механикт ажлын үеэр гарсан бүхий л зөрчил дутагдал, осолд дөхөлтийн талаар мэдээлнэ;
 - Ээлж хүлээлэлцэж, ажлын хуудаст ажлын тэмдэглэл хөтөлнө.

Усны машины жолоочийн ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй байдлын ерөнхий шаардлагууд

1. 18-аас дээш насны, тохирох ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй, ажлын дадлага туршлагатай эрчүүд шинээр ажилд орохдоо дараах шаардлагуудыг хангасан байна:

- Урьдчилсан (ажилд шинээр ороход) болон тогтмол (хөдөлмөрийн үйл ажиллагааны үед) эмчийн үзлэгт орж ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулах;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.
2. Ажилд шинээр орж буй хүнд ажлын заавар, энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгаа, байгаль орчны шаардлагуудын талаар ажлын байрны зааварчилгаа өгч, заавар өгсөн, заавар авсан этгээдүүдийн гарын үсэг, огноотой тэмдэглэл үйлдэнэ.
 3. Жолооч ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Хөдөлж буй машин механизм болон түүний ажлын хэсгүүд;
 - Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон газжилт;
 - Тоног төхөөрөмж болон материалын гадарга халах.
 4. Ажлын байрны давтан зааварчилгааг улиралд 1-ээс доошгүй удаа өгнө.
 5. Технологийн дараалал өөрчлөгдсөн; тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, машин механизмыг шинэчилсэн буюу өөрчилсөн; усны машины жолоочийг осол, бэртэл гэмтэл, галын аюул, тэсрэлт дэлбэрэлт үүсэх аюултай нөхцөл байдал үүссэн; ажил хуанлийн 30 хоног буюу түүнээс илүү хугацаагаар завсарласан зэрэг үеүдэд ээлжит бус давтан зааварчилгаа өгнө.
 6. Заавар, зааварчилгаа авсан ажилтан журмын дагуу өгсөн зааварчилгаанаас авсан мэдлэгээ шалгуулахад хангалтгүй гэж үнэлэгдвэл ажилд гарах эрхгүй бөгөөд дахин зааварчилгаа авч, удирдах ажилтандаа мэдлэгээ шалгуулж, зөвшөөрөл авсны дараа ажилд гарна.
 7. Усны машины жолооч удирдлагаас өгсөн үүрэгт ажлыг л гүйцэтгэнэ.
 8. Усны машины жолооч дараах зүйлсийг заавал мэдэж байх ёстой:
 - Усны машины ашиглалтын заавар;
 - Энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгаа;
 - Зам барилгын машин, тракторын жолооч нарын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа;
 - Мөрдөгдөж буй Замын хөдөлгөөний дүрэм;
 - Авто зам дээр ус цацах технологи;

- Усны машины хөдөлгүүр, ажлын механизмуудад үзлэг хийх, зөрчил дутагдлыг арилгах талаар мэддэг байх.
- 9. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд жолооч компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд машины бүхээгт гадны этгээд, согтуу хүн тээвэрлэхийг хориглоно.
- 10. Жолоочийн өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
 - Машиныг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Даамал, менежер буюу удирдах ажилтны үүрэг болгосон ажлыг л гүйцэтгэнэ,
 - Машиныг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана,
 - Ямар нэг зөрчил дутагдал, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл машиныг ажиллуулахыг хориглоно,
 - Ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгаж, хог, цас, шаврыг арилгах ба материал, машиныг хадгалах дүрмийг зөрчихгүй,
 - Ажлын үеэр анхааралтай байж, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагуудыг зөрчихгүй байх.
- 11. Оператор нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед ажлаа шууд зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 12. Энэхүү аюулгүй ажиллагааны зааварчилгааны шаардлагуудыг биелүүлээгүйгээс болж үүссэн хохирол, гарзыг усны машины жолооч хариуцаж, хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

Ажил эхлэхийн өмнөх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

- 13. Ажилд гарахын өмнө усны машины жолооч дараах үүрэгтэй:
 - Эмчийн үзлэгт орж, ажиллах зөвшөөрөл авах;
 - Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөх;
 - Удирдлагаас ажлын даалгавар, заавар авах;
 - Инженер механикийн хамт машины техникийн байдлыг шалгана. Үүнд:
 - Аккумуляторын цэнэг, тоормосны систем, жолооны систем, усны насос, гэрэлтүүлэг, дохио, бүхээгний хаалга, усны цистерний бэхэлгээ, яндангийн дуу намсгагч гэх зэрэг;
 - Тос масло, ус, шатахуун гоожиж асгарсан эсэх;

- Дугуйны хий;
 - Эмийн сан, гал унтраагуул гэх зэрэг хамгаалах хэрэгслүүдэд анхаарлаа хандуулна.
14. Жолооч ажлаа гүйцэтгэх явцад үүсч болох аюултай болон хүчин зүйлсийн талаар мэддэг, тэднээс өөрийгөө урьдчилан сэргийлдэг байх ёстой:
 - Халуун ус ба пар – хүний арьсанд хүрвэл түлэгдэлт үүсгэнэ;
 - Шатамхай болон хортой хийн зүйлс (пропан, бутан, нүүрстөрөгчийн эсэл гэх мэт) – эдгээр нь амьсгалын замаар хүний бие организмд маш хүнд хор уршиг бий болгоно;
 - Этилийн бензин – амьсгалын болон хоол боловсруулах эрхтэн, арьсанд маш хортой.
 15. Усны машины жолооч нь түүний ажлын байр болох авто зам нь өөрөө өндөр аюултай ажлын бүс гэдгийг санаж байх ёстой.
 16. Жолооч хувийн сахилга батыг сайтар сахих үүрэгтэй бөгөөд хоол идэх, тамхи татахын өмнө гараа усаар угаах, машины эд анги болон этилийн бензинтэй харьцсаны дараа гараа керосиноор угаах шаардлагатай.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

17. Худаг руу усны машин ухарч очих бол жолооч нь цоргоны ойр орчимд болон түүн рүү очих замд гадны этгээд, хүн мал, саад тотгор байхгүй эсэхийг нягтална.
18. Худгаас холдохдоо жолооч усны шланг машинаас бүрэн гарч, байрандаа очсон эсэхийг харна.
19. Усны машины жолоочид дараах зүйлсийг хориглоно:
 - Худгаас ус авахдаа машины хөдөлгүүрийг асаалттай байлгах;
 - Ажиллаж байх үеэр нь насосны редукторын тосны түвшинг шалгах;
 - Ажиллаж байх үеэр нь усны насосны жийргэвчийг тослох, чангалах;
 - Машиныг цистернийн бэхэлгээ муу буюу шаардлага хангахгүй байгаа үед ашиглах.
20. Хөдөлгүүр халуун байхад радиаторын тагийг нээхдээ бээлий өмсөх буюу алчуураар жийрэглэх ба нээсэн хүний нүүр, гар руу цоргихгүй байхаар тооцож, болгоомжтой ажиллана.
21. Усны машиныг нийтийн хэрэгцээний замаар барьж явахдаа МУ-ын Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх бөгөөд зорчих хэсэг буюу хөвөөн дээр зогсох шаардлага гарвал тус дүрмийн дагуу ослын дохио өгч, ослын тэмдэг тавина.
22. Зам дээр машинд үзлэг, үйлчилгээ хийхдээ жолоочийн хөл машинаас илүү гарч, авто зам дээр байрлахгүй байхаар тооцно.

23. Жолооч өөрийн хүчээр машины эвдрэлийг засах боломжгүй бол удирдлагаасаа зөвшөөрөл авч, засварчинд хандана.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

24. Хэрэв авто замын осол гарвал жолооч дараах үүрэгтэй:
- Нэн даруй зогсч, тээврийн хэрэгсэл болон осолд хамаатай эд зүйлсийг байрнаас нь хөдөлгөхгүй байна;
 - МУ-ын Замын хөдөлгөөний дүрмийн дагуу ЗЦГ-т хандах буюу бусад арга хэмжээг авна;
 - Шаардлагатай үед эмнэлгийн тусламж дуудна.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

25. Ажил дууссаны дараа жолооч дараах үүрэгтэй:
- Усны машиныг зогсоолд байрлуулна;
 - Хөдөлгүүрийг унтраана;
 - Машины зогсоолын тоормосыг татна;
 - Ажлын багаж хэрэгсэл, механизмуудыг шаардлагын дагуу тавина;
 - Усны машиныг жолоочоос өөр этгээд хөдөлгөх боломжгүй болгох арга хэмжээг авна.
26. Гар нүүрээ бүлээн ус, савангаар угаана. Тос, бензин, керосиноор гараа угаах, бохирдсон алчуураар арчихыг хориглоно.
27. Усны машины жолооч инженер механик болон удирдах ажилтандаа машиныг бүрэн бүтэн хүлээлгэн өгөх бөгөөд засвар үйлчилгээ хийх шаардлагатай зүйлсийн талаар мэдээлж, машин хүлээлгэж өгсөн бүртгэл хөтөлнө.

Гагнуурчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Энэхүү зааварчилгааг МУ-ын ХАБЭА-н тухай хууль, компанид ХАБЭА-н менежментийн систем нэвтрүүлэх ILO OSH 2001 удирдамжын шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

1. Цахилгаан гагнуурчны ажилд 18 нас хүрсэн, эмнэлгийн үзлэгт орсон, цахилгаан гагнуурын ажлын мэргэжлийн үнэмлэх буюу бусад гэрчлэх үнэмлэх, сертификаттай, цахилгаан гагнуурчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан этгээд гүйцэтгэхийг зөвшөөрнө.
2. Аюултай ажлыг менежерийн өгсөн үүрэг даалгаврын дагуу гүйцэтгэнэ. Цахилгаан гагнуурчид 2 –с доошгүй зэрэгтэй байх бөгөөд ажлаа аюулгүй гүйцэтгэх чадвар эзэмшсэн байна.
3. Гагнуурын бүх ажлыг тусгайлан зориулсан газар буюу гагнуурын ажилд зориулсан тоноглогосон газарт (бүхээг, гагнуурын пост, нээлттэй талбай гм) гүйцэтгэнэ.
4. Гагнуурчин дараах үүрэгтэй:
 - Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон цахилгаан гагнуурчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн үндсэн мэргэжил, өдөр тутам гүйцэтгэдэг ажил шигээ сайн мэддэг байх;
 - Гагнуурын объект болон ажлын ойр орчимд тамхи татахгүй байх,;
 - Ацетилентай генератор, хийн баллон, бүх төрлийн шатамхай бодис буюу шингэн, будагтай газар буюу будаг хадгалж буй газар, бусад гал гарч, дэлбэрэлт үүсч болох газар, хэсэг рүү ил гал гаргасан байдалтай ойртож болохгүй;
 - Хүчилтөрөгчийн баллонд өчүүхэн бага хэмжээний тос масло ороход дэлбэрэлт үүсэх аюултай байдаг тул хүчилтөрөгчтэй баллоны ойролцоо байхдаа баллонд тос масло орохгүй байхад анхаарч ажиллах ба тос масло болсон гараар баллонд хүрэхгүй байх;
 - Ажиллахыг хориглосон машин, механизм, тоног төхөөрөмжийг осол аюул тохиолдсоноос бусад үед асаахгүй байх;
 - Тоног төхөөрөмж, машин, механизмын хөдөлж буй хэсгүүдэд хүрэхгүй байх, цахилгаан төхөөрөмжид хүрэхгүй байх, шалан дээгүүр явсан зөөврийн цахилгаан дамжуулах утсан дээр гишгэхгүй, дарахгүй байх;
5. Хөдөлмөрийн дотоод журам болон Цахилгаан гагнуурчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааны заалтуудыг зөрчсөн этгээд сахилгын болон эд материалын хариуцлага хүлээнэ. .
6. Гагнуурчин нь гагнуурын аппаратын бүрэн бүтэн байдал, ашиглалтын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.
7. Цахилгаан гагнуурын аппаратыг залгах тусгай төхөөрөмжгүйгээр сүлжээнд залгах буюу сүлжээнээс салгахыг хориглоно.

8. Цахилгаан нумын тэжээлийг зөвхөн гагнуурын трансформатор, генератор, шулуутгагчаас авна. Гагнуурын агрегатыг 0.5 кВ-аас илүү хүчдэлтэй цахилгаан сүлжээнд залгахыг хориглоно.
9. Гагнуурын оч үсрэх, хайлсан металл цацрах болон үйлдвэрлэлийн аюултай болон хортой хүчин зүйлсээс бие, амьсгалын эрхтэн, харах эрхтнээ хамгаалах үүднээс компаниас тавьж өгсөн ажлын хувцас, гутал, хувийн хамгаалалтын бусад хэрэгслүүдийг (нүдний шил, гагнуурын малгай, цахилгааны бээлий гм) бүрэн өмсөж хэрэглэнэ.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Ажлын хувцас хамгаалах хэрэгслийг шалгаж аваад, өмсөнө. Ажлын хувцас нь бүрэн бүтэн, хуурай, тос масло болоогүй байх ёстой. Брезентэн хувцас нь кармагүй, ажлын өмдөн дээр өмсөхөөр байх ёстой. Өмд нь урт, ботинк буюу түрийтэй гутал дээр өмсөхөөр байх ёстой бөгөөд бүх хувцас, гутлыг бүрэн өмсч, цахилгаандана. таавчиг, сандаль гэх мэттэй ажил гүйцэтгэхийг хориглоно.
11. Ажлын байр болон түүн рүү орох хэсэг хангалттай гэрэлтүүлэгтэй байгаа эсэхийг шалгана. Гагнуурын ажил хийх ажлын бүсийн гэрэлтүүлэг 30 лк-ээс багагүй байх ёстой. Гэрэлтүүлэг нь нүд гялбуулахгүй байх ёстой.
12. Ажлын байрны эмх цэгцийг хангаж, шал халтиргаатай байгаа бол хөл доорх илүү зүйлсийг хурааж, асгарсан зүйлсийг цэвэрлэх шаардлага тавих буюу өөрөө цэвэрлэнэ.
13. Гагнуурын хэрэгслүүдийг цэгцтэй тавьж, бэхэлнэ. Гагнуурын ажлын бүсийн ойр орчмын 15 м зайд байгаа бүх төрлийн шатах тослох материал, шатамхай бодисуудыг хурааж, зайлуулахыг хариуцсан хүн байгаа бол түүнээс шаардаж, байхгүй бол өөрөө зайлуулна. Эсвэл тэдгээр галын аюултай зүйлсийг гагнуурын оч үсрэхээс найдвартай хамгаална. Ажлын бүс дэх галаас хамгаалах хэрэгслүүдийн (элс, ус, гал унтраагуул гм) тоо хэмжээ, хүрэлцээ, бүрэн бүтэн байдлыг шалгана.
14. Шаардлагатай үед менежер буюу ажлыг удирдаж буй ажилтны хамт гагнуурын багаж, хэрэгслүүдийг байрлуулах газрыг сонгож, тохиролцоно.
15. Ил талбай, үйлдвэрийн аль нэг хэсэгт гагнуур хийх гэж байгаа бол автомашин, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ачаа бараа, авто ачих буюу буулгах механизм болон ажилд аюул учруулж болох бусад зүйлсийг зайлуулсан байх ёстой.
16. гагнуур хийх газрын тал талаас орох хэсгүүд зэрэг нь 1м-ээс багагүй зайтай, гагнуурын ажил гүйцэтгэх, багаж төхөөрөмжийг зөөх, засвар хийх үеүдэд тохитой, аюулгүй нөхцлийг хангасан байх ёстой. Ус асгарсан газарт гагнуурын зөөврийн багаж төхөөрөмжийг суурилуулахыг хориглоно.

17. Хувийн хамгаалах хэрэгсэл болон урьдчилан хамгаалах хэрэгслүүдийн (самбар, маска, хамгаалалтын хар шил, бээлий, цахилгааны бээлий, түрийтэй гутал, гм) бүрэн бүтэн байдал, тоо хэмжээг шалгана.
18. Самбар, гагнуурын баг, маска, цахилгаанаас хамгаалах бээлий, түрийтэй гутал гэх мэт хамгаалах хэрэгслүүд нь ямар нэг гэмтэлгүй байх ёстой. Ахуйн резинэн бээлий, шаардлага хангахгүй хамгаалах хэрэгсэл гутал, бээлийтэй ажиллахыг хориглоно.
19. Хамгаалалтын хар шил (гэрэл шүүгч) нь үзэгдүүлэх түвшнээрээ гагнуурын ажилд хэрэглэгдэж буй тогны хүчтэй тохирсон байх ёстой.
20. Дараах маркийн хамгаалалтын шил хэрэглэнэ:

Тог 500 А хүчтэй бол -ЭС-500, Тог 100-аас 500 А хүчтэй бол- ЭС-300 ,
Тог 100 А хүртэл хүчтэй бо-ЭС-100

Гэрэл шүүгчийн зориулалтаар тохиолдлын өнгөт шил ашиглахыг хориглоно.

21. Гагнуурчны туслах ажилчид нүдээ гагнуураас хамгаалахын тулд хамгаалалтын хар шил буюу В-1, В-2, В-3 маркийн гэрэл шүүгчтэй нүдний шил хэрэглэх ёстой.
22. Ажилд шаардлагатай гар багаж, хэрэгслийг бэлтгэж, шалгана. Ажилд зөвхөн бүрэн бүтэн, хуурай, цэвэр багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах ба тэдгээрт дараах шаардлагууд тавигдана:

- Гар багажын бариул нь хатуу модоор хийгдсэн байна. Зөөлөн, олон давхаргатай модоор хийсэн бариул хэрэглэхийг хориглоно. Бариулны гадарга нь гөлгөр, ан цавгүй, , яргүй, зууван огтлолтой, төгсгөлдөө бага зэрэг бүдүүрсэн байх ёстой.
- Алх, лантуунуудын бариулыг найдвартай бэхэлсэн байна. Алхны бариулны урт нь 300 мм-ээс богиногүй, лантууны бариул багажны жингээс хамаарч 400-900 мм байх ёстой.
- Зубиль, алх, лантуу гэх мэт багажуудын цохих хэсэг нь бага зэрэг товгор, гөлгөр; цохидоггүй хэсгүүдийн гадарга нь эвдрэлгүй, ан цавгүй, цөмөрхийгүй, хонхорхойгүй байна
- Гайк, түлхүүрнүүд нь эвдрэлгүй, ам нь сунаагүй байх ба хэмжээ нь яг тохирсон түлхүүр хэрэглэх ёстой. Түлхүүрний хэв алдагдсан, ам нь сунасан тохиолдолд хэрэглэхийг хатуу хориглоно. Торцовон түлхүүрүүд нь хонхойсон ирмэггүй, толгой нь цуураагүй байна.

23. Цахилгаан гагнуурын аппарат, хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдал, цахилгаан газардуулгын зөв эсэхийг шалгана.. Нэг трансформаторын газардуулгыг нөгөөд хэрэглэхийг хориглоно.
24. Цахилгаан гагнуурын аппаратын биеийг газардуулахдаа хамгийн түрүүнд газардуулах оролтыг газарт нэгтгэж, дараа нь аппаратын хавчуурт хийнэ. Газардуулгыг гаргахдаа эсрэг дарааллаар гаргана.
25. Генератор, трансформатор, регулятор болон щеткуудыг үзэж, цэвэр, бүрэн бүтэн байгаа эсэхийг нь шалгана.
26. Цахилгаан гагнуур, гагнуурын цахилгаан дамжуулагч, тэдгээрийн нэгдсэн хэсгүүдийн байр байдал, зөв ажиллаж буй эсэхийг шалгана. Цахилгаан гагнуурын оролт нь уян биш, хөндийрөөгүй, тогны хүчдэлийн аюулаас хамгаалж газардуулга хийгдсэн байна.
27. Цахилгаан тэжээл дамжуулагч болон гагнуурын зөөврийн трансформатор хоёрын хоорондын урт 10м-ээс ихгүй, харин бага трансформаторын хувьд 1.5 м-ээс ихгүй байна.
28. Цахилгаан гүйдэлтэй бүх хэсгүүд найдвартай тусгаарлагдсан, хязгаарлагдсан, эсвэл хүн хүрэхээргүй газарт байрласан байх ёстой. Хэрэв цахилгаан тоног төхөөрөмж хэвийн бус ажиллаж байвал цахилгаанчныг дуудах бөгөөд өөрсдөө засах гэж оролдож болохгүй.
29. Баригч электродыг зөв барьсан эсэхийг шалгана. Бариул нь тусгаарлагдсан, дамжуулагчтай холбогдсон хэсгүүд найдвартай байх ёстой. Дамжуулагчийн тог баригч болон гагнуурын хэрэгсэлд холбох ажлыг холбогч хошууны тусламжтайгаар хийнэ. Дамжуулагчийн цахилгаан баригчтай холбогдсон газар тусгаарлагдсан байх ёстой. Гагнуурт 500 А-с илүү тог ашиглаж байгаа үед цахилгаан дамжуулагч цахилгаан баригчтай холбогдсон байх ёстой.
30. Багажны заалтаар генератор юм уу трансформаторын хавчуур дахь хүчдэл тогтмол гүйдэлтэй аппаратны хувьд 115 В, тогтмол бус гүйдэлтэй аппаратын хувьд 70 В-с хэтэрч болохгүй.
31. Ажил эхлэхийн өмнө дээрх шаардлагууд зөрчигдөж, техник хэрэгсэл эвдрэл гэмтэлтэй, ажиллах орчин нөхцөл хангагдаагүй тохиолдолд ажлыг гүйцэтгэхээс татгалзах бөгөөд менежертээ, эсвэл удирдаж буй ажилтандаа мэдэгдэж дээрх зөрчлүүд арилсны дараа ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө. Цахилгаан тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг өөрөө засварлахыг хориглох бөгөөд заавал цахилгаанчнаар засуулна.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

32. Ажлын үеэр цахилгаан гагнуурчин дараах үүрэгтэй:

- Удирдлагаас үүрэг болгон даалгасан ажлыг л гүйцэтгэнэ. Хэрэв ажлыг аюулгүй гүйцэтгэх арга нь тодорхойгүй, эсвэл ойлгомжгүй байвал удирдаж буй хүнээсээ тодруулна;
- Удирдлагаас аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй бол шинээр ажилд орох, ажил гүйцэтгэхийг хориглоно;
- Ажил гүйцэтгэх бүх хугацаанд өөрийн ажлын байрны эмх цэгц, цэвэр байдлыг хангах бөгөөд хөл доор тос масло, хөрсөн шингэн, үртэс болон бусад зүйлс байх ёстой;
- Гар, гутал, хувцас, бээлий үргэлж хуурай байх ёстой бөгөөд тос масло, бензин гэх зэрэг аюултай бодис болж, бохирдоогүй байх ёстой;
- Ажлын байранд тухайн ажилд хамааралгүй этгээдийг нэвтрүүлэхгүй байна.
- Туслах ажилчидтай хамт ажиллахдаа тэднийг аюулгүй ажиллах арга барилд сургаж, гүйцэтгэлд нь хяналт тавина;
- Гараа масло, эмульс, керосиноор угааж болохгүй бөгөөд үртэс болсон хувцас, алчуураар арчиж болохгүй. Хэрэглэсэн арчих материалыг тусгай метал саванд хадгална;
- Осол аваар болбол өртсөн хүнд яаралтай анхны тусламж үзүүлнэ;
- Бусад ажилчид Ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон бусад дүрэм, журмыг зөрчиж байвал тоолгүй өнгөрч болохгүй. Тэдгээр ажилчдад аюул болон техникийн аюулгүй байдлын шаардлагын талаар урьдчилан анхааруулах нь зүйтэй.

33. гагнуурчин төхөөрөмжийг тогны эх үүсвэрт тусгай дамжуулагчаар залгана. Дамжуулагчаар дурын металл ашиглахыг хориглоно.
34. Цахилгаан гагнуурын аппаратын дамжуулагч нь механик нөлөөлөл, гэмтэл, өндөр температур, чийгээс хамгаалагдаж тусгаарлагдсан, эсэхийг гагнуурчин шалгаж байна. Цахилгаан гагнуурын дамжуулагчийг хаалга, үүд гэх зэрэгт тавих гэж байгаа бол модон хайрцаг, эсвэл трубагаар хамгаалах шаардлагатай.
35. Гагнуурын кабелийг хүчдэлтэй байгаа, өндөр температуртай, хүчил төрөгчийн баллон болон ацетилиний генераторт ойр байгаа хийн гагнуурын хоолой болон трубан дамжуулгатай хамт байлгахыг хориглоно.
36. Гагнуурын аппаратын байрлалыг өөрчлөн шилжүүлж байх үед гагнуурын цахилгаан дамжуулагчид залгах, дамжуулагчийг угз татан салгахыг хориглоно.
37. Завсарлага, цайны цаг, цэвэрлэгээ, үзлэг, богино хугацаанд ажлын байраа орхиж явах, аппаратыг зөөх үеүүдэд гагнуурын аппаратыг унтраана.

38. Гагнуурын ажлыг гадаа, ил талбайд хийхдээ эргэн тойрны ажилчдын гагнуурын оч гэх зэрэг хортой нөлөөнөөс хамгаалах үүднээс 1.8 м-ээс багагүй өндөртэй, галд тэсвэртэй, тунгалаг биш, зөөврийн хязгаарлагчаар хязгаарлалт хийнэ.
39. Гадаа гагнуурын ажил хийхдээ цаг агаарын нөлөөнөөс хамгаалах үүднээс гагнуур хийх ажлын дээгүүр саравч барих шаардлагатай. Хэрэв саравч барих боломжгүй бол бороо, цас орж буй үед ажлыг зогсооно.
40. Гагнуурын ойр орчимд байгаа хүмүүсийг нүдээ аньж, гагнуур руу харахгүй байхыг шаардана. Цахилгаан нум руу хамгаалалтын шил зүүгээгүй бол ажилчин өөрөө ч харахгүй, өрөөл бусдыг ч харахыг зөвшөөрөхгүй байна.
41. Ажлын бүст цахилгаан баригчийг тогтой үед анхаарал хяналтгүй орхиж явж болохгүй.
42. Хайлсан металлын цацарсан үртсүүдээс хамгаалахын тулд гагнуурын газрын бүх эд хэрэглэлийг цэвэрлэсэн, тос масло, бензин болон бусад бохирдлыг арилгасан байхыг хариуцсан этгээдээс шаардах буюу хариуцсан ажилтан байхгүй бол өөрөө гүйцэтгэнэ. Гагнуур хийхийн өмнө багаж хэрэгсэл, ойр орчмын эд зүйлийг бензин, керосиноор арчих буюу дээр нь асгахыг хориглоно.
43. Гагнуурын үед хөл дээр оч, хайлсан металлын үртэс, бусад аюултай зүйлс унахаас сэрэмжилж, хамгаалалтын хувцас хэрэглэлийг зориулалтын дагуу, бүрэн өмсч хэрэглэнэ.
44. Гагнуурын ажлыг машин механизмд хийхдээ самосвалын тэвш өргөгдсөн үед, бусад машин, тоног төхөөрөмжийн ажлын эд ангиуд хангалттай бэхлэгдээгүй буюу хөдөлгөөнтэй байгаа үед гүйцэтгэхийг хориглоно.
45. Гагнуурын ажлыг өндөр нь хязгаарлагдмал газар, барилга байгууламж дотор, өндөр хүчдэлтэй газар, худагны дэргэд болон бусад аюултай газарт гүйцэтгэхдээ удирдаж буй хүнээсээ аюулгүй байдлын нэмэлт зааварчилгаа, эсвэл дээрх ажлыг гүйцэтгэх зааврыг асууж, зөвлөгөө авах хэрэгтэй. Ажлыг аюулгүй гүйцэтгэх арга аргачлал, заавар, зааварчилгаа ойлгомжгүй буюу тодорхойгүй санагдсан тохиолдолд менежер болон удирдаж буй хүний зөвшөөрөлгүйгээр ажил эхлэхийн хориглоно.
46. Онцгой аюултай байр байшин, түүнчлэн худаг, хонгил, хий буюу шингэн нөөцөлдөг том сав, цистернд ажиллахдаа гагнах гэж буй хэрэгсэлд электрод залгахад гагнуур автоматаар асдаг, хий ажиллуулахад автоматаар зогсдог, эсвэл хүчдэлийг 12 В болтол бууруулдаг цахилгаан түгжигчтэй гагнуурын төхөөрөмж ашиглана.
47. Хаалттай емкость буюу худаг дотор ажиллахдаа хоёр туслах ажилчинтай хамт ажиллана. Туслах ажилчид нь гадна талд байх бөгөөд шаардлагатай тохиолдолд тусламж үзүүлнэ.

48. Хаалттай емкость буюу худаг руу тагаар нь орохдоо тагны түгжээ онгорхой байхаар бат бэх тогтсон эсэхийг шалгана. Бат бэх биш бол битүү орчинд ажиллахад таг хаагдаж, аюул үүснэ.
49. Емкость, худаг гэх мэт битүү газарт гагнуур хийхдээ цахилгааны хамгаалалттай бээлий, түрийтэй гутал, емкостийн гадна байгаа туслахын нэг үзүүрээс нь барьж буй татлагад бэхэлсэн хамгаалалтын бүс зэргийг заавал хэрэглэнэ.
50. Емкостон доторх гэрэлтүүлгэнд 12 В-оос ихгүй, хамгаалалтын сеткээр тоноглогдсон, зөөврийн гэрэл ашиглана. Зөөврийн гэрэлтүүлгийн трансформатор нь емкостийн гадна талд байх бөгөөд газардуулгатай байна. Автотрансформатор ашиглахыг хориглоно.
51. Өндөрт ажиллахдаа заавал шаттай байх бөгөөд шат хэрэглэх боломжгүй богино хугацааны ажил хийх гэж байгаа бол галд тэсвэртэй, найдвартай зүйлд бэхэлсэн хамгаалалтын бүс хэрэглэнэ.
52. Өндөрт шат буюу тавцан дээр ажиллах гэж байгаа бол тэдгээр хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгана. Шат, тавцангийн гишгэх хэсгүүд нь тэгш, халтиргаагүй, тос масло асгараагүй; шат буюу тавцан нь газарт сайн бэхэлж суурилуулсан байх ёстой.
53. Ажлын үеэр шатыг өөрөө барих, буулгах (энэ ажлыг ажлын туршлагатай мужаан хийх ёстой), ажиллаж байхад нь зөөх, өөр хэн нэг зөөхийг хориглох бөгөөд үүнд анхаарал тавина.
54. Гагнуурын ажлыг хуурай модон байшинд, хуурай модон шал буюу дэвсгэр дээр гүйцэтгэх бол гагнуурын оч гал гаргахгүй байх аюулгүй ажиллагааны бүх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Гагнуур хийж буй газраас 5 м-ээс ойр зайд байгаа хана, гүйдэг хана, хаалга, гагнуур хийж буй газрын шал, дэвсгэр зэргийг гөлмөн төмөр, эсгий болон галд тэсвэртэй бусад материалаар бүтээнэ.
55. Шатан дээр бэхлээгүй ямар нэг зүйл үлдээх буюу түүнийг газар руу унагаж болохгүй.
56. Нэг шатан дээр гишгэж өндөрт ажиллаж буй гагнуурчид босоогоор нэг шугамд гагнуурын ажил хийхийг хориглоно. Учир нь гагнуурын оч, хайлсан металл бусдынхаа дээрээс унавал осол, золгүй явдал үүсгэж болзошгүй юм.
57. Өндөрт ажиллах үеэр багаж, электрод, гагнах хэсгийг тэмдэг хэрэгслүүдийг хийх цүнх ашиглана.
58. Өндөрт, эсвэл барилгын талбайд ажиллахдаа хамгаалалтын каска өмсөнө.
59. Цас бороо орж буй эсвэл хүчтэй салхитай үед өндөрт ажиллахыг хориглоно.
60. Ажлын үеэр ажиглагдсан ажлын байран дахь болон тоног төхөөрөмжийн үл тохирлын тухай удирдаж буй хүндээ хэлж засуулах ба түүний зөвшөөрөлгүйгээр ажлыг үргэлжлүүлж болохгүй.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

61. Гагнуурын ажил гүйцэтгэж байх үед осол үүсэхээс сэрэмжлэх үүднээс цахилгаан гагнуурчин дараах үүрэгтэй:
- Гагнуурын тоног төхөөрөмж, цахилгаан дамжуулагч, цахилгаан баригч, хамгаалалтын газардуулга зэргийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгаж;
 - Өөрийн биеийн ил хэсгүүдийг (нүүр, нүд, гар) ультрафиолет, хэт улаан туяа, цахилгаан нумын нөлөөнөөс хамгаалах, бусдыг хамгаалахыг шаардах;
 - Гагнуурыг түлш, шатах тосох материал, шатамхай бодис хадгалж байсан баллон, сав зэрэгт ойртуулж болохгүй. Тэдгээрийн урьдчилан цэвэрлэж, тэсрэх дэлбэрэх, шатах аюулгүй болгосны дараа гагнуурын аппаратыг ойртуулж болно.
 - Хүчдэлтэй трубан дамжуулагч болон саванд тэдгээрийг ямар хий буюу шингэнээр дүүргэснээс үл хамааран гагнуур ойртуулж болохгүй.
62. Осол гарсан, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирсан тохиолдолд аюулын эх үүсвэрийн үйлчлэлийг хамгийн түрүүнд арилгаж (тоног төхөөрөмжийг унтраах гм), хохирогчид эмнэлгийн анхны тусламж үзүүлнэ.
63. Анхны тусламжийг цаг алдалгүй, боломжтой бол осол гарсан даруйд үзүүлнэ.
64. Цус алдаж буй үед шархыг яаралтай дарж боон (хөвөн давхарлаж, бинтээр ороон чанга бооно), цус алдалтыг зогсооно.
65. Хүчтэй цус алдаж байгаа тохиолдолд эрчилсэн алчуур, бүс зэргээр (гартаа шархдсан бол бугуй, шууг нь, хөлдөө шархдсан бол гуяыг нь) бооно.
66. Гар юм уу хөл нь далд хугарсан тохиолдолд хугарсан хэсэгт нь хоёр хавтгай модоор чиг тавьж, хөдөлгөөнгүй болгон бинтээр бооно. Хэрэв ил хугарсан бол халдвар оруулахгүй болгож боогоод, цус алдалтыг зогсоох арга хэмжээ авна.
67. Хэрэв түлэгдсэн бол түлэгдсэн хэсэглт ариутгасан боолт тавина. Түлэгдсэн хэсэгт наалдсан хувцсыг хуулж болохгүй, харин болгоомжтойгоор наалдаагүй хэсгийг нь хайчилж авна.
68. Цахилгаан гүйдэлд цохиулсан бол хохирогчийг хүчдэлээс нэн даруй холдуулна (гүйдлийг салгаж, хохирогчийг хуурай палка болон урт модоор салгана). Хохирогч гүйдэлд цохиулсаар байхад биед нь хүрч болохгүй. Цахилгаан гүйдлээс салгасны дараа нэн даруй эмнэлгийн тусламж үзүүлнэ. Хэрэв хохирогч ухаан алдсан байдал нэн даруй зүрхэнд нь массаж хийж, эмчийг ирэх хүртэл хиймэл амьсгаа хийнэ. Үүний зэрэгцээгээр спирттэй хөвөн буюу алчуур үнэрлүүлж, биеийг нь арчиж, дулаацуулах арга хэмжээ авна.

69. Эмнэлгийн анхны тусламж үзүүлсний дараа хохирогч хамгийн ойр байрлах эмнэлэгт хүргэгдэх шаардлагатай.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

70. Гагнуурын аппаратыг гүйдлээс салгана. Байнгын тогоор гагнуур хийхдээ эхлээд байнгын тог, дараа нь гагнуурын машины хөдөлгүүрийг тэжээдэг хувьсах тогийг салгана.
71. Гагнуурын гүйдэл дамжуулагчийг эвхэж хийх зориулалтын газарт тавина.
72. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах хэрэгсэл болон хамгаалах хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, шүүгээнд хурааж хийнэ.
73. Гагнуур хийгдсэн металлын улайссан хэсгүүд хүрч болох газруудыг шалгаж үзээд, үсэрсэн металл, хог хаягдал байгаа эсэхийг шалгаж цэвэрлэнэ.
74. Ажлын байрны эмх цэгцийг шалгаж, ээлжийн ажилтан буюу даамалдаа ажлын байрыг хүлээлгэж өгөөд, ажлын байранд гарсан үл тохирол, алдаа дутагдлын талаар мэдээлэл өгнө.
75. Нүүр, гараа угааж, шүршүүрт орно.

Тоног төхөөрөмж, машин механизмын засварчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

1. Засварчнаар 18-аас дээш насны, мэргэжлийн үнэмлэх буюу ажлын дадлага туршлагатай хүмүүс ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн өдөр тутмын үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байх;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байх.
2. Засварчин нь ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох дараах үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Тоног төхөөрөмж, машин механизмын гадаргын температур халах,
 - Эд материал, тоног төхөөрөмж, машин механизмын гадаргын хурц ирмэг, зэтэр, арзгар барзгар гадарга, эргэх болон хөдлөх механизмууд,

- Өндөрт ажиллах шаардлагатай байрлал,
- Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон бусад хортой, галын аюултай хүчин зүйл нэмэгдэх,
- Машин, механизм болон эд ангиудын хөдөлж буй хэсгүүд.

3. Үйлдвэрлэлийн ерөнхий бохирдол болон механик нөлөөллөөс хамгаалахын тулд тоног төхөөрөмжийн засварчин ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсч, хэрэглэнэ:

- хөвөн даавуун материалтай, эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас, ажлын гутал, ажлын хос, таарсан бээлий, эсвэл холимог материалан гадаргатай бээлий, хамгаалалтын нүдний шил; дуу шуугианаас хамгаалах чихэвч буюу хавчаар.

Өвөл гадаа ажиллахдаа нэмэлтээр байгууллагаас тавьж өгсөн дараах зүйлсийг өмсч хэрэглэнэ:

- дулаалгатай ажлын хувцас, эсвэл хүйтнээс хамгаалахад зориулсан холимог буюу ноос, ноолууран материалтай ажлын хувцас,
- резинэн ултай эсгий гутал, хатуу ултай өвлийн арьсан гутал,
- хөлдөлтөөс хамгаалах гадаргатай бээлий.

Үйлдвэрлэлийн талбайд ажиллаж байхдаа засварчин хамгаалалтын каска өмсөх шаардлагатай.

Гагнуурчинтай хамт ажиллах тохиолдолд хамгаалалтын гэрэл шүүгчтэй нүдний шил хэрэглэнэ.

4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд тоног төхөөрөмжийн засварчин компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн байлгахыг хориглоно.

5. Засварчны өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:

- Жижиг механик хэрэгслүүдийг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
- Ажлын байран дахь эмх цэгцийг хадгалж, хог, цас, шалбаагийн цэвэрлэх ба тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ба бусад материалыг хадгалах горимыг зөрчихгүй байна;
- Зөвхөн даамал буюу ажил удирдах ажилтны даалгаж өгсөн ажил үүргийг гүйцэтгэнэ;
- Ажлын үеэр анхаарал болгоомжтой байж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг зөрчихгүй ажиллана.

6. Засварчин нь хүний амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй болон осолд дөхсөн тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед ажлаа шууд зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө цахилгаанчин дараах шаардлагыг хангасан байна:
 - Тавьж өгсөн каска, ажлын хувцас, гутлыг бүрэн өмсөнө;
 - Менежертээ ажлыг аюулгүй гүйцэтгэх аргачлалын талаарх мэдлэгээ шалгуулна;
 - Гүйцэтгэх ажлын онцлогт тохирсон үүрэг даалгавар, ажиллах заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
8. Үүрэг даалгавар авсны дараа цахилгаан монтер шаардлагатай тохиолдолд дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
 - Хувийн хамгаалалтын шаардлагатай хэрэгслүүдийг бэлтгэж, тэдгээрийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг шалгана;
 - Ажлын байр болон түүн рүү орох хэсгүүдийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэхийг шалгана;
 - Ажилд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цуглуулж, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагаа, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан эсэхийг шалгана;
 - Зөөврийн гэрлийн чийдэн хэрэглэхдээ бүрэн бүтэн байдал, дамжуулагчийн хоолойн тусгаарлагчийн бүтэн байдлыг шалгана.
9. Засварчин аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсэн тохиолдолд ажил гүйцэтгэхийг хориглоно:
 - Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажилчдыг хамгаалах хэрэгслүүдийн ажиллагаанд ямар нэг зөрчил дутагдал, дефект үүссэн тохиолдолд;
 - Технологийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд ээлжит үзлэгт цагтаа ороогүй бол;
 - Ажилчдыг хамгаалах хэрэгслүүдийн ашиглалтын хугацаа дууссан буюу ээлжит үзлэгт цагтаа ороогүй бол;
 - Зам хучилтын болон туслах үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж, узель, аппарат, бусад дамжлагууд хэвийн бус ажиллаж байгаа үед;
 - Хүчдэлтэй цахилгаан тоног төхөөрөмж, утас, дамжуулагчийн ойролцоо байрлаж байгаа үед;
 - Ажлын байр, түүний орох гарах хэсгүүдийн гэрэлтүүлэг хангалтгүй үед;
 - Гал унтраагуул болон галаас хамгаалах хэрэгслүүд байхгүй үед.

Аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчлүүдийг ажил эхлэхийн өмнө цахилгаанчин өөрөө арилгахыг эрмэлзэх ба боломжгүй нөхцөлд даамал, эсвэл ажлыг удирдаж буй хүндээ мэдэгдэж зөрчлийг арилгуулах үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Ажлын үеэр засварчин аюулгүй байдлын дараах шаардлагуудыг биелүүлэн ажиллах үүрэгтэй:
 - Зам, барилгын техник, машин механизм, тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээ хийж байх үедээ машины удирдлагын хэсэг болон араан дээр “Хөдөлгүүрийг асааж болохгүй – хүмүүс ажиллаж байна!” гэсэн бичиг наана;
 - асфальтзаводын машин механизм, тоног төхөөрөмжид засвар хийх үед (машины тоормосны систем, цахилгаан тоног төхөөрөмж, карбюраторын ажиллагааг шалгахаас бусад үед) хөдөлгүүр бүрэн унтарсан байна;
 - Машин доогуур орох, гарах үед машин механизм, хүн явахгүй талаас орж, гарна;
 - Машин доор байрлахдаа машины уртын дагуу, дугуй буюу гинжний хооронд хэвтэнэ;
 - Гагнуурын ажил эхлэхээс өмнө бензин, дизель түлш, тос маслыг хамж, бензиний савыг хаана;
 - Машин механизм болон тоног төхөөрөмжийг задлах, угсрах ажлыг суурин буюу зөөврийн засварын газарт, зориулалтын, бэхлэгчтэй тавцан дээр гүйцэтгэнэ;
 - Засварын ажлыг өргөгч механизмтай машинаар тоног төхөөрөмжийг өргөсөн байрлалд гүйцэтгэхгүй;
 - Машин болон тоног төхөөрөмжийн угсрах хэсгүүд өөрийн жингээс болж хөдлөх буюу өнхрөх аюултай тул тоног төхөөрөмжийг тулгуур дээр тавьж, бэхлэх ба машин механизмыг дугуй, гинжинд нь ивүүр болон өнхрөлтөөс хамгаалах өөр хэрэгсэл тавина;
 - Ажлын байранд шатамхай шингэн болон тослох материал хадгалахгүй.
11. Данхраадыг бат бэх, тогтвортой модон ивүүр дээр тавина. Данхраадын өргөлтийн өндөр нь машин, тоног төхөөрөмж болон тэдгээрийн хэсгүүдийн өргөгдөхөд зөвшөөрөгдсөн хэмжээнд байна. Машиныг данхраадаар өргөсний дараа хөл тавина. Зөвхөн данхраадаар өргөж, хөл тавиагүй машин доогуур орж ажиллахыг хориглоно.
12. Тэвшээ өргөсөн самосвал дээр ажил гүйцэтгэхдээ урьдчилан тэвхийг тулгуур штанг дээр тавина.
13. Машин, тоног төхөөрөмжийн тос, маслыг хураахдаа заавал тусгай саванд хийнэ. Санаандгүй асгасан тос масло, асгасан солидолыг нэн даруй үртэс, хуурай элсээр булж, тусгайлан бэлдсэн газарт цуглуулж хураана.
14. Тахир гол, кардан голыг гараар эргүүлэх шаардлагатай үед засварчин түлш өгөлт болон галлагаа (дизель машины хувьд) унтарсан эсэх, арааг Нейтраль дээр тавьсан эсэх,

- зогсоолын тоормоз дээр тавьсан эсэхийг шалгах ёстой. Ажил дууссаны дараа зогсоолын тоормозыг татаж, 1 дүгээр араан дээр тавина.
15. Дугуйг авах, буцааж хийх ажлыг тавцан дээр юм уу тэгшхэн цэвэр талбай дээр гүйцэтгэнэ. Дугуйг өргөж ажиллах бол данхраад, хамгаалагч хэрэгсэлгүйгээр хийхийг хориглоно. Данхраатыг алх, лантуугаар угз татахыг хориглоно.
 16. Асфальтбетон хольцын үйлдвэрийн засвар, үйлчилгээг өндөр тавцан дээр хийхдээ засварчин 300 мм-ээс багагүй урттай зориулалтын шат хэрэглэх ёстой. Залгамал шат хэрэглэхийг хориглоно.
 17. Асфальтбетон хольцын үйлдвэрийн тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээг хийхдээ хөдөлгүүр, дамжуулга, , рамыг авах, тээвэрлэх, байрлуулах ажлыг өргөгч хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэнэ. Өргөгч хэрэгсэл нь аваарын тоноглолтой, ажлыг аюулгүй гүйцэтгэх баталгаатай байх ёстой.
 18. Машинд үзлэг, засвар хийх ажлыг үзлэгийн газарт хамгаалалтын шил зүүж гүйцэтгэнэ.
 19. Засварын ширээ болон эд ангиудыг үртэс, тоосноос цэвэрлэхдээ хялгасан шётка, хамгаалалтын нүдний шил хэрэглэх шаардлагатай. Металлын үртсийг шахсан агаараар үлээлгэж цэвэрлэхийг хориглоно.
 20. Асфальтбетон хольцын үйлдвэрийн тоног төхөөрөмжид үзлэг хийхдээ 42 В-с илүүгүй хүчдэлтэй зөөврийн цахилгаан чийдэн хэрэглэх ба хэрэв агаарын чийгшил ихтэй, эсвэл ил агаартай газарт хийх бол 12 В-с илүүгүй хүчдэлтэй чийдэн хэрэглэнэ. Тоног төхөөрөмжид үзлэг хийхдээ ил гал ашиглахыг хориглоно.
 21. Цахилгаан гагнуурчинтай хамт ажиллахдаа хамгаалалтын гэрэл шүүгчтэй нүдний шил хэрэглэнэ.
 22. Тоног төхөөрөмж, машин механизмыг өргөхдөө өргөдөг механизм ашиглах ба түүний зааврыг судалсан байна.
 23. Гар цахилгаан машинтай ажилладаг засварчид аюулгүй ажиллах арга барилд сайтар суралцсан байна.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

24. Гал гарсан үед ажлаа жогсоож, (гал унтраагуул, эсгий , элс, хүчтэй даралттай усаар) гал унтраах ажилд оролцох ба өөрсдийн хүчээр унтраах боломжгүй нөхцөлд гал команд дуудна.
25. Засвар, үйлчилгээний үеэр үйлдвэрийн узель, тоног төхөөрөмж, машин механизмын тогтворжилт алдагдвал ажлаа зогсоож, менежер буюу удирдах ажилтандаа мэдэгдэнэ.

Үүний дараа засварчин машины хэсгүүд хөдлөх, унахаас сэргийлэх арга хэмжээнд оролцоно.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

26. Ажил дууссаны дараа засварчин дараах үүрэгтэй:
- Ажлын байрыг эмх цэгцтэй болгож, багаж хэрэгсэл, туслах материалуудыг хураана;
 - Ажилд хэрэглэгдсэн цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, механизмуудыг унтрааж, тогноос салгана;
 - Гар багаж, ажлын хувцас, гутал, хамгаалах хэрэгслүүдийг тайлж, хадгалах зориулалттай газарт хадгална;

Ажил гүйцэтгэх үед тохиолдсон анхаарвал зохих асуудлын талаар даамал юм уу удирдах ажилтандаа мэдээлнэ.

Цахилгаанчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

1. Цахилгаанчнаар 18-аас дээш насны, мэргэжлийн үнэмлэх буюу ажлын дадлага туршлагатай хүмүүс ажиллах ба ажил эхлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:
 - Объектын эмчийн урьдчилсан болон өдөр тутмын үзлэгт хамрагдаж, ажлыг хэвийн гүйцэтгэх чадвартай гэдгээ баталгаажуулсан байх;
 - Ажлаа аюулгүй арга аргачлалаар гүйцэтгэхэд суралцсан байх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан байх, ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байх.
2. Цахилгаанчин ажлын онцлогтой холбоотойгоор үүсч болох дараах үйлдвэрлэлийн аюултай болон хортой нөлөөллөөс хамгаалах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллана:
 - Цахилгаан утасны хүчдэл ихэсч, хүний биед нөлөөлж болох үе,
 - Тоног төхөөрөмжийн гадаргын температур халах,
 - Өндөрт ажил гүйцэтгэгдэж болох байрлал,
 - Байгууламж болон тоног төхөөрөмжийн хурц ирмэг, зэтэр, арзгар барзгар гадарга,

- Ажлын бүс дэх агаарын тоосжилт болон бусад хортой, галын аюултай хүчин зүйл нэмэгдэх,
 - Машин, механизм болон эд ангиудын хөдөлж буй хэсгүүд.
3. Үйлдвэрлэлийн ерөнхий бохирдол болон механик нөлөөллөөс хамгаалахын тулд цахилгаанчин ажил олгогчоос үнэгүй тавьж өгсөн дараах зүйлсийг өмсч, хэрэглэнэ:
- хөвөн даавуун материалтай, эсвэл хөвөн даавууны хольцтой ажлын хувцас,
 - ажлын гутал,
 - ажлын хос, таарсан бээлий; эсвэл хөвөн даавуун материалтай бээлий; эсвэл холимог материалан гадаргатай (цахилгааны хамгаалалттай) бээлий,
 - хамгаалалтын нүдний шил.
- Өвөл гадаа ажиллахдаа нэмэлтээр байгууллагаас тавьж өгсөн дараах зүйлсийг өмсч хэрэглэнэ:
- дулаалгатай ажлын хувцас, эсвэл хүйтнээс хамгаалахад зориулсан холимог буюу ноос, ноолууран материалтай ажлын хувцас,
 - резинэн ултай эсгий гутал, хатуу ултай өвлийн арьсан гутал,
 - хөлдөлтөөс хамгаалах гадаргатай бээлий.
- Үйлдвэрлэлийн талбайд ажиллаж байхдаа цахилгаанчин хамгаалалтын каска өмсөх шаардлагатай.
4. Үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд цахилгаанчин компанийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд гадны этгээд, согтуу хүн байлгахыг хориглоно.
5. Цахилгаанчны өдөр тутмын ажилд дараах шаардлагууд тавигдана:
- Багаж хэрэгслийг зориулалтын дагуу, үйлдвэрлэсэн үйлдвэрээс өгсөн зааврын дагуу ашиглана;
 - Зөвхөн даамал буюу ажил удирдах ажилтны даалгаж өгсөн ажил үүргийг гүйцэтгэнэ;
 - Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг техникийн бүрэн бүтэн байдалтайгаар ашиглана;
 - Ямар нэг зөрчил, осолд дөхөлт, эвдрэл гэмтэл, бүрэн бүтэн бус байдал илэрвэл багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хэрэглэхийг хориглоно;
 - Ажлын үеэр анхаарал болгоомжтой байж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудыг зөрчихгүй ажиллана.
6. Цахилгаанчин нь хүний амь нас, эрүүл мэндэд аюул учирсан бүх нөхцөл байдал, үйлдвэрт болсон бүх золгүй болон осолд дөхсөн тохиолдол, өөрийн эрүүл мэндийн байдал муудах, мэргэжлээс шалтгаалах цочмог өвчин илрэх, хордлогод орох зэрэг үед ажлаа шууд зогсоож, удирдлагадаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлагууд

7. Ажил эхлэхийн өмнө цахилгаанчин дараах шаардлагыг хангасан байна:
 - Удирдах ажилтандаа ажлыг аюулгүй гүйцэтгэх аргачлалын талаарх мэдлэгээ шалгуулж, гүйцэтгэх ажлын онцлогт тохирсон үүрэг даалгавар, ажиллах заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
 - Тавьж өгсөн ажлын хувцас, гутлыг бүрэн өмсөнө;
 - Өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэхдээ ажлыг аюулгүй гүйцэтгэх арга барилтай танилцаж, тухайн ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг сайн мэдсэн байна.
8. Үүрэг даалгавар авсны дараа цахилгаан монтер шаардлагатай тохиолдолд дараах зүйлсийг хийх үүрэгтэй:
 - Хувийн хамгаалалтын шаардлагатай хэрэгслүүдийг бэлтгэж, тэдгээрийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг шалгана;
 - Ажлын байр болон түүн рүү орох хэсгүүдийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэхийг шалгана;
 - Ажилд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цуглуулж, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагаа, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан эсэхийг шалгана;
 - Кемпийг цахилгаанаар хангах бүдүүвч, түүний өөрчлөлт болон үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр дэх тэмдэглэлтэй танилцана.
9. Цахилгаанчин аюулгүй байдлын дараах шаардлагууд зөрчигдсөн тохиолдолд ажил гүйцэтгэхийг хориглоно:
 - Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ажиллагаанд ямар нэг зөрчил дутагдал, дефект үүссэн тохиолдолд,
 - Үндсэн болон туслах хамгаалах хэрэгслүүд ээлжит үзлэг, шинэчлэлдээ ороогүй буюу ашиглалтын хугацаа дууссан тохиолдолд,
 - Ажлын байрны гэрэлтүүлэг хангалтгүй, эсвэл эмх цэгцгүй байхад,
 - Цахилгаан хэрэгслүүдийн ажиллах хугацаа дууссан буюу хугацаа нь тодорхойгүй тохиолдолд.

Аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчсөн эдгээр зөрчлүүдийг ажил эхлэхийн өмнө цахилгаанчин өөрөө арилгахыг эрмэлзэх ба боломжгүй нөхцөлд даамал, эсвэл ажлыг удирдаж буй хүндээ мэдэгдэж зөрчлийг арилгуулах үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

10. Цахилгаанчин аюулгүй байдлын дараах шаардлагуудыг биелүүлэн ажиллах үүрэгтэй:
 - Шаардлагатай зүйлсийг унтрааж, цахилгааны аппарат өөрөө асах, хүний алдаанаас үүдэн ажлын байран дахь цахилгааны хүчдэл нэмэгдэх, улмаар гал гарах, хүн гэмтэх гэх зэргийн аюул осол гарахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг авах;
 - Цахилгаан гүйдэлтэй хэсгүүдэд газардуулга хийх;
 - Ажлын байрны эд хогшлыг хамгаалсан хязгаарлалт хийж, урьдчилан сэргийлэх плакатуудыг өлгөсөн байх;
 - Ажил явагдаж буй газар, эсвэл ажил гүйцэтгэх үеэр ашиглагдах тогтой цахилгаан гүйдлүүдийг цахилгаан аппаратын тусламжтайгаар, эсвэл гал хамгаалагчаар унтраах боломжийг бүрдүүлсэн байх;
 - Зөөврийн газардуулга хэрэглэхгүйгээр ажил гүйцэтгэх үед гарч болох алдаанаас үүдэн тогны хэлбэлзэл ихсэх, хүчдэл нэмэгдэх боломжийг хязгаарласан нэмэлт арга хэмжээнүүдийг авах;
 - Унтраалга, залгуур болон бусад асаах хэсгүүд дээр “Асааж болохгүй – хүмүүс ажиллаж байна!” гэсэн плакат нааж, урьдчилан анхааруулах;
 - Зөөврийн буюу түр хязгаарлалт тавьсан хэсгүүд дээр урьдчилан анхааруулах зураг буюу “Зогс – амь насанд аюултай!” гэсэн плакат хадах;
 - Тогны гүйдэл зогссон эсэхийг шалгахдаа цахилгааны хамгаалалттай бээлий өмссөн байх;
 - Зөөврийн газардуулгын хавчаарыг цахилгааны хамгаалалттай бээлий өмсч, газардуулсан цахилгаан гүйдэлтэй хэсэгт тусгаарлагч штангийн тусламжтайгаар тавина;
 - Цахилгаан гүйдэл дамжиж байгаа хэсгүүдэд ажил гүйцэтгэхдээ заавал хуурай, цэвэр тусгаарлагч хэрэгсэл хэрэглэх ба тусгаарлагч хэрэгслүүдийг гараар барьж байгаа үедээ хязгаарлагч кольцоноос цааш оруулахгүй барих хэрэгтэй.
11. Хамгаалагчийн хавчаарыг рубликтай үед солихдоо хүчдэлийг таслана.
12. Хүчдэлтэй байгаа хамгаалагчийн хавчаарыг солихдоо цахилгаанчин хамгаалалтын нүдний шил, цахилгааны хамгаалалттай бээлий өмсч, тусгаарлагч хэрэглэнэ.
13. Цахилгаан-техникийн бус мэргэжлийн ажилтны захиалгаар түр салгасан төхөөрөмжийг асаахын өмнө төхөөрөмжийг хүчдэлд залгахад бэлэн эсэхийг үзэж шалгаад, түүн дээр ажиллах ажилчдад төхөөрөмжийг асаах гэж байгаагаа урьдчилан анхааруулна.
14. Гүйдэлтэй цахилгаан шугамыг салгахыг шаарддаг зөөврийн багажийг залгах буюу салгахад хүчдэлийг бүрэн тасалсан байх шаардлагатай.

15. Цахилгааны шон дээр ажиллахдаа авирах дөрөө болон хамгаалалтын бүс хэрэглэнэ.
16. Ажлыг тэсэрч дэлбэрэх аюултай объект дээр гүйцэтгэхэд цахилгаанчинд дараах зүйлсийг хориглоно:
 - Хүчдэлтэй байгаа цахилгаан төхөөрөмж болон утас, сүлжээг засах;
 - Хамгаалалтын газардуулгыг зөв хийгээгүй цахилгаан төхөөрөмжийг ашиглах;
 - Автоматаар салгагддаг төхөөрөмжийг шалгаад эвдрэл шарсан бол шалтгааныг нь тодорхойлж, засахгүйгээр асаах;
 - Байшин, барилга, тамбурыг шатааж болох гадны хүчин зүйлээс тусгаарласан хаалга, үүдийг нээлттэй орхих;
 - Хамгаалалттай гэрлийн чийдэн шатсан тохиолдолд өөр төрлийн, эсвэл өндөр хүчин чадалтай чийдэн сольж хийх;
 - Цахилгаан төхөөрөмжийг тогны хэлбэлзэлтэй үед цахилгаан шугамыг автоматаар унтраадаг аппаратгүй үед асаах;
 - Цахилгаан төхөөрөмжийн хамгаалалтыг (гал хамгаалагч, автомат салгагч) тухайн төхөөрөмжид тохирохгүй өөр төрлийн, өөр номиналь параметртэй хамгаалалтаар солих.
17. Цахилгаан төхөөрөмж дээр ажиллахдаа эвдрэлгүй, хэвийн ажиллаж байгаа цахилгааны хамгаалалтын үндсэн (тусгаарлагч штанг, тусгаарлагч болон цахилгаан гүйдэл хэмжигч бахь, хүчдэл заагч, цахилгааны хамгаалалттай бээлий) болон туслах (цахилгааны хамгаалалттай түрийтэй гутал, коврик, хамгаалах төхөөрөмжүүд, аюулгүй ажиллагааны плакат, тэмдгүүд) хэрэгслийг хамтад нь хэрэглэх шаардлагатай.
18. Өндөр эрсдэлтэй, аюултай дараах нөхцөлд ажил гүйцэтгэж байгаа тохиолдолд дээрх арга хэмжээг давхар авна:
 - Газардуулгатай (шугамыг тусдаа цахилгаан хөдөлгүүрт залгах болон салгах, трансформаторт нийлүүлэх, хуваарилагч байгууламж дотор ажиллах) гүйж буй хүчдэлийг бүтнээр нь буюу хэсэгчлэн салгах;
 - Газардуулга шаарддаггүй (цахилгаан шалгах, хэмжих, хамгаалагчийн хавчуурга гм) хүчдэлийг салгаагүй үед;
 - Залгамал шат, гүүр хэрэглэж байгаа үед;
 - Цахилгаан гүйдлийн агаарын шугам дээр ажиллах үед.
19. Тусгаарлагчийн эсэргүүцлийг мегаомметрээр хэмжих ажлыг цахилгаан төхөөрөмжийг бүрэн зогсоосон үед л хийнэ. Хэмжихийн өмнө туршилтын төхөөрөмжид хүчдэл гүйхгүй байгаа эсэхийг нягтална.
20. Ойр орчимд кран болон цахилгаанаар ажилладаг машин ажиллаж байгаа тохиолдолд дараах шаардлагуудыг хангах шаардлагатай:

- Шугамын тогийг салгаж, санаандгүй байдлаар эсвэл хүний алдаанаас болж түүнийг асахгүй байх арга хэмжээг авах;
 - Цахилгааны шугамыг газардуулах ба хооронд нв ойртуулах;
 - Хүчдэлийг салгах боломжгүй тохиолдолд шугамын огтлолцсон хэсгийг тусгаарлах материалаар (резинэн коврик, модон щит) хязгаарлах. Хязгаарлалтан дээр “Амь насанд аюултай – 380 В хүчдэл!” гэсэн плакат өлгөнө.
21. Гэрлийн шугамд засвар үйлчилгээ хийхдээ цахилгаанчин дараах шаардлагыг биелүүлэх үүрэгтэй:
- Гал хамгаалагч болон шатсан чийдэнг шинээр сольж, гэрлийн цахилгааны монтажийг засварлах ажлыг хүчдэлийг тасалсан үед, хоногийн гэрэлтэй цагуудад хийнэ;
 - Тулгуур буюу шон дээр бэхлэгдсэн цахилгааны төхөөрөмжийг цэвэрлэх буюу чийдэнг солихдоо хүчдэлийг тасалсан байх ба өөр цахилгаанчинтай хамт гүйцэтгэнэ;
 - Хэмжилтийн трансформаторт залгасан цахилгаан счетчикийг шалгах болон суурилуулахдаа аюулгүй ажиллагааны өндөр мэдлэгтэй, 4-р зэрэгтэй цахилгаанчинтай хамт хоёул ажиллана;
 - Цамхагийн гэрэлтүүлгийг засах, үйлчилгээ хийхдээ хамгаалалтын бүс болон цахилгааны хамгаалалттай бээлий хэрэглэнэ.
22. Унтраалга болон түүний утаснуудыг салгахдаа дамжуулгыг гадны хүн асаах, эсвэл өөрсдөө асахаас сэргийлсэн урьдчилсан арга хэмжээ авна.
23. Тосон унтраалгын ажиллагааг шалгах, гэрэлтүүлэх зэрэгт цахилгаанчин 12 В-оос илүүгүй хүчдэлтэй цахилгаан ашиглана.
24. Ажил гүйцэтгэх үед цахилгаанчинд дараах зүйлсийг хориглоно:
- Түр зуурын хязгаарлалтыг өөрчлөн тавих, плакатыг хуулж авах, газардуулгыг авах, хамгаалалттай хэсэгт нэвтэр орох;
 - Хүчдэлийг тасалсаны дараа ахин шалгалгүйгээр ажиллах;
 - Цахилгаан хөдөлгүүр ажиллаж байх үед ороомгийн хязгаарлагчийн авах;
 - Газардуулга хийхийн тулд зориулалтын бус дамжуулагч хэрэглэх, түүнчлэн дамжуулагчийг эрчлэн ороох замаар газардуулга хийх;
 - Амперметртай тог хэмжигч бахь хэрэглэх, тог хэмжигч бахьтай ажиллаж байхдаа амперметр үзүүлэлт хэмжиж байх үед дээрээс нь тонгойх;
 - Хэмжилтийн үед багаж хэрэгсэл, эсэргүүцэл, утас, дамжуулагч болон хэмжигч трансформаторт хүрэх;
 - Шатан дээрээс агаарын шугамд хэмжилт хийх;
 - Цахилгаан төхөөрөмжид засвар, үйлчилгээ хийж байх үед төмөр шат хэрэглэх;

- Хүчдэлтэй газар ажиллаж байх үедээ хутга, хуурай, төмөр метр гэх зэргийг хэрэглэх;
- Хүчдэлийг бууруулахын тулд автотрансформатор хэрэглэх;
- Зөөврийн гар чийдэнгийн зориулалтаар байнгын гэрэлтүүлэг хэрэглэх.

25. Цахилгаанчин өндөрт гарах, буухдаа гарахдаа шат, тавцан ашиглах шаардлагатай. Өндөрт ажиллах үед хамгаалалтын бүс хэрэглэнэ.

Ослын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

26. Цахилгаан төхөөрөмж шатсан, цахилгаан кабел (дамжуулагч)-ийн утас тасарсан, утасны үзүүрүүд нь нийлсэн зэргээс үүдэн ойр орчмын цахилгаан утаснууд масалж, гал гарч эхэлбэл төхөөрөмжийг унтрааж, гал унтраах ажилд оролцох ба даамал болон ажлыг удирдаж буй хүндээ мэдээлэх шаардлагатай. Галыг нүүрс хүчлийн хий, эсгий бүтээлэг юм уу элс, шороогоор унтраана.

Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны шаардлагууд

27. Ажил дуусах үед цахилгаанчин дараах үүрэгтэй:

- Ээлж солилцож буй хүндээ хэрэглэж буй багаж, тоног төхөөрөмж, цахилгааны утас, сүлжээг бүрэн бүтэн хүлээлгэн өгч, үйл ажиллагааны бүртгэлд гарын үсэг зуралцана;
- Ажлын байранд ажиллахад зориулан байгууллагаас олгосон багаж хэрэгсэл, хувийн хамгаалалтын зүйлсийг хурааж, зориулалтын газар хадгалан үлдээнэ;
- Ажлын байрыг эмх цэгцтэй үлдээнэ;
- Гал гарсан, үнс цог үлдсэн, оч үсэрсэн гэх мэт гал гарах аюултай газрууд байгаа эсэхийг шалгана;

28. Удирдах ажилтандаа аюулгүй ажиллагааны шаардлагуудыг зөрчсөн бүх тохиолдол, хөдөлмөрийн зөрчил, осолд дөхсөн тохиолдлуудын талаар мэдээлэл өгнө.